



МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ

Цуврал 1

МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН  
ФИЛОСОФИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

А.ЦАНЖИД

МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН  
ФИЛОСОФИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Улаанбаатар хот  
2023 он



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ

---

Цуврал 1

А.ЦАНЖИД

## МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Улаанбаатар хот  
2023 он

ННА 74  
ДАА 370  
Ц-191

А.Цанжид

**МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД**

Зохиогч                      А.Цанжид  
Редактор                     М.Итгэл

Хэвлэлийн хуудас:        5.5хх  
Хэвлэсэн хувь:            500ш  
Хэвлэсэн газар:          Гоо Дизайн ХХК

ISBN 978-9919-9004-5-8

## ГАРЧИГ

<b>Бүлэг 1. БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ САНАА</b> .....	7
<b>Бүлэг 2. ТАЙЛБАР-ТЭМДЭГЛЭЛ</b> .....	14
2.1 Монголын боловсролын зорилго .....	17
2.2 Боловсролын үйл явцад оролцогчид .....	26
2.3 Сургалт-хүмүүжил нэгдмэл байх нь .....	32
2.4 Боловсролын агуулга, үйл явцыг зорилготой нийцүүлэн зохиомжлох нь .....	32
2.5 Соёл, үнэлэмжийн нэгдмэл байдал .....	36
2.6 Орчин үеийн боловсролын системийн шинжийг бүрдүүлэх нь .....	39
2.7 Боловсролын дэд бүтэц .....	40
2.8 Боловсролын үнэлгээг чанаржуулах нь .....	41
2.9 Сурган хүмүүжүүлэх монгол уламжлалаас суралцах нь .....	42
<b>Бүлэг 3. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛАМЖЛАЛ</b> .....	43
<b>Бүлэг 4. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН НОМЛОЛ</b> .....	67
<b>Бүлэг 5. ДЭЛХИЙН ЗАРИМ УЛСУУДЫН БОЛОВСРОЛЫН     ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОГ</b> .....	78

## ӨМНӨХ ҮГ

“Философи” гэдэг нэр томъёо нь эртний Грект “цэцэн мэргэнийг эрхэмлэх” гэсэн санааг илэрхийлсэн үг ажээ. Анхны философи сургаалууд 3000 жилийн өмнө олон улсад зэрэг үүссэн гэх бөгөөд философи мэдлэгээ бичгийн дурсгал хэвээр авч үлдсэн нь Энэтхэг, Хятад, Грек, Египет, Вавилон, Ром зэрэг улс байна. Тухайлбал, эртний Грекийн философич Платон “философи бол анхдагч эхлэлүүдийг болон шалтгаануудыг судалдаг шинжлэх ухаан байх ёстой” гэсэн. Зарим судлаачид эдгээр сургаалыг өрнийн болон дорнын философи гэж ангилаад энэ хоёр нь соёл иргэншлийн үүднээс авч үзвэл аль аль нь өөртөө нэгдэл, тэмцлийг агуулж байдаг боловч дорнын философид “нэгдэл”, өрнийнхөнд “тэмцэл” давамгайлж хөгжлийн хүч болдог гэж үздэг байна. Тэгвэл манай судлаачид “Монголын философи” гэсэн ойлголтыг Монголчуудын философи сэтгэлгээ анх үүссэн буюу Монголын тулгар төр үүссэнтэй холбон тайлбарладаг.

Орчин үед философи нь аль нэг урсгалаас үл хамааран философийн түвшний үнэлэмжийн шинжээ хадгалан салбарлан хөгжих боллоо. Түүний нэг салбар нь “Боловсролын философи” юм. Боловсролын салбарт хуримтлагдсан асуудлууд, тэдгээрийг шийдэх арга замыг эрж хайх нь “Боловсрол” гэх ойлголтын философи үндэслэлийг шаардсан хэрэг билээ. Боловсролын ерөнхий дүр төрх, үнэлэмж, боловсролтой хүн гэх асуудлуудыг аль ч цаг хугацааны хувьд тавьж болох ч “Боловсролын философи” бие даасан салбар нь XX зууны дунд үеэс эхлэн хөгжиж ирсэн байна. Манай улсын хувьд энэ салбар нь XXI зуунд илүү яригдаж хөгжиж ирсэн гэж үзэх талтай. Тухайлбал, 2001 онд Ц.Бүжидмаа “Монголын боловсролын философийн хөгжлийн судалгаа” сэдвээр докторын зэрэг хамгаалсан нь манай улсын боловсролын философийн анхдагч судалгааны томоохон бүтээл гэж хэлж болно.

Тэгвэл өнөөдрийн нийгэм эрчимтэй хөгжиж, улам нарийн төвөгтэй нөхцөл үүсгэж байгааг VUCA (volatility, uncertainty, complexity, ambiguity) буюу тогтворгүй, тодорхойгүй, эдрээтэй, олон санаа агуулсан байдалтай гэж тодорхойлж байна. Иймд бидний өмнө ирээдүйгээ төсөөлөх, таамаглах асуудал тавигдаж

буйд ирээдүй үргэлж өөрчлөгдөж байгаа нь бидний үйлдлийн үр дагавар гэсэн үзлээр хандах боллоо.

Боловсролыг хүний жам ёсны эрх, улс орон оршин байхын үндэс гэсэн томъёоллоор авч үзэж байна. Үүнтэй уялдуулан олон улсын нэр хүндтэй байгууллагууд боловсролын асуудлыг байнга хэлэлцэж, багагүй бүтээл гаргаж байна. Тухайлбал, 2020 оноос хойш НҮБ, ЮНЕСКО, ЭЗХАХБ, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон улсын байгууллагаас “Transforming Education” хэлэлцүүлэг, “Боловсролын ирээдүйг бүтээх нь”, “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ”, “Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал дахь боловсролын ирээдүйг тодорхойлох шинэ загварын сургуулиуд” зэрэг судалгааны болон бодлогын баримт бичгийг боловсруулан хэлэлцүүлэг хийв.

Мөн дэлхийн улсууд өөрийн орны боловсролыг хэрхэн хувирган өөрчлөх, хөгжүүлэхэд даяарчлалын (global) эсвэл дангаарчлалын (local) гэсэн дагнасан хандлагаас илүүтэй тэдгээрийн холимог буюу даяарчлалын хандлагатай дангаарчлалын онцлогтой (glocal) хөгжлийг илүүд үзэх болж байна.

Ялангуяа өнө эртний арвин түүхтэй Монгол улсын хувьд боловсролоо үндэсний онцлогтойгоор хэрхэн хөгжүүлэх вэ? гэсэн философи асуулт гарна. Өөрөөр хэлбэл, боловсролд чухал гэх мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйл ирээдүйд хэрхэн өөрчлөгдөхийг эргэцүүлэх цаг болжээ. Үүний тулд “Монголын боловсролын философи” талбарт монголын боловсролын төлөө санаа тавигч хүн бүр оюунаа уралдуулж, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, мэтгэлцэх, хэлэлцэх, бүтээл туурвих зэрэг чөлөөт сэтгэлгээний олон хэлбэрүүдээр хөгжүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Иймд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс Монголын боловсролыг хөгжүүлэхэд оруулах хувь нэмэр болгож, тодруулбал, бидний оюун санааны санд:

- юу байна вэ? цаашид юуг нь хөгжүүлэх хийгээд юуг нь орхих вэ?
- юу байхгүй байна вэ? түүнийг хэрхэн бүтээж, хөгжүүлэх вэ?

гэсэн ерөнхий асуултад хариу өгөх, санал болгох, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх зорилго бүхий “Монголын боловсролын философи” цувралыг эрхлэн гаргахаар болов.

Мөн Боловсрол, Шинжлэх Ухааны сайд Л.Энх-Амгалан “Монголын боловсролын философи”-ийг хөгжүүлэх талаар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Монгол улсын их сургууль, Философийн хүрээлэн зэрэг байгууллагуудын удирдлагатай уулзахдаа гол сэдэв болгон олон удаагийн ярилцлага, чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлж, идэвх санаачилгатай ажиллахыг цохон анхааруулж байсан юм.

Энэ цувралын салхийг хагалж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд асан (2000-2004), шинжлэх ухааны доктор А.Цанжидын бүтээлийг хэвлүүлж байна. Бид цаашид цувралыг чөлөөт хэлэлцүүлэгт тулгуурлан туурвихаар төлөвлөж байна.

Дэлхий дахинд “боловсрол” нь

- Их туршлага хуримтлуулах (XX зуунаас өмнө),
- Их юм мэдэх (XX зуунд),
- Хүн байх (XXI зуунд)

гэсэн хандлагатайгаар хөгжиж байна гэсэн ерөнхий дүр төрх ажиглагдаж байна. Тэгвэл, Монголчуудын сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнд бүрэлдэн тогтсон

- “хүн”-ий тухай ойлголт болох “хүн болоорой (эрдэмтэй, ухаантай, сайн, аав ээждээ ачлалтай...)” гэсэн ерөөлийн үг,
- “хүнээр хүн хийх ухаан” сурган хүмүүжүүлэх үйл явц,
- “Монгол хүн байна даа” гэсэн үнэлэмж нь

орчин үеийн боловсролын хайж байгаа философитой давхцаж байна гэж үзэж байна. Энэ нь цаашид бид хэрхэн хөгжүүлэх вэ? гэсэн асуудлын нэг шийдэл байж болох талтай.

Монголын боловсролын философи цувралын  
Алтан гадас нь – “Маргааш”-ийн боловсрол,  
Луужин нь – Монгол сэтгэлгээ байх болно.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн  
захирал М.ИТГЭЛ /Ph.D/

## БҮЛЭГ 1

### БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ САНАА

Боловсролын философи нь хавсарга шинжтэй бөгөөд нийгмийн өөрчлөлттэй холбоотойгоор залуу үеэ амьдралд хэрхэн бэлтгэх вэ? гэсэн асуулт гарах бүрд шинэ чиглэлүүд гарсаар байдаг. Тийм учраас боловсролын философийн чиглэлүүдэд хандахдаа тэдгээрийн урган гарсан нийгмийн хөрс, түүнд гарч байсан өөрчлөлттэй холбон үзэх нь чухал байдаг байна. Европ, Америкт буй болсон чиглэлүүд нь ХХ зуунд тэдгээр бүс нутгийн улс орнуудад буй болсон нөхцөл байдалтай ихээхэн холбоотой юм.

Боловсрол гэдэг нэр томъёо нь улс орон, соёлын онцлогийг шингээсэн байдаг бололтой. Орос хэлээр “образование” гэдэг нь ямар нэг юманд дүрс хэлбэр оруулах гэсэн санаатай бөгөөд “Образ” буюу зураг, дүрслэл гэсэн утгатай үгнээс үүсэлтэй ажээ. Ойлголтыг тэмдэглэж буй үгийн гарал, анхны утгыг хөөцөлдөх нь тэдгээрт тухайн ард түмний олон жилээр хурааж хуримтлуулсан ажиглалтын үр дүн шингэсэн байдагт оршино. Герман хэлээр боловсрол гэхийг мөн л зураг, дүрс, хуулбар гэсэн агуулгатай “Bildung” хэмээн хэлдэг байна. Харин Европын олон хэлээр education, Éducation, Formazione scolastica, Educación гэж хэлдэг нь латин хэлний educere = ex+care хэмээх “гарган авах” (“to bring up, rear) гэсэн утгатай үгнээс гаралтай гэж үздэг байна.

Харин монгол хэлний боловсрол хэмээх нэр томъёо нь “болгох” буюу ямар нэг түүхий зүйлийг болгох өөр болгох, гэсэн утгатай. Монголчуудын сурч боловсорч ирсэн түүхэн туршлага, түүнийг шингээсэн нэр томъёог хөөн үзэх юм бол “боловсрол” хэмээх нэр томъёо хожуу хэрэглэгдэх болсон байна. Хорин нэгтийн тайлбар тольд “боловсрохуй” хэмээх үг байгаа боловч “боловсрол” хэмээх нэр томъёо алга байна. Энэ нь монголчууд “боловсрол” хэмээхээс өмнө өөр үг хэрэглэж байсантай холбоотой байж болох юм. Монголын нууц товчоонд Таргутаг Хирилтуг Ширээт өвгөн болон түүний хүүхдүүдэд баригдаад явж байхдаа хүүхдүүддээ

“Ширээт намайг алан буюу. Алан барваас үхсэн, амин үгүй биеийг минь авч одож юу хийх, та нар. Намайг алаагүйд түргэн харигтун. Тэмүжин намайг үл алах. Тэмүжинийг өчүүхэн цагт нүдэндээ галт, нүүрэндээ гэрэлт бүлгээ хэмээн, эзэнгүй нутагт хоцорч амуу хэмээн, авахаар одож авч ирж сургаваас сурах мэт буюу хэмээн, сонин үрээ даага сургах мэт сурган соён явлаа” (МНТ, 149 дүгээр зүйл) хашгиран хэлсэн байдаг. Үүнээс үзвэл энэхүү “сурган соёх” гэдэг нэр томьёо нэлээд эртнийх бололтой. Харин 1743 онд зохиогдсон Хорин нэгтийн тайлбар тольд “соёл” гэдэг үгийг тайлбарлахдаа галын халуунаар хатууг зөөлрүүлэх мэт “эрдмээр эгэл мэдлийг гэгээрүүлэхийг соёл” хэмээмэй гэжээ. Боловсрол гэдэг үг байхгүй, харин соёл гэдгийг ийнхүү тайлбарласан нь эл хоёр ойлголтыг “соёл” гэдэг нэр томьёогоор илэрхийлж иржээ гэсэн сэтгэгдэл төрүүлж байгаа болно. “Сурган соёх” гэдэг чухамхүү монгол ахуйгаас үүсэлтэй ойлголт юм. Хожим бурхны шашин өргөн дэлгэрсэнтэй холбоотойгоор “гэгээрэл”, “гэгээрэх” гэсэн нэр томьёо хэрэглэгдэх болжээ. Яг хэдийгээс хэрэглэж эхэлснийг хэлэхэд төвөгтэй боловч хожим “хүмүүжүүлэх”, “хүнээр хүн хийх”, “хүмүүжих” гэсэн нэр томьёог “боловсрол” гэдэг утгаар хэрэглэж байсан аж. Тухайлбал, “Хүмүүн төрлөхтөн” гэдэг дуунд “Хөөрхий биднийг бүсгүйчүүд хүмүүжихийн замд орлоо” хэмээн дуулж байсан нь чухамхүү соёл, боловсролтой болох боломжтой боллоо гэсэн агуулгатай хэмээн ухаж болох юм. Ийнхүү “сурган соёх”, “эрдмээр гэгээрэх”, “хүмүүжих” гэсэн ойлголтууд цаг хугацааны хувьд дэс дараатай хэрэглэгдэж ирсэн мэт ажиглагдаж байгаа юм. Хэрвээ ийм таамаглалыг зөв гэж үзэх юм бол боловсрох үйл явцын тухай монголчуудын ойлголт энгийнээс нарийн руу шилжин өөрчлөгдөж ирсэн байна. Сургах, соёх гэдгээс хүүхэд залуусыг хүн болгох гэдэгт шилжсэн нь гүн гүнзгий утгатай юм. “Хүмүүжих” гэдэг ойлголт наанадаж XVII-XVIII зууны үед хэрэглэгдэж байсан бололтой байдаг. Хорин нэгтийн тайлбар тольд боловсрох үйлтэй холбоотой хэд хэдэн нэр томьёог тайлбарласан байдаг. Тухайлбал, “боловсормой” хэмээхийг “аливаа юмны хүмүүжиж сайжрахыг” хэлнэ хэмээн тайлбарласан байдаг. Түүнчлэн “боловсорч” гэдэг үгийг “бичгийн эрдэм сурлагыг сайтар тэмдэглэн цэгцэлж дадсаныг” хэлнэ хэмээжээ. Эндээс ажиглавал “боловсормой” хэмээх

нь боловсрох үйл явц бөгөөд “боловсорч” гэдэг нь түүний үр дүн гэмээр байгаа юм. Түүнчлэн соёлын тухай дээрх тодорхойлолтод байгаа “эрдэм, гэдэгт зөвхөн шашны эрдмийг хэлж байгаа бус гэдэг нь “бичгийн эрдэм” гэх мэт бичсэнээс харагдаж байгаа юм. ХХ зууны эхэн үеийн төрийн бичиг баримтад “эрдэмд боловсруулах”, “бичигт боловсруулах” гэх мэт үг хэллэг элбэг тохиолддог. Энэ бүхнээс үүтгэн “боловсрол” хэмээх нэр томъёо буй болжээ.

Аливаа зүйлд өөрчлөгдөж хувирч байдаг хэсэг байхад өөрчлөгдөхгүй хадгалагдаж, тухайн тэр зүйлийн мөн чанарыг хадгалж байдаг хэсэг бас байдаг билээ. Тийм учраас боловсролын тухай авч үзэхэд ч чухам аль нь өөрчлөгдөж, аль хэсэг нь хадгалагдаж ирснийг хөөн үзэх хэрэгтэй юм. Хүүхэд залуусаа амьдралд бэлтгэж эхэлсэн тэр цаг үеийг наанадаж ухаант хүн буй болсноос эхлэн тоолж болох бизээ. Хэдийгээр яагаад гэдэгт хариулахад бэрх боловч ургамлаас эхлэн амьтан, ухаант хүн хүртэлх бүхий л амьд организмын удирдлага болгодог үндсэн зарчим бол тухайн төрөл зүйл цаг хугацааны дотор хадгалагдан үлдэхийн төлөөх тэмүүлэл юм. Байгаль цаг уурын нөхцөл, дайсагнагч амьтдын хорлол гэх мэтэд дасан зохицож өөрийгөө хамгаалах арга олох, үр хөврөлөө тараан цацаж, тухайн төрөл зүйлийн амьдралыг цаашид үргэлжлүүлэх боломжтой болохын тулд зохицохуйн янз бүрийн аргыг олсон байдаг. Амьд байгалийн энэ хуулиас ухаант хүн ч бас гадуур оршоогүй билээ. Хүний дасан зохицохуйн арга нь түүний соёл юм. Соёлынхоо ачаар байгаль, нийгмийн орчинд дасан зохицохын зэрэгцээ тохиолдож буй бэрхшээлд хариу өгч, өөрчилж болох зүйлийг өөрчилж, болохгүйгээс нь өөрийгөө хамгаалж иржээ. Ухаант хүн нийгмээр амьдрах болсон нь дасан зохицохуйн чадварыг нь үлэмж нэмэгдүүлсэн юм. Балар эртний үеийг алгасаад түүхийн хуудсыг нэлээд нааш эргүүлэх юм бол хүний нийгэм оршин тогтнохын тулд хүүхэд, залуу үедээ өнгөрсөн үеийн туршлагыг эзэмшүүлж, аж төрөх чадвартай болгож ирсэн байна. Ийнхүү эзэмшүүлж байсан туршлагыг агуулгын хувьд гурван үндсэн хэсэг юмуу чиглэл болгож болно.

Нэгд, гэр бүл зохиож, үр удмаа үлдээх чадвар,

Хоёрт, амьдрал ахуйгаа авч явах чадвар (мал маллах, тариа тарих, ан хийх г.м.),

Гуравд, нийгмийн бусад гишүүдтэй харилцаж, нийгэм дотор амьдрах чадвар. Түүхийн урт удаан хугацаанд эдгээр чадварыг овгийн, гэр бүлийн ахмад гишүүд олгож чаддаг байжээ. Монгол хүүхдүүд л гэхэд бага балчир наснаас дүү нараа харах, хамгаалах арчлах гэх мэтээр нэг дэх чиглэлийн чадварыг, аяга даах наснаас эхлэн өөртөө тохирсон хөдөлмөр эрхэлж, ахмад хүмүүсээс суралцан хоёр дахь чиглэлийн чадварыг, эцэг, эх, ахмад хүмүүсийн сургаалыг сонсож, нутгийн ёс заншлыг дагаж зөв үйлдэл, ёс суртахууны мэдлэг мэдрэмжтэй болж гурав дахь дахь чиглэлийн чадварыг эзэмшиж, түүний ачаар улс, үндэстэн оршин тогтносоор ирсэн байна. Тэгэхдээ энэ гурамсан зорилт нэг нэгнээсээ салгуу биш, хамтдаа нэгэн зэрэг хэрэгждэг, гол хэрэгжүүлэгч нь гэр бүл байжээ. Гэр бүл зохиож, үр хүүхдээ өсгөх, аж амьдралынхаа гол эх сурвалж болох аж ахуйгаа хөтлөх мэдлэг чадварыг эзэмшээд нийгэмд бусад хүмүүстэй харилцан амьдрах чадвар эзэмшээгүй бол оршин байхад бэрхшээлтэй юмуу боломжгүй байхсан. Нөгөө хоёрын аль нэг нь дутвал бас л тийм болно. Тиймээс боловсрол нь анх үүсэхээсээ л эдгээр гурамсан чадварыг хүнд эзэмшүүлэх асуудлыг өөртөө багтааж иржээ. Хойч үеэ ийнхүү бэлтгэх нь ямар ч үндэстэнд байсан хэрэг юм. Гэвч түүхийн нэгэн цаг үед зарим зүйлийг түүнийг заахад зориуд мэргэшсэн хүнээр заалгахаас өөр аргагүй болсон байна. Энэ нь юуны өмнө бичиг үсэг байлаа. Чухам энэ үеэс л багшлах хэмээх үйл буй болж, боловсрол (хэдийгээр тэр үед ингэж нэрлэж байгаагүй боловч) хэмээх нийгмийн үзэгдэл гарч ирсэн байна. Энэ үеэс хүүхэд залуусыг амьдралд бэлтгэх үүргийн зарим хэсэг нь гэр бүлээс хальж, сүм хийд, сургуулийн үүрэг болон хувирч эхэлжээ. Өнгөрсөн үеийн туршлага, мэдээлийг хадгалагч нь зөвхөн ахмад хүмүүс байхаа больж, бичмэл мэдээлэл, орчин үед цахим мэдээллийн сан хөмрөг буй болсон байна. Хүүхэд, залуучуудын сурч мэдвэл зохих зүйл нь малчин, тариачин, гар урчуудын амиа аргацаасан аж ахуйн хэрэгцээнээс хальж, шинжлэх ухааны мэдлэг, түүнд суурилсан чадвар эзэмших шаардлагатай болжээ. Өрхийн аж амьдралын уг сурвалж байсан аж ахуйг хөтлөх мэдлэг чадварыг эзэмшиж үе залгамжлан түүнийгээ хөтөлдөг байсан нь мэргэжил эзэмшиж, өөр газар мэргэжлийн ажил хийх явдал болж хувирсан байна. Гэвч өрхийн аж ахуй хөтлөх мэдлэг

чадвар эзэмших, мэргэжил эзэмших хоёр нь мөн чанараараа хүнд амьдралаа залгуулах гэдэг утгаар мөн чанар нь ижил юм. Гэр бүл зохиож, үр хүүхэд төрүүлэн өсгөн бойжуулахад ч нийгмийн шинэ институтүүдийн үүрэг оролцоо нэмэгдсэн байна. Хүүхэд, залуучуудын хүмүүжилд гэр бүлээс гадна нэг ангийнхан, үе тэнгийнхэн, сурч судалж байгаа хичээлийн агуулга нөлөөлдөг байснаа, ХХ зуунд телевиз, орчин үед бас нийгмийн сүлжээ гэх мэт олон зүйл нөлөөлдөг болсон хэрэг юм. Хэдийгээр залуу үеийн сурч эзэмшвэл зохих мэдлэг, чадварын агуулга, арга хэрэгсэл, нөлөөлөгч субъект гэх мэт олон зүйл өөрчлөгдөж байгаа боловч хүүхэд, залуусыг амьдралд бэлтгэдэг анхны гурамсан зорилт одоогоор хувирч өөрчлөгдөөгүй, хадгалагдсаар байгаа ба цаашид ч нэлээд хугацаанд ач холбогдолтой хэвээр байна гэж үзэж болно. Хүүхдийг эсээр өсгөж төрүүлдэг, ухаалаг инкубаторт бойжуулдаг, мэдлэгийг ямар нэг аргаар тархинд шууд бичдэг гэх мэт олон шинэ зүйл гарч ирж болох бөгөөд цаашид ч гарч ирэх байх. Гэвч энэ бүхэн бол одоогоор таамаг төдий байна. Магадгүй хүн төрөлхтөн зарим зүйлээс ухамсартайгаар татгалзаж ч болох юм. Ирээдүйг харж философидох хэрэгтэй боловч хөрснөөсөө тасарч болохгүй. Багшгүйгээр боловсрол эзэмшдэг болж ч болох юм. Гэвч энэ нь төрийн ивээлд ямар нэг хэмжээгээр байдаг, зохион байгуулалттай өнөөгийн боловсролын тогтолцооны хүрээнд хамааралгүй зүйл.

Боловсролын талаарх философидолд хүн нийгэм хоёрыг салгаж, эсрэгцүүлэн тавих туйлшрал нэлээд байна. Эхлээд хөгжсөн хүн буй болоод нийгмээ хөгжүүлдэггүй, нөгөө талаас нийгэм хөгжсөн хойно хүн хөгждөггүй. Хүн нийгэм хоёр харилцан уялдаатайгаар зэрэг хөгжиж явдаг. Хүн нийгмээс гадуур хөгжихгүй, нийгэм хөгжсөн хүнгүйгээр бас хөгжихгүй. Тийм учраас боловсролын зорилго нь хүнийг хөгжүүлэхэд оршино гэх юмуу эсвэл хүнийг нийгмийг хөгжүүлэх гол хүчин (хэрэгсэл) болгох гэх мэтээр хоорондоо огт нийлэхгүй хоёр хувилбараар асуудлыг тавих нь хийсвэр сэтгэлгээний үр дүнгээр гарч ирсэн хиймэл зүйл юм. Төрөө засья гэвэл гэрээ зас, гэрээ засья гэвэл биеэ зас, биеэ засья гэвэл эрдэм сур гэсэн дорнын гүн ухааны үндэслэл нь чухамхүү хүн нийгмийн харилцааны дээр дурдсан зүй ёсыг илэрхийлж байгаа билээ.

Түүхэн хөгжлийн явцад хүний мэдлэг чадвар нь дээшилж, хөгжихийн хэрээр түүний өөрийнхөө өмнө болон нийгмийн өмнө хүлээх хариуцлага өсөж ирсэн юм. Хариуцлагын мэдрэмж бол хүний эрх чөлөөний салшгүй хэсэг юм. Хүний болон нийгмийн аль алиных нь хариуцлагын мэдрэмж нь тэдгээрийн харилцааны суурь нөхцөл юм.

Хүүхдийн хүмүүжил, эзэмшиж буй мэдлэг чадварт шууд болон шууд бусаар нөлөөлдөг хүчин зүйлс олон болж, заримдаа нөлөөлөгч, нөлөөнд орогч хоёрын аль аль нь ухамсарладаггүй, эмх замбараагүй байдал (хаос) нь өнөөгийн боловсролын онцлог шинж байж болох юм. Ийм тохиолдолд уг асуудлыг сайтар судлах шаардлага гарч байна. Нөгөө талаас суралцагчийн сурах сэдлийн тухай асуудлыг судлах хэрэгцээ их байна. Гадаадын судлаачид сурагчдын суралцах сэдэл багцаалбал найман насны үеэс эхлэн буурч арван зургаан нас хүртэл үргэлжилдэг гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг (Timo Gnambs, Barbara Hanfstingl, 2016). Энд дурдаж байгаа өгүүллийг зохиогчид өөр олон судлаачдын янз бүрийн цаг үед хийсэн судалгааг эшлэхийн хамт тэдгээрийн үр дүн ерөнхийдөө төстэй байсныг тэмдэглэжээ. Тэдний судалгаагаар Европт гучин жилийн туршид ийм хандлага үргэлжилж байгаа ажээ. Ийнхүү суралцах сэдэл буурч байгаагийн шалтгаан нь:

1. Сурагчид илүү бие даасан байдалтай байхыг хүсдэг.
2. Өөрөө чадна гэдэгт итгэлтэй байх.

3. Анги хамт олны дотор байр суурь эзэлж, түүнд хамаарах гэсэн сэтгэл зүйн шинжтэй гурван хэрэгцээтэй холбоотой ажээ. Өөрөөр хэлбэл, эдгээр хэрэгцээ хангагдахгүй байгаагаас сурах сэдэл буурч байгаа гэж үзжээ. Манай оронд суралцах сэдлийн тухай асуудал өөр хандлагатай, өөр шалтгаантай байхыг үгүйсгэж болохгүй боловч төстэй байх магадлал их бий юм. Хэрвээ тийм бол боловсрол нь суралцагчийг хөгжүүлэх зарчимд суурилах хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Судлаачдын суралцагчийн дурдсан хэрэгцээг сургуулийн амьдралд буулган хэлсэн жишээнүүдээс үзэхэд хичээл сонгох, багш тэднийг илүү бие даалгах байдлаар хичээлээ зохион байгуулах зэрэг нь бие даах хэрэгцээг, багш сурагчдад хэт хөнгөн биш, гэхдээ хэт хэцүү биш атлаа зохих хэмжээгээр өөрийгөө дайчилбал шийдвэрлэж чадахаар даалгавар өгөх зэрэг нь

өөртөө итгэлтэй байх хэрэгцээг хангах, улмаар суралцах сэдлийг нэмэгдүүлэх хандлагатай байдаг ажээ. Дашрамд тэмдэглэхэд суралцах үйлд багш сурагчийн аль алиных нь үүрэг их гэдгийг эл судалгаа харуулж байна.

Боловсролын “хаос” байдалтай байгаа орчин, хүчин зүйлст нөлөөлж хүн хөгжих, боловсрох таатай орчин бүрдүүлэх нь боловсролын салбар дахь төрийн үүрэг, бодлогын асуудал юм. Хүний хөгжлийг аль зүгт залах вэ гэдэг нь боловсролын зорилгод хамааралтай асуудал юм. Энэ нь улмаар улс орныхоо нийгмийн дүр төрхийг хэрхэн төсөөлж байна гэдэгтэй холбоотой. Болзмол байдлаар жишээ татах юм бол АНУ-ынх шиг (төстэй), Европ (тэр дундаа скандинав шиг)-ынх шиг эсвэл Японых шиг нийгэм байх уу гэх мэт. Эдгээр нь ардчилсан улсууд, гэвч хүн амын болон нийгмийн шинж чанар нь өөр. Ийм төсөөллүүдээс боловсролын нийгэм-хүмүүнлэгийн шинжтэй зорилго урган гарна. Боловсролын хэрэглээний чиглэлийн зорилго нь тухайлбал, Монголын нийгэм хэмээх макро системийн дотор болон түүний дэд системүүдийн өмнө боловсролын өнөө хүлээж буй үүргээр тодорхойлогдоно.

## БҮЛЭГ 2

### ТАЙЛБАР-ТЭМДЭГЛЭЛ

Энэхүү гарчгийг тавьсны дараа чухам юуны тухай бичих ёстой вэ гэдгийг тунгаан бодох хэрэгтэй болж байгаа юм. Эхний ээлжид боловсролын тухай философи, боловсрол олгох, боловсрох үйл явцад буй болдог философи асуудлын тухай байх гэж төсөөлмөөр байгаа юм. Ингэх нь боловсролын философи гэж юу болох вэ, түүний судлагдахуун, арга зүй, эцэст нь судлаад буй болгосон философи мэдлэг гэж механик физик, органик хими гэдэг шиг цэгцтэй цогц мэдлэг байна уу гэсэн асуулт ч бас урган гарч байгаа юм. Боловсролын философи үүсэн буй болсноос хойш маш их судалгаа хийж, олон урсгал чиглэл буй болсон боловч хараахан тийм цогц мэдлэг үгүй байна. Энэ талаар Станфордын философийн нэвтэрхий тольд бичсэнийг үзье. “Боловсролын философи нь боловсролын мөн чанар, зорилго, боловсролын онол, практикаас үүдэлтэй философийн асуудлуудтай холбоотой хэрэглээний болон практик философийн салбар юм. Энэхүү практик нь хүний нийгэмд түгээмэл байдаг, түүний нийгэм, хувь хүний илрэлүүд нь маш олон янз, нөлөө нь маш гүнзгий байдаг тул энэ сэдэв нь ёс зүй, нийгэм/улс төрийн философи, эпистемологи, метафизик, оюун санааны гүн ухаан, сэтгэхүйн философи, хэл, философийн бусад салбарууд зэрэг өргөн хүрээг хамардаг. Энэ нь дотогшоо эх ухаан руугаа (философи руугаа -А.Ц.), мөн гадагшаа боловсролын практик, нийгэм, хууль эрх зүй, институцийн нөхцөл байдал гэх мэтээр хоёуланг нь хардаг тул боловсролын философи нь уламжлалт онол/практикийн хуваагдлын хоёр талтай холбоотой байдаг. Түүний судлагдахуун нь философийн үндсэн асуудлууд (жишээ нь, заах ёстой үнэ цэнтэй мэдлэгийн мөн чанар, боловсролын тэгш байдал, шударга ёсны шинж чанар гэх мэт) болон боловсролын тодорхой бодлого, практикт хамаарах асуудлууд (жишээ нь, стандартчилсан сургалтын хөтөлбөр, шалгалтын зохистой байдал, санхүүжилтийн

тодорхой зохицуулалтын нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, ёс суртахууны хэмжүүр, сургалтын хөтөлбөрийн шийдвэрийн үндэслэл гэх мэт) байдаг” хэмээн тодорхойлсон байна (Philosophy of Education, 2008). “Боловсролын философи нь боловсролын зорилго, хэлбэр, арга, агуулгыг судлахыг хэлнэ. Түүнийг эдгээр сэдвийн гүн ухааны үндсэн дүн шинжилгээнд болон практик сурган хүмүүжүүлэх арга барилд дүн шинжилгээ хийхэд ашиглаж болно. Судлагдахуунд нь сургах ёстой үнэ цэнтэй мэдлэгийн мөн чанар, боловсролын шударга ёсны байдал зэрэг философийн үндсэн асуудлууд болон стандартчилсан тест, сургуулийн санхүүжилтийн нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, боловсролын практик бодлого гэх мэт практикт хамаарах асуудлууд багтана (“Top Hat”, 2023).

Тэгэхээр боловсролын философийг судална гэдэг бол маш өргөн хүрээтэй, цаг хугацаа их шаардсан дүн шинжилгээ хийх ажил байж таарна.

Гэвч нөгөө талаар “Монголын боловсролын философи” гэдэг нь ерөнхийдөө тус улсын боловсролын салбарыг хөгжүүлэх бодлогын тухай, түүний үндсэн зарчмуудын тухай асуудал хэмээн үзэж болно. Ийм тохиолдолд боловсролын философийн олон урсгал чиглэлийн ололт, дүгнэлт, боловсролын хөгжлийн талаар ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллагуудын баримт бичиг (тэдгээрт ч бас “философи” байгаа), боловсролын судалгааны салбарт өөрийн орны хуримтлуулсан мэдлэг, туршлагад үндэслэн “үндэсний боловсролын философи”-ийг боловсруулж болно. Үүнийг боловсролын үндэсний номлол гэвэл илүү зохимжтой ч байж болох юм. Номлол нь боловсролын философийн хүрээнд буй болсон мэдлэгийг санд түшиглэхийн зэрэгцээ Монгол Улсын хөгжлийн өнөөгийн болон ойрын ирээдүйн хэрэгцээг тусгана. Шинжлэх ухаан технологийн хөгжил, улсын хөгжил, боловсролтой хүний чадамжийн өөрчлөлт гэх мэт болон бусад шалтгааны улмаас номлол нь тодорхой хугацаатай байна. Өөрөөр хэлбэл, номлолд тогтмол байх үндсэн зарчим, бүтэц зэргээс гадна цаг үеийн шаардлагаар өөрчлөгддөг хэсэг байна гэсэн үг юм.

Боловсролын философийн олон урсгал чиглэл нь өнгөц харахад бие биетэйгээ эсрэг тэсрэг мэт боловч боловсрол хэмээх

нийгмийн үзэгдлийн олон талт байдлын илэрхийлэл бөгөөд судалгааны урсгал чиглэл бүр аль нэг талыг нь товойлгон үзсэн байдаг. Тийм учраас философийн аль нэг тодорхой загвар нь тэдгээрийг анхааралдаа авч, өвөрмөц зорилгодоо нийцүүлэн зүй зохистой хослуулахыг эрмэлздэг. Монголын боловсролын философи

г боловсруулахад арга зүйн хувьд энэхүү зарчмыг баримтлах нь зүйтэй юм.

Монголын боловсролын философи бол боловсролын философи хэмээх мэдлэгийн салбарын нэг тодорхой хэв маяг мөн. Монголчууд хэзээнээс нааш үр хүүхэд, залуу хойч үеэ сурган хүмүүжүүлж, амьдралд бэлтгэж ирсэн уламжлалтай, түүнийхээ философи үндэслэл нь болдог мэдлэг ухааны өв сантай байсан. Хүүхдэд нэгд, ажил хөдөлмөрийн буюу амьдрал ахуйгаа авч явах, хоёрт, бусадтай харилцан нийгмийн гишүүн байх, гуравд, гэр бүл зохион, үр хүүхдээ өсгөн сургаж, хүмүүжүүлэх гэсэн гурамсан мэдлэг, ур чадварыг эзэмшүүлдэг эрин зууныг туулан амьдралаар шалгагдсан боловсролын философитой байжээ хэмээн үзэж болно. Гэр бүл, нутаг нугынхан боловсролын эл системийн субъект байсан. Бурхны шашин нэвтрэн ирж монголчууд нийтээрээ шүтэх болсноор субъектийн тоо нэмэгдэж, 400 шахам жилийн хугацаанд монголын нөхцөлд зохицон, зонхилох байр суурийг эзлэх болсноор бурхны шашны философи, ардын гүн ухаанд суурилсан философи буй болжээ.

XX зууны эхэн үеэс иргэний боловсролын систем, соёл, гэгээрэл, үзэл суртлын байгууллагууд бий болсноор хүүхэд, залуучуудын боловсрол, хүмүүжилд хүчтэй нөлөө үзүүлдэг шинэ субъектүүд буй болжээ. Энэ нь хүүхдийг гэр бүлээс ямар нэг хэмжээгээр “холдуулж”, бусад тоглогчдын нөлөөг ихэсгэсэн байна. Магадгүй энэ үеэс “биеийг нь төрүүлснээс бус ухааныг нь төрүүлээгүй” хэмээх хэлц үг гарсан байх.

Орчин үед нийгмийн өөрчлөлт болсон хэдий ч боловсролын гэр бүлд түшиглэсэн уламжлалт хэв маяг улам бүр эвдрэн (XX зуунаас эхлэлтэй), шинэ хэв маяг түүний гүйцэтгэж ирсэн гурамсан үүргийг биелүүлж чадахгүй байна. Нийгмийн оюун санааны ертөнцөд зонхилох үзэл санаа байхгүй болж, “хаос” ноёрхох болов. Бурхны шашин, үндэсний үзэл, албан ёсны нийгэм,

хүмүүнлэгийн шинжлэх ухаан, гаднаас шургалан орж ирж буй үзэл суртлуудын аль нь ч гол нөлөөтэй байж чадахгүй байна. Энэхүү “хаос” тодорхой төлөвт орж тогтворжих эсвэл, нийгмийг задрал болоход хүргэх аюултай юм. Ийм нөхцөлд үндэсний боловсролын философийг боловсруулах нь зарчмын ач холбогдолтой юм.

Монгол Улсын төрөөс боловсролыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын зорилго нь:

- Улс орны түргэвчилсэн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын чанарыг сайжруулах;
- Үндэсний боловсролын философи/номлолыг буй болгон мөрдөх;
- Монгол хүний төрөлх чадварыг, авьяаслаг хүүхэд, залуучуудыг тасралтгүй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Залуу үеийн эх оронч, иргэнлэг байр суурийг бэхжүүлэх;
- Оюун санааны хүрээнд буй болсон хямралт байдлыг гэтлэн давж, ард түмний соёл, ёс суртахууны нэгдмэл байдлыг буй болгох;
- Боловсролын салбарын хоцрогдлыг богино хугацаанд арилгахын тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

## 2.1. Монголын боловсролын зорилго

Үндэсний боловсролын философийн үндсэн зарчим нь монгол боловсрол залуу үеийг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой гэдэг юм. 1974 онд “Ромын клуб”-ээс боловсруулсан “Боловсрол хязгааргүй” хэмээх илтгэлд боловсрол нь “хадгалах” болон “инновац”-ын гэсэн үндсэн хоёр хэв маягтай байх гэсэн ангиллыг санал болгосон билээ. Хадгалах хэв маягийн боловсрол нь түүхийн бүхий л хугацааны дотор буй болсон социаль туршлагыг залуу үед эзэмшүүлснээр тухайн үед оршин байгаа нийгмийг тэр янзаар нь нөхөн “үйлдвэрлэхэд” чиглэдэг бол хөгжүүлэх буюу инновацийн хэв маяг нь хүнийг хөгжүүлэх зорилгыг баримтлан нийгмийг тухайн үеийн нөхцөл байдалд зохицуулан цаашид оршин тогтнох чадварыг нь улам өсгөн нэмэгдүүлэхэд чиглэдэг. Нэг дэх хэв маяг зонхилж байгаа үед гэр бүл, төр, сүм хийдээс зориуд ялган авсан мэдлэгийг залуу үед дамжуулах зорилгыг агуулж байдаг.

Ийм системд сурган хүмүүжүүлэгч гол байрыг эзэлнэ. Харин хөгжүүлэх хэв маягтай боловсрол бол хүний хөгжлийн үе шат бүрд шаардагдах тэр агуулгыг сонгон эзэмшүүлэх-эзэмшихэд чиглэнэ. Тийм учраас боловсролын агуулга нь сурганы үндсэн хэрэгсэл, хөгжлийн хүчин зүйл болж байдаг.

Боловсролын тухай ярихын тулд эхлээд боловсрол гэж юу вэ, орчин үед боловсрол хэмээх ойлголтыг хэрхэн ойлгож байна вэ гэдэг нь чухал юм. Боловсролын тухай олон тодорхойлолт бий. Түүнийг нэг талаас хүнийг мэдлэг, чадвартай болгох үйл ажиллагаа, нөгөө талаас хүн суралцах явцдаа олж эзэмшдэг мэдлэг, чадвар, үнэлэмж, туршлагын цогц хэмээн агуулга талаас нь боловсрох үйл явцын үр дүн гэж ойлгодог. Тэдгээрээс гадна хүнд боловсрол олгох зорилго бүхий институцүүдийг “боловсрол” хэмээх ойлголтод багтаана. Боловсролын тухай янз бүрийн тодорхойлолтыг үзвэл эдгээрийн аль нэгийг нь онцолсон юм уу эсвэл бүгдийг нь тоочин багтаасан байх нь элбэг. Зарим жишээг авч үзье. Үүнд:

- Сургалт, хүмүүжүүлэх, хөгжүүлэх болон хүн өөрөө сурч, хүмүүжих үйл явц, түүний үр дүн (Педагогический глоссарий, 2023).
- Хувь хүн соёлын үнэт зүйлсийг эзэмших замаар хөгжих гадаад, дотоод нөхцөлийг бүрдүүлдэг нийгмийн амьдралын тусгай хүрээ (Педагогический глоссарий, 2023).
- Хүнийг хувь хүн, нийгэм, төр улсын сонирхолд нийцүүлэн хүмүүжүүлэх сургах, болон иргэн төрөөс тогтоосон боловсролын түвшнийг эзэмшсэн болохын нотлох зорилго чиглэл бүхий үйл явц (Гревцева, Циулина, 2014).
- education, discipline that is concerned with methods of teaching and learning in schools or school-like environments as opposed to various nonformal and informal means of socialization (e.g., rural development projects and education through parent-child relationships) (Britanica, 2023).
- Aristotle - Education is the process of training man to fulfill his aim by exercising all the faculties to the fullest extent as a member of society (Leverage Edu, 2021).

Энэ бүхнээс үзвэл Европ дахины сэтгэлгээнд боловсрол хэмээхийг эртний латины “хүмүүжүүлэх- upbringing, сургах-training” гэсэн агуулгатай “educationem” янз бүрийн хувилбартайгаар хадгалагдаж ирсэн бололтой. Тодорхойлолтуудын ялгаа нь сургах, хүмүүжүүлэх арга барил, сургалтын агуулга, түүний хэмжээ, сургагч суралцагч хоёрын харилцаа, боловсролд нийгмийн орчны үүрэг гэх мэтийг хэрхэн үзэж байгаад оршдог.

Боловсролын тухай хэзээ ямагт газар бүр тохирдог тодорхойлолт байж болохгүй. Уг ойлголт сургах, хүмүүжүүлэх гэсэн үндсэн санаагаа багтаахын зэрэгцээ үндэсний онцлог, цаг үе, нийгмийн хэрэгцээтэй уялдаж байх ёстой болов уу. Орос хэлний «образование» гэдэг нь “образ” - мóρφωσις юм уу пайдейя гэсэн үгнээс гаралтай бөгөөд энэ нь ямар нэг юманд тодорхой хэлбэр дүрс оруулах гэсэн агуулгатай гэж үздэг нь боловсролыг ойлгох үндэсний онцлог гэмээр байгаа юм. Харин дорно дахины боловсрол хэмээх ойлголтын агуулгыг Рабиндранат Тагорын “The highest education is that which does not merely give us information but makes our life in harmony with all existence” гэсэн санаа ерөнхийд нь илэрхийлж байна гэмээр. Энэ өгүүлбэр дорнын хүмүүсийн юмыг ерөнхийгөөс тусгай руу сэтгэдэг, ерөнхийд зохицож аж төрөх, ёс суртахууныг чухалчилдаг онцлогийг илэрхийлж байна.

Монгол Улсын оршин тогтнохуйн өнөөгийн нөхцөл байдлаас ургуулан бодвол боловсрол гэдэг бол тухайн нийгмийн соёл, хэрэгцээнд нийцсэн хүний хөгжлийн чиг зорилго бүхий хөгжлийн үйл явц хэмээн үзэж болох юм. Орчин үед ийм тодорхойлолтод хүний өөрийгөө хөгжүүлэх үйл явц гэж бас нэмэх болжээ. Гэвч бид энд албан ёсны боловсролын тогтолцооны хүрээнд хүн боловсрох тухай ярьж байгаа болохоор энэ хүрээнд л хүнийг хөгжүүлэх тухай ярина. Нийгмийн хэрэгцээ бол хоёр түвшинтэй. Үүнд:

- *Дэлхий дахины:* Энэхүү том нийгэмлэгийн гол хоёр хэрэгцээ бол нэгд: хүн төрөлхтөн бүх нийтийн сүйрэл дагуулах дайнгүй энх тайван орших, хоёрт: дэлхийн сав, шимийн ертөнцийг хамгаалах. Монголын боловсрол энэ хоёр хэрэгцээг зайлшгүй харгалзах ёстой.

- *Монголын нийгмийн хэрэгцээ*: Үүнийг улс орноо хөгжүүлж монголчуудын соёлоо хадгалан хамгаалж, хүн ардаа сайн сайхан байлгахын төлөө улс орноо хөгжүүлэх хэмээн ерөнхийд нь томъёолж болно.

Боловсрол олон талын нөлөө, хэмжүүртэй:

- Нийгмийн хэрэгцээг хангахын зэрэгцээ, шинэ хэрэгцээг буй болгодог,
- Хүний үйл ажиллагааны хэв загварыг төлөвшүүлдэг,
- Нийгмийн орчноос хүнд үзүүлдэг элдэв нөлөөлөлд үзүүлэх хариултын шинж чанарыг тодорхойлдог,
- Хүнд амьдралаа төлөвлөх, төлөвлөгөөгөө өөрчлөх боломж олгодог,
- Хүний зан төлөвийг төлөвшүүлж, бэхжүүлдэг зэргийг юуны өмнө дурдаж болно.

Тиймээс орчин үед боловсролыг нийгмийн амьдралын дан ганц социаль тал хэмээн үзэхээ больжээ. Жак Делорын боловсруулсан ЮНЕСКО-ийн илтгэлд боловсролыг эдийн засгийн нэг хэсэг хэмээн үзэх саналыг дэвшүүлжээ.

Боловсролыг зөвхөн нийгмийн асуудал талаас нь харах нь түүнд зориулан тухайн үед гаргаж буй санхүүжилтийг тооцох төдийгөөр хязгаарлагдаж байгаа ба төв, орон нутгийн төрийн байгууллагууд боловсролоос илүүтэй дэд бүтцэд хөрөнгө оруулахыг эрмэлзэж байна. Орон нутагт сургуульд хөрөнгө оруулахаас зам тавихыг илүүд үзэж байна.

Боловсролын шалгуур нь тухайн нийгэмд баримталдаг “боловсролтой хүн”-ний хийсвэр дүр зураг юм. Энэхүү тодорхойлолтод соёлгэдгийг өргөн утгаар нь авч үзэж байна. Энэхүү дүр зургийг баримтлан боловсролын зорилгыг тодорхойлдог гэсэн үг. Энэхүү дүр зураг тухайн цаг үеийнхээ онцлогийг тусган өөр өөр болж, хувирч өөрчлөгддөг. Орчин үед боловсролын чанарыг боловсролын систем дотроо бус, түүний гадны үнэлгээгээр хэмжих ёстой гэж үзэх болжээ. Хамгийн ерөнхий хэмжүүр бол макро түвшний улс орны эдийн засгийн чадавх, ард түмний амьдралын чанар, хүрээлэн буй орчны хамгаалалт, технологийн суурь гэх мэт бөгөөд эдгээр нь боловсролын чанар ямар байгааг харуулна. Нэгжийн түвшинд бол боловсролын чанар, үр дүн нь хүний цогц

чадамж (competency) хэмээн үзэх болжээ. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан дүр зургийг хүний цогц чадамж тодорхойлдог гэсэн үг юм. Энэхүү цогц чадамж бол мэдлэг, чадвар, дадлаас бүрдэнэ. Тэгэхээр Монгол Улсын боловсролын чанарыг (үр дүнг) боловсролтой хэмээн үзэгдэж буй хүний цогц чадамжаар үнэлж дүгнэх болно.

Хөгжүүлэх боловсролын агуулга нь түүний зорилгоор тодорхойлогдоно хэмээн үзэж болно. Тиймээс боловсролын хууль, бодлогын зорилго нь энэ шаардлагыг тусгаж байх ёстой. Зорилгыг юу тодорхойлох вэ? Үүнд хүний хөгжлийн хэрэгцээ хэмээн хариулж болно. Гэвч энэ бол маш ерөнхий хариулт болно. Зорилгод боловсролтой хүн ямар шинж чанартай байх вэ, өөрөөр хэлбэл Монгол улсын боловсролын шат шатны байгууллагыг дамжин суралцаж, ямар нэг шатны боловсролтой болсон хүн ямар байх вэ, эсвэл нөгөө талаас нь ямар монгол хүнийг бэлтгэх ёстой вэ гэдэг нь тусгалаа олсон байх хэрэгтэй. Энд нөгөөх л хүний цогц чадамжийн тухай яригдаж байна. Одоохондоо бид энэхүү цогц чадамжийг хэрхэн олох юм уу олгох тухай асуудлыг хөндөөгүй. Ерөнхийдөө суралцагчийн өөрийнх нь идэвх, хариуцлагыг онцолж байгаа өнөөгийн нөхцөлд цогц чадамжийг олгох тухай бус, хүн өөрөө цаг үедээ нийцсэн цогц чадамжтай болох боломжийг бүрдүүлэх тухай ярих хэрэгтэй байх.

Боловсролын зорилгыг тодорхойлоход түүний нийгэмд гүйцэтгэдэг үүргийг баримтлах хэрэгтэй болно. Хүнд мэдлэг олгож, ертөнцийн шинжлэх ухааны дүр зургийг ойлгуулах гэх мэтийн зөвхөн боловсролтой өөртэй нь холбоотой үүргүүд бий. Гэвч нөгөө талаар боловсрол бол нийгмийн амьдралын бусад салбартай нягт холбоотой. Учир нь боловсрол нь өөрөө бие даасан систем болохын зэрэгцээ төр-улс төр, нийгэм, эдийн засаг, оюун санааны гэх мэт том системүүдийн дэд систем юм. Дэд систем харьяалагдаж буй том системдээ ямар нэг чиг үүргийг гүйцэтгэж байдаг нь ойлгомжтой. Тэгэхгүйгээр дэд систем бус болж тэрхүү том системтэй ямар нэг холбоогүй болно.

Энэ бүхнийг харгалзан үзвэл Монголын боловсролын систем дээр дурдсан том системүүдийнхээ хүрээнд ямар ямар чиг үүргийг гүйцэтгэх вэ гэдгийг тодорхойлох ёстой. Их сургуулиуд эдгээр салбарын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай шинэ

мэдлэгийг буй болгож байдаг. Харин тэрхүү мэдлэгийг эзэмшин салбар тус бүрийг хөгжүүлэгч гол хүчин нь боловсрол, мэргэжилтэй хүн юм. Тэгэхдээ дээр дурдсан том системүүд өөрчлөгдөж, өөрчлөгдөхийн хэрээр боловсролтой хүнд тавих шаардлага буюу түүний цогц чадамжид тавигдах шаардлага өөрчлөгдөж байна. Практик зорилт талаас нь аваад үзвэл өнөөдөр Монголын нийгэм эдийн засаг, улс төр, оюуны санааны байдал, эерэг сөрөг тал нь юу байна, түүнийг өөрчлөх буюу хүсэн тэмүүлэх “шинэ” дүр төрх ямар байх ёстой вэ гэдгээр боловсролтой монгол хүний цогц чадамж, түүгээр боловсролын зорилго, зорилт тодорхойлогдоно хэмээн үзэж болох юм. Боловсролын зорилгыг, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлохдоо Монгол Улс бол хөгжиж байгаа орон, бүр тодорхой хэлбэл, хөгжлөөрөө хоцорч яваа орон гэдгийг харгалзах учиртай. Энэ нь зорилго илүү прагматик, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл ч бас түүнд нийцсэн байх ёстой гэсэн үг.

ЮНЕСКО-ийн санал болгож өнөөдөр дэлхий даяар баримталж байгаа боловсролын “дөрвөн багана (OECD, 1996)” бол боловсролтой хүний эзэмших чадамжийг тодорхойлж байгаа юм. Тэдгээрт мэдэхийн тулд суралцах (Learning to know), үйлдэхийн тулд суралцах (Learning to do), хамтран аж төрөхийн тулд суралцах (Learning to live together), оршин байхын тулд суралцах (Learning to be) гэсэн суралцахуйн зорилгыг чадамжаар илэрхийлсэн томъёолол багтдаг юм. Эдгээр чадамж өөр хоорондоо нягт уялдаатай. Суралцаад мэдлэг олсон бол түүнийгээ хэрэглэж чаддаг, хэрэглэхдээ нийгэмд тустай байж, амьдралаа утга төгөлдөр болгох ёстой. Сургалт, хүмүүжлийн үйл явц ч энэ уялдааг анхаарч, хангах учиртай. Европын Холбооны Зөвлөл суралцах хөдөлмөрлөхөд чухал ач холбогдолтой 5 цогц чадамжийг тодорхойлсон байдаг. Тэдгээрийн тоонд улс төрийн ба нийгмийн чадамж, олон соёл бүхий нийгэмд амьдрах чадамж, бичгийн болон аман нэвтрэлцэхүйн чадамж, нийгмийн мэдээлэлжилт нэмэгдэж буйтай холбоотой чадамж, амьдралынхаа туршид суралцах чадамж зэргийг оруулсан байна.

ЮНЕСКО-ийн тодорхойлсон чадамжууд нь нарийн бодож үзвэл аливаа ард түмний суралцахуйн уламжлалтай нь дүйж байгаа. Европын Холбооноос тодорхойлсон нь дээр дурдсан чадамжуудыг бүс нутгийн онцлогт нийцүүлэн нарийвчилсан хэрэг


байх. Монголын боловсролын философид эдгээрийг харгалзахын зэрэгцээ нийгмийн амьдралд боловсролын гүйцэтгэх ёстой үүргүүдийг тусгасан байх учиртай. Боловсролтой хүнээс эдийн засаг, нийгэм, улс төр, оюун санааны салбарын хөгжил ямар шинж чанартай, чадамжтай байхыг шаардаж буйг тодорхойлох хэрэгтэй. Тэгэхдээ XXI зууны хүн ийм байх учиртай гэх дэлхий дахины хандлагыг харгалзахын зэрэгцээ өөрийн орны өвөрмөц нөхцөлд нийцсэн чадамжуудыг тодорхойлох хэрэгтэй. Дахин сануулахад Монгол Улс хөгжиж буй орон, эдийн засгийн хувьд сул, аж үйлдвэр бага хөгжсөн, соёлын өөрчлөлт (хямрал) хүчтэй болж байгаа зэрэг онцлогтой байна. Нөгөө талаар монгол хүний чадвар өндөр. Гэвч уг чадварыг бага наснаас нь тасралтгүй хөгжүүлж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох насанд нь өндөр чадамжтай болгох үр нөлөө бүхий систем байхгүй байна. Дэлхий дахинд чухалчилж буй чадамжууд болон өөрийн орны нөхцөл байдал, хөгжлийн шаардлагаас урган гарч буй чадамжуудыг нэгтгэн илэрхийлсэн нь боловсролын (хуульд тусгах) зорилго бөгөөд, түүнийг задалж нарийвчилсан нь дэд зорилго юмуу зорилтууд болно. Боловсролын агуулга, хэлбэрийг шинэтгэх нь нэг талаас монголын ард түмний түүхэн ололт, соёлыг шингээх, нөгөө талаас орчин үеийн соёл иргэншлийн өөрчлөлт хувирлыг харгалзан үзэх нь зайлшгүй юм.

Энэ бүхнийг харгалзан орчин үеийн монголын боловсролын зорилго, зорилт болон монгол хүнд байх ёстой чадамжийг та бид хэлэлцэж тодорхойлох ёстой.

Дээр ярьсан зүйлийг дараах бүдүүвчээр илэрхийлж болох юм. Боловсролын зорилго бол үйл явцаар бус, бүх нийтэд боловсрол эзэмшүүлэх гэх мэт улс төрийн зорилгоор бус харин боловсролтой болсон хүний шинж чанараар, өөрөөр хэлбэл үр дүнгээр илэрхийлэгдэнэ. Зураг дээр боловсролыг салгаж зурсан боловч дээр дурдсанаар боловсрол бол нийгмийн том системүүдийн дэд систем учраас төр-улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санаа гэсэн том системүүд дотор ямар нэг байдлаар багтана. Үүнийг хоёр талтай сумаар илэрхийлсэн болно. Орчин үед улс орноо хөгжүүлэх, батлан хамгаалах чадварыг нь сайжруулах, байгаль, нийгмийн гаралтай аливаа гамшгаас урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчныг сэргээх, хамгаалах гэх мэт зорилтуудыг хэрэгжүүлэх нь улс

үндэстний оршин тогтнохуйн чухал нөхцөл болж байна. Эдгээрийн улмаас хүний хөгжлийг ийм зорилго, зорилтод чиглэсэн чадварыг эзэмших чиглэлээр өрнүүлэх хэрэгтэй болж байна. Үүгээр боловсролын зорилго тодорхойлогдоно.

*Зураг 1. Боловсролын зорилгыг тодорхойлох*



Өөрөөр хэлбэл, бодгаль хүн бие хүн болон “боловсрох”, болон хүн нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг өсгөх үйл явц нэгэн үйл явц болно гэсэн үг юм. Энэ нь Монголын боловсролын философийн гурав дахь зарчим юм уу онцлог хэмээн үзэж байна.

Нэгэнт тодорхойлогдсон зорилгын дагуу боловсролын үйл явцыг шинээр зохиомжилно. Хэдийгээр шинэ дизайн гарсан ч гэсэн нийгмийн өөрчлөлт, дэлхий дахины боловсролын чиг хандлагыг харгалзан боловсролын ирээдүйд байнгын прогноз хийдэг байх ёстой. Ирээдүйн чиг хандлагын таамаглал нь боловсролын үйл явцыг тодорхой хугацаанд ямар нэг хэмжээгээр өөрчлөх, шинэчлэх

үндэслэл болно. Гэвч боловсрол тогтвортой байх ёстой. Тиймээс боловсролын үйл явцын дизайн нь үл өөрчлөгдөх бүтцүүдийг агуулж байх учиртай.

*Санал:* XXI зууны боловсролтой хүнд байвал зохих шинж, Монгол Улсын өнөөгийн байдал, соёлын шилдэг уламжлалыг харгалзан үзвэл Монголын боловсролын зорилго нь дараах шинж чанар бүхий иргэнийг төлөвшүүлэхэд оршино хэмээн үзэж болох юм. Үүнд:

- Эх оронч, иргэнлэг байр суурьтай;
- Өндөр ёс суртахуунтай;
- Бүтээлч, аливаа зүйлийг шинжлэн үзэж, сайжруулах эрмэлзэлтэй;
- Хүн бүрийг хүндэлж, нийгмийн эерэг харилцааг тогтоох чадвартай;
- Хүн төрөлхтний соёлын үнэт зүйлсийг ойлгодог, үндэсний соёлын өвийг эзэмшсэн;
- Өөрчлөгдөн буй орчин, нөхцөлд дасан зохицох чадвартай
- Насан туршаа суралцах, дадал хэвшилтэй;
- Мэргэжилтэй;
- Ажилсаг;

Эдгээр чадамж нь сүүлийн үед XXI зууны хүнд байх “soft skills” хэмээн нэрлэдэг шинж чанаруудыг багтаахын зэрэгцээ Монгол улсын хөгжлийн хэрэгцээг харгалзаж байгаа гэж үзэж байна. Зөөлөн ур чадварын тоонд дараах зүйлийг ихэвчлэн нэрлэсэн байгаа юм. Үүнд багаар ажиллах чадвар, шийдвэр гаргах чадвар, эрсдэл гаргах эрмэлзэл, нэвтрэлцэхүйн чадвар, зөрчлийг шийдвэрлэх чадвар, бүтээлч байх, эмх цэгцтэй (системч) байх, шинжээч байх, суралцах сонирхол, сэдэл, овсгоо, шинэ зүйлд нээлттэй байх, шударга чанар, сэтгэлзүйн хувьд тогтвортой, өөдрөг байх, шүүмжлэлт сэтгэлгээ зэрэг болно.

Тиймээс монголын боловсролын тогтвортой бүтэц (invariable structures) нь юу байх ёстой тухай ярилцах хэрэгтэй болно. Энэ нь боловсролын институт болон агуулгын аль алинд нь хамааралтай юм. Түүнд одоо байгаа болон буй болгоод тогтвортой байлгах зүйлийн аль аль нь багтана.

## 2.2. Боловсролын үйл явцад оролцогчид

Боловсролын системийн систем үүсгэгч нь суралцагч-хүн гэж үздэг. Гэвч боловсрол бол “багш-шавь” гэсэн хоёр хүний үйл ажиллагааны болон тэдний харилцааны үр дүн байдаг. Тийм болохоор Монголын боловсролын системийн систем үүсгэгч нь “шавь- багш” гэсэн хослол байна гэж үзэж байна. Хүнийг хөгжүүлэх гэдгийг шавь, багш хоёрыг зэрэг хөгжүүлэх, тэд зэрэг хөгжих гэсэн агуулга болно. Зөвхөн шавийг онцлох нь зөв биш. Хэрвээ тэгж үзвэл, шавийн хөгжлийн бүх үе шатанд шаардагдах мэдлэг чадварыг эзэмшсэн багш анхнаасаа байж, шавиа хөтөлнө гэсэн үг болж таарна. Өнөөгийн нөхцөлд ийм боломж байхгүй. Багш шавьтайгаа хамт хөгжиж байж сая үр дүн гарна хэмээн үзэж болно. Тийм учраас Монголын боловсролын философийн нэг онцлог нь багш, шавь хоёрыг салгахгүйгээр хөгжүүлэх асуудал юм гэж үзэж байна. Шавь төвт сургалтын тухай ярих нь багшийн үүргийг дутуу үнэлэх, хөгжлийг нь орхигдуулахад хүргэж байж болох юм. Суралцагч суралцах үйлдээ идэвхтэй, хариуцлагатай хандах, бие даасан бүтээлч шинжтэй болж хөгжихөд багш л түүнийг ийм замналаар хөтөлнө. Шавь төвт сургалт гэж ярихын зэрэгцээ багш бол менежер, багш бол мэдлэгийг хамтран бүтээгч гэх мэтээр ярих нь зөрчилтэй юм.

Дэлхий даяар боловсролын чанарт нөлөөлж байгаа гол хүчин зүйл бол суралцагчдын сурах сэдэл гэж үзэх болжээ. Манай оронд ч суралцагчдын сурах сэдэл хангалтгүй байдаг нь нууц биш. Суралцагчдын сурах сэдэлд нөлөөлдөг хүчин зүйлсийн тоонд юуны өмнө багшийн үйл ажиллагаа, сургуулийн тав тух, соёл, ангийн хэмжээ, сургууль эцэг эхийн холбоо зэрэг орж байна. OECD-ийн TALIS байгууллагаас хийсэн судалгаагаар багш нарын 94.0 хувь нь суралцагчдыг бүтээлчээр сэтгэж сургах ёстой гэж үздэг боловч зөвхөн 42.0 хувь нь тэдний үйл ажиллагааг багаар зохион байгуулдаг ба 16.0 хувь нь сургалтдаа төсөл хэрэглэдэг гэсэн үр дүн гарчээ. Өөрөөр хэлбэл, бүтээлч сэтгэлгээнд сургах аргыг хэрэглэдэггүй гэсэн үг юм. Үүний дотор суралцагчдыг сэдэлжүүлэх явдал бүр бага байдаг ажээ. Түүнчлэн багш нар суралцагчдад мэдлэг олгоход голлон анхаараад нийгэм-сэтгэл хөдлөлийн талын

чадамжийг нь хайхрах нь сул байдаг ажээ. Байдал ийм байгааг боловсрол судлаачид XXI зууны хүүхдүүдийг XIX зууны сүүлчээр буй болсон тэр аргаар сургах гэж оролдож байна хэмээн дүгнэж байна. Олонх багш нар багшийн сургуулиар олж авсан мэдлэгээ хэрэглэж чаддаггүй аж. Боловсролын чанарыг дээшлүүлэхэд бага сургуулийн үйл ажиллагааны үр дүн онцгой ач холбогдолтой байна. Тэнд л хүүхэд сургуульд дуртай юм уу эсвэл дургүй болдог, суралцах дадал эзэмшиж эхэлдэг, ямар хүмүүжилтэй хүн болох вэ гэдгийг шийдвэрлэдэг. Тиймээс бага ангийн багш нарыг бэлтгэх, бага сургуулийг олшруулах, багшийн ажил, амьдралын нөхцөлийг дээшлүүлэх цогц арга хэмжээ чухал болж байна.

Багшийн сургах арга барил юм уу сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны хэв маягийг гурав ангилж болох юм.

- *Авторитар захиргаадах хэв маяг.* Ийм хэв маягийн сургалт нь эхлээд багш агуулгыг ярьж өгөх, жишээгээр тайлбарлах дараа нь сурагч багшийн жишгээр дасгал ажиллах. Сурагчдын үйлдэлд хяналт тавьж, болох, болохгүйг заан захирах;
- *Либераль буюу сурагчдыг дураар нь тавих;*
- *Ардчилсан хэв маяг.* Сурагчдад тавьсан зорилгодоо хүрэхэд нь тусалж, дэмжих. Багш сурагчийн хооронд найзын харилцаа тогтож, харилцан ярилцаж, амжилт ахицаа дүгнэх, зорилго тодорхойлох, суралцагчид тулгасан шаардлага тавихгүйгээр зөвлөгөө өгч, зөв зүг рүү чиглүүлэх, тэдний сонирхлыг дагуулан сурган хүмүүжүүлэх зорилгоо хэрэгжүүлэх;

Либераль хэв маяг олон сөрөг талтай учраас түүний талаар авч үзэх шаардлагагүй байх. Харин үлдсэн хоёр хэв маягийн талаар ярьж, хэрэгжүүлэх боломжийн талаар нухацтай бодох хэрэгтэй юм. Захиргаадах аргыг дангаар нь сонгох нь хамгийн амар хялбар зам мөн. Ардчилсан хэв маяг нь онолын хувьд маш аятайхан сонсогдож байгаа боловч хэрэгжүүлэх арга талаасаа маш бэрхшээлтэй. Түүний үр дүнд багш нар ийм арга барилыг хэр эзэмших, үндэсний соёл зэрэг олон зүйл нөлөөлнө. Тиймээс ардчилсан болон захиргаадах арга барилыг хослох боломж байгаа эсэхийг судлах хэрэгтэй. Хятад, Солонгос,

Японы сургалтын арга барилд ийм хослолыг хэрэглэж байгаа мэт. Захиргаадах аргаар бүтээлч сэтгэлгээнд сургаж болох уу гэдэг асуулт л даа. Эдгээр орнуудын боловсролын чанар сайн байгаа шүү дээ.

Уг асуудал нь монгол хүүхдүүдийн сурах сэдэл, түүнд нөлөөлдөг хүчин зүйлийн судалгаанд тулгуурлах учиртай. E.L.Desi судалгааныхаа үндсэн дээр багшийн зүгээс суралцагчийн бие даасан байдлыг өөгшүүлсэн маягийн сургалтын арга барил сурлагын амжилтад нөлөөлдөг гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг. Багш бие даасан байдлыг дэмжиж, хянах зааварчлахаас аль болохоор татгалзана гэсэн үг юм. Сургалтын ийм аргыг хэрэглэх асуудал нь зөвхөн багшид биш, боловсролын системийн менежментэд бүхэлд нь хамаатай байна гэж дүгнэсэн. Учир нь багшид дээд байгууллага, удирдлагын зүгээс үзүүлэх дарамт, хяналт их байх тусам тэдний суралцагчдадаа тавих шаардлага чанга болдог байна. Гэтэл Joanna Gózdź арга зүйн хувьд Desi нарын онолд тулгуурласан боловч багш нар суралцагчдын бие даасан байдлыг дэмжих болон хянах аргыг хослуулах нь зүйтэй гэж үзсэн байдаг. Тэрбээр “суралцах сэдлийн талаас нь үзвэл багшийн зүгээс бие даасан байдлыг дэмжих болон хянах хоёрын аль аль нь чухал. Суралцагчийн бие даасан зан үйлийн сэдлийг тогтвортой байлгахын тулд түүнийг дэмжих хэрэгтэйг багш ухамсарлаж байх ёстой. Гэвч гадаад зохицуулалт нь багшийн хяналтад үндэслэнэ. Тэр нь бие даасан байдлыг дэмжих ээлжит зохицуулалттай нягт холбоотой байдаг” гэжээ. Эл сүүлчийн судалгааны дүгнэлт нь дээр өгүүлсэн захиргаадах болон ардчилсан хэв маягийн арга барилыг хослох боломж бий гэсэн санааг бага ч болов бататгаж байгаа юм. Ийм хандлага нь монголчуудын төвч үзэл, арга билгийн ухааны үзэл санаатай нийцэх болов уу гэмээр байна. Багш суралцагчаа судалж, хөгжих боломжийг нь нээн олж, түүгээр нь дамжуулан хөгжүүлэх арга барилаа сонгодог байх нь тэднийг ялгаварлах, сайн сурдагийг нь илүүд үзэх, бусдынх нь суралцах идэвхийг бууруулдаг сөрөг үзэгдлийг арилгадаг ажээ.

Шинжлэгч сэтгэлгээтэй сурагч	Бүтээлч сэтгэлгээтэй сурагч	Практик сэтгэлгээтэй сурагч
Дүн өндөр	Дунд болон сул дүнтэй	Дунд болон сул дүнтэй
Тестийг сайн өгдөг	Тестийг дунд дүнтэй өгнө	Тестийг дунд болон сул үнэлгээтэй өгнө
Сургуульдаа дуртай	Сургууль өөрийг нь хязгаарлаж байна гэсэн мэдрэмжтэй	Сургууль уйтгартай гэсэн мэдрэмжтэй
Багш нар түүнд хайртай	Багш нар төвөгтэй хүүхэд хэмээн үзэх нь элбэг	Багш нар түүнийг суралцах дургүй хүүхэд хэмээн үзнэ
“Сургуульдаа тохирч буй хүүхэд”	“Сургуульд тийм ч их тохиромжтой биш хүүхэд”	“Сургуульд тохирох нь бага хүүхэд”
Багшийн даалгаврыг гүйцэтгэнэ	Даалгавар хийхдээ дургүй	Ямар зорилгоор даалгавар, заавар өгч байгааг нь мэдэх дуртай
Үзэл баримтлалын доголдлыг олж харна	Өөрийн шинэ санаа дэвшүүлэх дуртай	Үзэл санааг практикт хэрэглэхэд анхаардаг
Төрөлхийн “шүүмжлэгч”	Төрөлхийн “мөрөөдөгч”	“Ухаалаг”, хар ухаантай
Хянуулж, шалгуулах дуртай	Өөрөө өөрийгөө хянах хандлагатай	Хүрээлэн байгаа орчноосоо баталгаа олох дуртай

Энд дурдаж байгаа дүгнэлтүүд монгол хүүхдийн хувьд өөр ч байж болох юм. Гол санаа бол “муу” юм уу “сахилгагүй” гэж үнэлэгддэг сурагчид ч бүтээлч, амьдралын ухаантай хүмүүс байж болох учраас тэдэнд ялгавартай хандаж, хөгжүүлэх ёстой гэдэг юм.

Өөр нэг асуудал бол багш сурагч хоёрын амьдарч байгаа ертөнцийн ялгаа юм. Өнөөгийн сурагч интернэтийн ертөнц буюу ямар нэг хэмжээгээр виртуаль ертөнцөд, харин багш бодит ертөнцөд байх шиг байна. Тиймээс сургалтыг сурагчдын ертөнц рүү оруулах арга хэрэгтэй болж байх шиг байна. Тиймээс хэрвээ тэгж нэрлэж болох бол “цахим дидактик”-ийг боловсруулан хэрэглэх шаардлага гарч байна. Ухаалаг анги, цахим сургалтын платформ болон бусад зүйлийг буй болгож болно. Харин цахим орчинд яаж хичээл заах, яаж сургалтыг хүмүүжилтэй хослуулах вэ гэдэг нь нарийн асуудал юм. Орчин үед медиа-боловсрол хэмээх сурганы салбар ухаан буй

болсон тухай ярих болжээ. Энэхүү ухаан нь сурган, кино судлал, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл судлал, коммуникацийн онол, соёл судлал, уран зохиол судлал, социологи, антропологи, улс төр судлал, урлагийн түүх, гоо сайхан зэрэг ухаануудын уулзвар дээрх хавсарга ухаан ажээ. Медиа боловсрол хэмээх тодорхойлолт бүр 1989 онд гарсан аж. “Медиа боловсролын зорилго нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мөн чанар, тэдгээрийн ашигладаг арга техник, тэдгээрийн нөлөөний талаар бүрэн дүүрэн, шүүмжлэлтэй ойлголтыг төлөвшүүлэх явдал юм. Энэ бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн ажилладаг, хэрхэн утга учрыг бий болгодог, бодит байдлыг хэрхэн зохиомжилдог, хэрхэн зохион байгуулагддаг талаар суралцагчид ойлгон ухамсарлахад нь туслах зорилго бүхий боловсролын хэлбэр юм. Медиа боловсролын өөр нэг үүрэг бол суралцагчид өөрснөө медиа бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадварыг нь нэмэгдүүлэх явдал юм (Henry Jenkins, 2009)”.

Сургууль бол насанд хүрсэн болон насанд хүрээгүй хүмүүс, хэдэн зуугаас хэдэн мянган ам бүл бүхий том байгууллага юм. Сургалт, хүмүүжлийн ажлаас гадна санхүү эдийн засгийн, гадаад орчинтой харилцах гэх мэт олон талын үйл ажиллагаа явуулна. Тийм учраас сургууль удирдах гэдэг бол менежментийн нэг өвөрмөц төрөл юм. Тэр нь захиргаадалтаас ч, бизнесийн менежментээс ялгаатай. Энэ нь сургуулийн захирлыг менежментийн чиглэлээр мэргэшүүлэх шаардлагыг бий болгож байна. Захиргаадах арга барил үеэ өнгөрөөсөн. Ийм нөхцөлд сургуулийн менежментийн талаарх чанартай судалгааг хийж, түүний үр дүнг практикт нэвтрүүлэх нь сургалт, хүмүүжлийн ажлын чанарыг сайжруулахад тус дөхөм болно.

Энд багшийн тухай нэлээн дэлгэрэнгүй нуршиж буйн учир нь боловсролын хамгийн гол оролцогч бол багш гэж үзэж байгаагийнх юм.

Багш-шавь гэсэн энэхүү явцуу хүрээнээс халих юм бол боловсрол бол боловсорч буй хүний нийгэмтэй харилцах үйл явц юм. Энэхүү харилцаанд гэр бүл, үе тэнгийнхэн, мэдээллийн хэрэгсэл, соёл, урлагийн ажилтан гэх мэт маш олон харилцагч оролцдог. Юуны өмнө “багш-суралцагч-гэр бүл”, “сургууль, суралцагч гэр бүл” гэсэн гурвалжилсан харилцааг суралцагчийн

хөгжилд түлхэц өгөхүйцээр эрүүл болгох учиртай. Хүүхдийг гэр бүлд хүмүүжүүлэх, хөгжүүлэх асуудал чухал болж байна. Гурав хүртэлх насны хүүхдийг зөвхөн асрах, хамгаалах ёстой гэдэг үзэл зөв биш юм. Эцэг эхчүүд хүүхдийн хүмүүжлийн асуудлыг зөвхөн цэцэрлэг сургуульд даатгах, улмаар өөрсдийгөө хариуцлагаас хөндийрүүлэх явдал түгээмэл ажиглагдаж байна. Нөгөө талаар хүүхэд цэцэрлэгт явахаараа “элдэв муухай үг” сурч ирдэг, сургуульд явахаараа бусдад уруу татагдан сахилгагүйтэх, тамхи татах зэрэг хүмүүжлийн доголдолтой болдог гэсэн үзэл байдаг нь сургалтын байгууллага тэдний хүмүүжилд дутуу анхаарч байгаагийн шинж юм. Боловсролын байгууллагууд хүүхдэд мэдлэг олгоход анхаарч, хөгжлийн бусад талуудыг орхигдуулж болохгүй юм.

Монголын боловсролын философийн асуудлын тухай ярихад зайлшгүй хөндөх ёстой асуудал бол нийгэм орчны хүүхэд, залуучуудад үзүүлж буй нөлөө, хүүхэд хамгааллын асуудал болж байна. Энд орчны хүүхдэд үзүүлж буй сөрөг нөлөөг багасгахын тулд насанд хүрэгчид, урлаг соёлын зүтгэлтнүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн зүгээс “хүүхдэд үзүүлж буй нөлөө” гэдэг үзүүлэлтийг баримтлан өөртөө “цензур” тогтоох тухай санааг дэвшүүлж байна. Эл асуудлыг боловсролын системийн зүгээс нийгэмд хандан бүх нийтийн анхааралд оруулж чадвал улс нийгэмд үзүүлэх ач холбогдол нь их байх болно. Хүүхэд хамгааллын үндсэн субъект нь гэр бүл, боловсролын байгууллага юм. Тэдгээрийг ямар нэг хөндлөнгийн байгууллага орлох нь хүүхдийг гэр бүл, сургууль, багш нарынх нь эсрэг болгож, хөндийрүүлэх хандлагатай байна. Хүүхэд, залуу үеийг сургаж хүмүүжүүлэхийн зэрэгцээ хамгаалах ажил хаана ч, хэзээ ч гэр бүл, сургуулийн үүрэг байсан. Тэдэнд энэ ажлаа хийх боломжийг нь олгох хэрэгтэй.

Нэг нутгийнхан хүний өөрийн гэхгүйгээр хүүхдийн хүмүүжилд анхаарч сургаж заадаг байсан уламжлалыг өнөө үед нийгмийн түвшинд хэрэгжүүлэх арга хэрэгслийг олох нь чухал юм.

Ийм учраас багш-шавийн харилцааг суралцахуйн “субъект-объектын” бус “субъект-субъектийн” харилцаагаар төсөөлөх, түүнийг амьдралд хэрэгжүүлэх тодорхой арга зам нь юу вэ гэдгийг

хэлэлцэх хэрэгтэй байна. Түүнчлэн нийгмийн орчноос хүүхэд залуучуудын хүмүүжилд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөө, мэдлэг, чадвар, дадал олоход нь тус дэм үзүүлэх асуудлыг сөхөх, судлах, нийт нийгмийн анхаарлыг хандуулах хэрэгтэй.

### **2.3. Сургалт-хүмүүжил нэгдмэл байх нь**

Монгол боловсролын өөр нэг онцлог нь боловсрол нь агуулгадаа хүмүүжлийг заавал багтааж байх учиртай гэж үзэх явдал юм. Боловсролтой, гэр бүлдээ хайртай, урлаг соёлд дуртай, нэг үгээр хэлбэл “өөгүй” мэт харагддаг хүн хүн төрөлхтөнд, нийгэмд хортой үйл үйлдсэн жишээ олон бий. Өөрөөр хэлбэл, хүн боловсролоо янз бүрээр ашиглаж болно. Хүн түүнийг юуны төлөө хэрхэн ашиглах нь хүмүүжлээс хамааралтай. Ийнхүү суралцангаа хүмүүжсэний үр дүн нь боловсрол болно. Үүнийг  $C \times X = B$  хэмээн томъёолж болох юм. Энд үржүүлэх тэмдэг тавьдгийн учир нь суралцахуй хүмүүжихүй хоёр бие биеэ дэмжиж шинэ мөн чанарыг үүсгэх бөгөөд энэ нь боловсрол гэсэн санааг агуулж байгаа болно. Боловсрол нь дээр дурдсанчлан хүний цогц чадамжаар илэрхийлэгдэнэ.

Суралцахуй хүмүүжихүй хоёрыг ийнхүү нэгэн үйлээр зохион байгуулахад багшийн үүрэг, нөлөө маш их. Энэ асуудал багшийн цогц чадамж, түүнийг бэлтгэж байгаа сургуулиудын хөтөлбөр, багш мэргэжлийг эзэмшүүлж буй арга барил, багш мэргэжлээр элсэж буй хүүхдүүдийн ёс суртахууны шинж чанар гэх мэт олон зүйлийг хөндөнө. Суралцагчид зарим багшийг дагаад гүйгээд байдаг, заримаас нь айж цэрвэдэг, заримыг нь тоодоггүй зэрэг тохиолдол амьдралд элбэг байдаг. Бараг сургууль, анги бүрд ийм байдал ажиглагддаг. Энэ нь багшийн тэдэнд хандах хандлага, өөртөө татах, зааж байгаа хичээлдээ дуртай болгох чадвартай холбоотой юм. Багшийн эдгээр болон бусад хэв маягийг судлах нь саяын дурдсан хөндөх асуудлуудыг шийдвэрлэхэд тустай байх болно.

Энэ бол судлаачдын хөндөж судлах, ярилцах ёстой асуудлын нэг мөн.

## 2.4. Боловсролын агуулга, үйл явцыг зорилготой нийцүүлэн зохиомжлох нь

Боловсролын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд боловсролын агуулга, үйл явцыг хэрхэн зохиомжлох ёстой вэ гэдэг нь төвөгтэй асуудал юм. Боловсролын хөгжүүлэх хэв маягийг баримталж буй өнөөгийн нөхцөлд боловсролын философийн аль нэг урсгал чиглэлийг үндэсний боловсролын философид баримтлах боломжгүй юм. Боловсролын философийн судлагдахуун бол хөгжиж буй хүн юм. Харин сурганы судлагдахуун бол боловсролын үйл явц юм. Гэвч энэ хоёр салгуу зүйл бус бөгөөд боловсролын үйл явцыг үндэсний боловсролын философид суурилснаар эдгээрийн уялдаа холбоо хангагдана. Боловсролын үйл явц нь сургалт, хүмүүжлийг хосолсон, боловсролын зорилгыг хангахад чиглэсэн байна.

Орчин үед хүнд хувь хүн гэдэг талаасаа, мөн улсын иргэн гэдэг талаасаа олон янзын мэдлэг чадвартай байх, тэдгээр нь өөр хоорондоо зөрчилгүй (чадвар болон хандлагын хооронд г.м.), уялдаа холбоотой байх шаардлагатай болж байна. Чухам эл шаардлага нь боловсролын философийн аль нэг урсгал чиглэлийг баримтлах бололцоогүй болгож байгаа ба боловсролын үйл явцыг зохиомжлоход хүндрэл учруулж байгаа юм. Тиймээс монголын боловсролын философийг боловсруулахад хэд хэдэн ац асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болж байгаа юм.

- Хүнийг хувьч шинжтэй (индивидуал) болон нийгэмч шинжтэй болгон хөгжүүлэх зорилтыг хэрхэн шийдвэрлэх. Тодорхой хэлэх юм бол эдгээрийг хэрхэн хослуулах вэ гэдэг асуудал юм. Хувьч шинж нь хүний өвөрмөц авьяас чадварын тухай асуудал болохоос бус нийгмийг, бусад хүмүүсийг үл тоох, эсвэл аминчхан үзэл биш юм. Социо-төвт ба антропо-төвт үзлийн хооронд сонголт хийх эсвэл хувь хэмжээг нь тогтоох асуудал юм. Дэлхийн практикаас үзвэл антропо-төвт үзэл нь яваандаа нийгмийг “атомжиход” хүргэдэг учраас цөөн хүн амтай, дэлхийн геополитикт өртөмтгий учраас ард түмний нэгдэл, нягтрал маш чухал хүчин зүйл болж байдаг манай орны хувьд түүнийг баримтлах нь зохимжгүй байж болох юм.

- Монголын ард түмний түүхэн ололт буюу социаль туршлагыг эзэмшүүлэх болон хүнийг бие даасан, бүтээлч, шинэчлэгч болгон хөгжүүлэх зорилтыг хэрхэн хослуулах. Энэ нь боловсролын “хөгжүүлэх” болон “хадгалах” хэв маягуудыг ямар нэг хэмжээгээр хослуулах хэрэгтэй гэсэн үг юм. Тэгэхээр юуг хадгалж авч үлдэх, юуг гээх, юуг шинээр бий болгохыг шийдвэрлэх хэрэгтэй болно. Социаль туршлага нь үндэсний болон нийт хүн төрөлхтний гэсэн хоёр түвшинтэй. “Хадгалах” хэрэгтэй зүйл нь боловсролын үйл явцын үл өөрчлөгдөх бүтцийн (invariable structure) нэг хэсэг байх болно.
- Хүмүүнлэг болон технократ хандлагыг хэрхэн хослуулах. Орчин үеийн боловсролд шинжлэх ухаанч, технократ чиглэл нь зонхилох хандлагатай байна. Энэ нь улс орны хөгжилд (эдийн засаг, техник, технологийн утгаар) тустай байгаа нь илэрхий. Гэвч нөгөө талаар нийгмийн зөрчил, сөрөг үзэгдлүүд, хүрээлэн буй орчны доройтол гэх мэт олон асуудлын улмаас боловсролын хүмүүнлэг талыг анхаарах нь чухал гэсэн үзэл санаа буй болж байна.

Эдгээр асуудал нь хүний үнэлэмж төлөвшихтэй холбоотой юм. Мөн боловсрол, мэргэжилтэй холбоотой асуудал бий.

- Бүх талын мэдлэг олгох болон нарийн мэргэжил эзэмшүүлэх зорилтын харьцааг зөв тогтоох. Энэ асуудал нь хүний хөдөлмөрийн зах зээл дээр ажил олох чадвар, хөрвөх, шилжин ажиллах боломж, үнэлэмж, ямар нэг иррациоаналь үзэл, итгэл үнэмшилтэй болохоос хамгаалах, ухамсартай сонголт хийх чадвар хандлага гэх мэт олон зүйлд нөлөөлнө. Түүнчлэн эл харьцаа нь тухайн улсын хүн амын тоо гэх мэт хүчин зүйлээс шалтгаалдаг бололтой. Олон болон цөөн хүн амтай орны хооронд ялгаатай байх болов уу гэсэн үг юм.
- Мэдлэг олгох үйл явцад плюрализмыг тэвчих эсэх. Өнөөг хүртэл манай оронд ертөнцийн шинжлэх ухаанч дүр зургийг л ойлгож, эзэмшихэд гол хандлага ноёлж ирсэн. Зарим оронд боловсролтой хүмүүсийн дотор ч гэсэн хүний үүслийн тухай хувьслын онолыг үгүйсгэх нь байдаг. Манай орны хувьд шинжлэх ухааны мэдлэг олгох

- нь үл өөрчлөгдөх бүтцийн нэг байх учиртай. Зохих шатны боловсрол эзэмшсэн хүн дараа нь ямар итгэл үнэмшилтэй байх, баримтлах зэрэг нь түүний сонголтын асуудал байна.
- Сургалт, хүмүүжлийн ажлууд зааг ялгаатай байх эсэх тухай асуудал. Өнгөрсөн зууны сүүлийн хагаст монголын сургуулиудад “хүмүүжлийн эрхлэгч” хэмээх албан тушаалтан буй болсон нь нэг талаас суралцагчдын хүмүүжлийг онцгой ач холбогдолтой хэмээн үзэж байсны шинж гэж болох боловч нөгөө талаас сурах, хүмүүжих болон сургах, хүмүүжүүлэх үйл ялгаатай хэмээн үзэж салгаж байсны тэмдэг гэж болох юм. Ингэснээр хүмүүжлийн ажил анги удирдсан багш, хүмүүжлийн эрхлэгч хоёрын үүрэг болж, бусад багш нар “хүмүүжүүлэх үүрэг”-ээс хөндий болсон болов уу гэлтэй. Эвлэл, пионерийн зэрэг үзэл суртлын байгууллагууд нөлөөтэй байсан нь монголын боловсролын философийн бас нэг онцлог байх болов уу. Эдгээр нь нэгдмэл нэг үйл явц юм. Суралцагч суралцангаа хүмүүжих учиртай. Ингэж үзвэл сургалтыг зохион байгуулж байгаа байгууллага, багшийн хандлага, ур чадвар маш чухал.

Энд дурдаж буй ац асуудлуудыг шийдвэрлэснээр Монголын боловсролын философийн нүүр царай тодорхой болно. Үүний тулд ац асуудалд багтаж байгаа хоёр чиглэлийг Монголын нийгмийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, хөгжлийн бодлоготой уялдуулан цэгнэх нь чухал. Дээр дурдсан асуудлууд нь ац шинжтэй боловч, бие биеэ бүрэн үгүйсгэхгүй. Аль нэг чиглэлийг нэлээд туйлшруулан үздэг судлаачдын байр сууринаас үзвэл ийм харилцуулан үгүйсгэсэн байдал илэрдэг. Гэвч энэ нь заримдаа улс төрийн байр суурийн илэрхийлэл байх нь элбэг юм. Нэгэнт эдгээр асуудлууд бие биеэ бүрэн үгүйсгэдэггүй учраас ямар нэг хэмжээгээр хослох боломж байгаа юм. Хослохдоо суралцагчийн хөгжлийн үе шатуудаар дараалах, тухайн тодорхой үе шатанд ямар нэг хэмжээгээр хослох, “ерөнхий-тусгай-нэгж”-ийн диалектик шилжилтийг хоёр чиглэлийн аль алинаар нь баримтлах зэрэг арга зүйн зарчмуудыг ашиглаж болох юм. Тэгэхдээ энэ бүхэн нь монгол хүүхдийн хөгжлийн үе шатууд, тэдгээрийн онцлогийн тухай мэдлэгт суурилах болно.

Үүнд монгол гүн ухааны гол үндэслэлийн нэг болох төвч хандлагыг хэрэглэж болно. Энэхүү төвч гэдгийг бурхны шашны төв үзэлтэй холбон ойлгож болохгүй. Монголын төрт ёсны уламжлалд “Түшмэл хүний есөн эрдмийн дотор төв сэтгэл нэн эрхэм”, “түшмэл хүн есөн эрдмийг төгсгөвч төв сайн сэтгэлгүй бол хорт чоно мэт жигшигдэхийн учир төв сэтгэлийн эеийг хичээ” хэмээн сургамжилж, улмаар баримталж ирсэн байна. Төвч хандлага бол аливаа юмны голд нь байна гэсэн үг бус, орон цаг, нөхцөл байдлыг харгалзан тун хэмжээг нь тохируулна гэсэн үг билээ.

Ийм шийдэл нь англи хэлтэн орнуудад “holistic”, Германд “Ganzheitliche Bildung”, орос судлаачид “целостное образование” гэж нэрлэдэг хэв маягтай зэрэгцэх монгол “бүрэн боловсрол” олгодог сургалтын загварыг бүрдүүлж болох юм. Дашрамд дурдахад Германы Хайделбергийн мэргэжлийн сургуулийн захирал Вилли Хелпах сургуульдаа “аз жаргал - Glück” хэмээх хичээл заадаг болсон нь суралцагчдад ихэд нөлөөлсөн аж. “Glück macht Schule” гэсэн уриатай энэ аргыг Герман, Австрийн зуу гаруй сургууль ашиглах болжээ. Суралцагч сургууль дээрээ жаргалтай байдаг, хичээлдээ баяртай явдаг нөхцөл байдлыг буй болгох нь хэрэгжүүлэхэд хэцүү боловч тэмүүлэх ёстой чин эрмэлзэл байж болох юм.

Ац асуудлыг ямар харьцаагаар боловсролд бүхэлд нь болон хичээл тус бүрд, боловсролын шатлал болгонд хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг нь судлах, хэлэлцэх асуудал болно. Үүгээр монгол боловсролын онцлог тодорхойлогдох болно.

## **2.5. Соёл, үнэлэмжийн нэгдмэл байдал**

Хүний хөгжил гэдэг нь юуны өмнө нийгэм-соёлын талын хөгжил юм. Бусадтай харилцаж, хүндэтгэж, санаа бодлыг нь сонсож, өөрийгөө цэгнэн үнэлэмж буй болгох, өөрийн болон бусдын үйлийг үнэлэмжийн шалгуураар үнэлж, сонголт хийж чаддаг байх зэрэг нь чухал юм. Энэ нь бусдын эрхийг хүндэтгэх, өөрөө үүргээ ухамсарлах дадлыг буй болгоно. Энэ үндсэн дээр нийт ард түмний бус гэхэд дийлэнхийн үнэлэмжийн, соёлын нэгдмэл байдал буй болно. Энэ бол хувь хүний түвшнээс дээш гарсан өндөр түвшин, өргөн хүрээний чанар буй болж байгаа хэрэг

мөн. Мэргэжилтэй атлаа нийгэм соёлын чадвар дадал байхгүй бол түүнийг хөгжсөн хүн гэж үзэх боломжгүй юм. Тийм учраас өнөөгийн нөхцөлд Монголын боловсролын гол зорилт бол ард түмний түүхэн туршлагаар бий болсон оюун санааны үнэт зүйлд тулгуурласан соёлын нийгэмшил, залуу үеийг эх орны өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн хэрэгцээ, шинжлэх ухаан технологийн нөлөөгөөр гарч байгаа хүний оршин байхуйн өөрчлөлтөд нийцүүлэн төлөвшүүлэх явдал юм. Гэвч нийгэм-соёлын хөгжлийн зэрэгцээ монгол хүний хөгжлийн нэг чухал тал бол мэргэжил юм. Хүн бүрд заавал мэргэжил эзэмшүүлэх нь боловсролын системийн нэг зорилт юм. Хүний хөрвөх чадвар өндөр байх нь хүн амын тооны сөрөг нөлөөллийг арилгах, нөгөө талаар эрчимтэй өөрчлөгдөн буй өнөөгийн нөхцөлд хүний дасан зохицох, аж амьдралаа авч явах боломжийг нэмэгдүүлэх болно. Тийм учраас нарийн мэргэжилтэн бэлтгэхийн зэрэгцээ, хоёр юмуу хэд хэдэн чиглэлийг хосолсон мэргэжилтэн бэлтгэж болох юм. Барилгын инженерийг угсралт, сантехник, цахилгааныг багтаасан, малын эмч-мал зүйч гэх мэтээр хосолж болох юм.

Нийгэм-соёлын хөгжил нь ямар нэг сургаал, номлолд суурилдаг гэж ажиглагдаж байгаа юм. Европын орнуудын хувьд христийн шашин, ардчиллын үзэл санаанд гол нь тулгуурлаж байгаа аж. Азийн орнуудын хувьд лал, күнзийн зэрэг номлол зохих нөлөөтэй байгаа боловч гол нь үндэсний үзэлд тулгуурлаж байх шиг ажиглагддаг. Монгол улсын хувьд ч үндэсний үзэлд тулгуурлах нь илүү зүйтэй юм. Үүнд үндэсний үзэл санаа (national idea)-г боловсруулан соёл, боловсролоор дамжуулан хүний амьдралын бүхий л талд шингээх учиртай. Үндэсний үзэл санаа нь нийгмийн гишүүдийг сэдэлжүүлэгч, нягтруулагч хүчин зүйл юм. Монголын нийгэмд сүүлийн гуч орчим жилийн хугацаанд буй болж, улам бүр даамжирч байгаа эсрэгцэл, задралын үйл явц, төвөөс зугтах хүчний эрчимжилтийг харгалзан үзвэл ийм үндэсний үзэл санааг буй болгож, дэлгэрүүлэх шаардлага маш хурц байна. Үндэсний үзэл санаа нь уриа, лоозонгийн хэлбэртэй байх тохиолдол байдаг боловч өнөөгийн Монгол Улсын хувьд ямар улс, ямар нийгэм байх дүр төрхийн тухай төсөөлөл/мөрөөдөл юм. Монголчууд түүхэндээ ийм төсөөллийг буй болгож түүнийг

хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байсан уламжлал бий. 1914 онд Улсын хурлын газрыг байгуулахыг хүсэж айлтгасныг Богд хаан зөвшөөрөн цохсон бичигт Манж Чин улсаас тулгар салсан Монгол Улсын ирээдүйн төлөвийг тодорхойлж “улсын хүчин бат чийрэг, эдийн засаг элбэг дэлбэг, хүн бүр хүрэлцэж, гэр бүр баян талбиу, дотоод дор ариун тодорхой, гадаад дор найртай түвшин болох” хэмээн бичсэн байна. Социализмын үед “аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон” болох гэх мэт уриатай байсан нь бас л үндэсний үзэл санааны шинжтэй байжээ. Үндэсний үзэл санааг бий болгох улс төр, эрх зүйн суурь нь Монгол Улсын Үндсэн хуулиар тавигдсан юм. Уг хуулийн оршилд:

Монголын ард түмэн бид

- Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж;
- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж;
- Төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж;
- Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж;
- Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно хэмээн хуульчилсан юм.

Эдгээр нь монголын ард түмний үнэлэмжийн суурь юм. Энэхүү суурин дээр тулгуурлаж ард түмний соёл, ёс суртахууны нэгдэл бий болно. Үндсэн хуульд тодорхойлсон эрхэм зорилгыг агуулгын хувьд нарийвчилбаас энэ нь үндэсний үзэл санаа болно. Улмаар эл эрхэм зорилго боловсролын агуулга, үйл явцад хэрхэн тусгалаа олж буйг нягтлан шинжлэх үндсэн дээр тэдгээрийг шинэтгэх хэрэгтэй болно. Ингэх нь боловсролын системд бүхэлд нь дүн шинжилгээ хийх том ажил юм. Үндсэн хуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэгч гол үндсэн субъект нь боловсролын систем юм.

Дээр дурдсан эрхэм зорилго нь соёл, үнэлэмжийн шинжтэй байгаа нь тохиолдлын хэрэг бус юм. Түүнийг хэрэгжүүлж чадвал, технократ тал нь бүрэлдэн бий болох нөхцөл хангагдана. Хүний хөгжил, нийгмийн хөгжил хоёр өөр түвшний асуудал боловч хоорондоо нягт уялдаатай. Тэгэхдээ энэхүү уялдаа нь нэгийг нь

нөгөөд нь захируулах гэсэн үг биш юм. Тиймээс хүний болон нийгмийн хөгжсөн гэж үзэх төлөвийг тодорхойлох хэрэгтэй. Залуу үе бие даасан, сонголт хийх чадвартай байх ёстой гэдэг нь ерөнхий. Юуг хийх, үйлдэхдээ бие даасан байдалтай байх, юуг үндэслэн сонголт хийх вэ гэдэг асуулт гарна. Орчин үеийн хөгжингүй улс орнуудад ийм зүйлд хэрэг болох санааг залуу хүний “зам дээр” тавиад өгчихдөг нь нууц биш. Үүнд боловсрол чухал үүрэг гүйцэтгэж байна. Тодорхой хэлбэл, нийтлэг үнэлэмжийг баримжаалан сонголт хийх чадвартай болгож байна гэсэн үг.

Тиймээс өнөөгийн байдал ямар байна вэ гэдгийг судалж дүгнэх, улмаар боловсролын үйл явцыг зохиомжлох тухай ярилцлага өрнүүлэх хэрэгтэй болно.

## **2.6. Орчин үеийн боловсролын системийн шинжийг бүрдүүлэх нь**

Орчин үеийн боловсролын систем нийлэгжсэн (integrative), нээлттэй, тасралтгүй, хүртээмжтэй, инновацлаг байх ёстой гэж үздэг болжээ. Эдгээр зарчмуудыг манай боловсролын системийн өнөөгийн байдал, хүмүүсийн бие даах чадвар, хариуцлага, суралцахуйд ашиглах боломж бүхий мэдээллийн баазын бүрэлдсэн байдал гэх мэт зүйлийг харгалзан өвөрмөцөөр шийдвэрлэх учиртай. Тэгэхдээ эдгээр хүчин зүйлийн үйлчлэх, өөрчлөгдөх шинж чанар өөр өөр. Мэдээллийн бааз гэх мэт зүйлийг тодорхой хугацааны дотор бүрдүүлж болох бол боловсролын нээлттэй системийн боломжийг ашиглан чанартай боловсрол эзэмших талаарх хүний өөрийн нь идэвх, хариуцлага тийм хялбархан өөрчлөгдөхгүй байж болох юм. Түүнчлэн дотооддоо багц цаг харилцан зөвшөөрөллөх гэх мэт олон асуудлыг журамлах, тасралтгүй суралцахуйн системийг бүрдүүлэх, боловсролыг виртуалчлах, дээд боловсролын дэлхийн системд нэгдэн орох (үүний тулд багш, оюутны гадаад хэлний мэдлэгийг эрс дээшлүүлэх) гэх мэт олон асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Энэ бүхнийг шийдвэрлэж боловсролын системийг дэлхийн чиг хандлагад нийцүүлэх “замын зураг” зохиож мөрдөх нь зүйтэй юм.

Тэгэхдээ орчин үеийн нөхцөлд бизнесийн, төрийн бус янз бүрийн байгууллага, хувь хүний суралцагчдад зориулан бий

болгож байгаа биет болон биет бус хэрэглэгдэхүүнүүд тэднийг өөрөө зүтгэл гарган суралцахаас зайлсхийж, амарчлах нөлөөтэй байж болохгүй юм.

Энэ ч бас монголын боловсролын философийг тодорхойлохын тулд судлаачид, мэргэжилтнүүдийн ярилцлага өрнүүлэх сэдэв юм.

## 2.7. Боловсролын дэд бүтэц

Боловсролын дэд бүтэц өнөөдөр өөр болж байна. Сурах бичиг, байгалийн ухаан, компьютерын лаборатори төдийхөн нь орчин үеийн боловсролын хэрэгцээг хангаж чадахгүй болжээ. Эдгээр нь цаашдаа ч байх нь мэдээж. Ялангуяа сурах бичиг бол маш чухал. Учир нь сурах бичиг бол стандарт, байнга гар дор байдаг лавлах юм. Гэвч хүний бие даан тасралтгүй суралцах, өөрөө идэвхтэй хариуцлагатай байх, мэдээлэл, мэдлэгийн эх үүсвэрийг хайх, сонгох боломжийг бүрдүүлэх талаасаа өөр байх ёстой болж байна. Суралцагч мэдлэг, мэдээлэл олж авах, хэрэгтэй үедээ зөвлөгөө авах, туршилт хийх, дадлагажих боломжийг хангахуйц боловсролын мэдээллийн цогцолбор хэрэгтэй болж байна. Бичвэрээс гадна аудио-видео хосолсон сурах бичиг болон мэдлэг, зөвлөгөө мэдээллийн олон төрлийн интернэт багцууд, хоцрогдол нөхөх болон ахисан түвшний сурах бичиг, тасралтгүй суралцахуйд зориулсан хөтөлбөр болон бусад материалууд, дрон, олон хэмжээст принтер бүхий бодит болон виртуал лабораториудыг бий болгох нь цаг үеийн шаардлага болж байна. Жишээлбэл, байгалийн ухааны биет лабораториудаас гадна виртуал лабораториуд байж болно. Эдгээр нь суралцагчдад сургууль болон гэрийн орчинд суралцах, туршилт хийх, мэдлэгийн эх үүсвэрээ чөлөөтэй сонгох боломжийг олгоно. Ингэснээр боловсрол нээлттэй, хүртээмжтэй болно. Дадлагажих зохион байгуулалтын хэлбэрүүдийг буй болгох хэрэгтэй болно. Олон түвшний мэргэжлийн сургуулиудын суралцагчдыг дадлагажуулахад төр, хувийн хэвшлийн янз бүрийн байгууллагын оролцоог хангах талаар зохистой арга хэрэгслийг олох нь чухал байна. Орчин үеийн техник, технологийн ачаар хүүхдэд зориулсан суралцахуйн хэрэглэгдэхүүн их болсон нь чухал юм. Гэвч хүүхдийн суралцах хөдөлмөрийг хөнгөвчилсөн,

бодох сэтгэх, тэвчээр гаргах зэргийг үгүйсгэсэн хэрэглэгдэхүүн сөрөг нөлөөтэй юм.

Энэ бүхэн нь боловсролын дэд бүтэцтэй холбоотой янз бүрийн стандартыг гаргаж мөрдөх хэрэгцээг бий болгоно.

## 2.8. Боловсролын үнэлгээг чанаржуулах нь

Сургууль, багш, суралцагчийн үйл ажиллагааны үр дүн, ахицын үнэлгээ хяналтын нэгдсэн систем байх нь чухал юм. Энэ бол боловсролын салбарын дотоод үнэлгээ байна. Үүнээс гадна дээд боловсрол эзэмшсэн мэргэжилтний цогц чадамжийн үнэлгээ, түүний шалгуурыг мэргэжлийн холбоод зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулж мөрдөх хэрэгтэй. Боловсрол бол багш сурагч хоёрын харилцаагаар хэрэгждэг үйл явц учраас ялангуяа багшийн цогц чадамж, түүнийгээ хэрхэн хэрэглэж буйг үнэлэх нь маш чухал. Багшийн үйл ажиллагааг үнэлэх янз бүрийн арга бий. Олон улсын байгууллагаас боловсруулж хэрэгжүүлсэн аргачлалууд байдаг. Жишээлбэл, Дэлхийн Банкны шугамаар боловсруулж Африк, Ойрх Дорнодод ашигласан үнэлгээний аргыг дурдаж болно (Халси Роджерс, 2015). Энэ аргачлалд багшийн ирц гэх мэт тоон үзүүлэлтүүдээс гадна мэдлэгийн тест, хичээлийн ажиглалт зэрэг багшийн үйл ажиллагааг үнэлэх олон аргыг хэрэглэдэг байна. Судлаачид болон боловсролын удирдлагын байгууллагууд өөр өөрийн орны нөхцөлд нийцсэн багшийн цогц чадамжийг үнэлэх арга зүйг боловсруулсан байдаг (Department for Education, 2011). Ийм жишээ олон байгааг манай өөрийн хэрэглэж буй аргачлалтай зэрэгцүүлэн судалж сургуулийн, багшийн суралцагчийн, мэргэжилтний үйл ажиллагааны үр дүн, ахиц дэвшил юм уу цогц чадамжийн үнэлгээний систем бий болгох нь боловсролын салбарын үйл ажиллагааны чанарыг бүхэлд нь сайжруулахад түлхэц болно. Үүний дотор багшийн ёс зүйн үнэлгээ, багшийн ёс зүйтэй холбоотой маргааныг шийдвэрлэх асуудал багтана.

Суралцагчийг үнэлэхэд PISA судалгааг ашиглах нь боловсролын түвшнийг олон улсынхтай харьцуулах, олон улсын хэмжээнд боловсролын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тустай учраас одоохондоо өөр хувилбарын тухай ярихгүй байх нь зүйтэй

юм. Бас чадамжийн үнэлгээг ашиглах ёстой болно. Тиймээс боловсролын шат болгоны дараа суралцагчийн эзэмшсэн байх цогц чадамжийг тодорхойлох хэрэгтэй болно. Мэргэжлийн боловсролын түвшин бүрд нийцсэн цогц чадамжийг үзүүлэлт болгож үнэлэх шаардлага бий.

Энэ бол судлах, ярилцах, улмаар албан ёсны үнэлгээний системтэй болох бас нэг чухал сэдэв юм.

Үүнээс цааших асуудал нь сурганы асуудал юм. Юут, хэрхэн заах тухай асуудал юм. Тэгэхдээ сургалт/хүмүүжлийн ажлын эцсийн үр дүн нь мэдлэг, чадвар, дадал байх учиртай.

## **2.9. Сурган хүмүүжүүлэх монгол уламжлалаас суралцах нь**

Боловсролын шинэтгэлд монголчуудын залуу үеэ төлөвшүүлж ирсэн зарчим, арга барилыг харгалзан үзэх нь үр дүнтэй. Монголчууд олон жилийн туршлага, дорнын ард түмний мэдлэг ухааны ололтоос суралцсантайгаа хослуулан ийм зарчмуудыг баримталж ирсэн байна. Ромын клуб орчин үеийн хүний нийгмийн шинж төлөвийг шинжлэн үзээд “хүмүүн байх шинэ аргад суралцах нь - Learning new ways of becoming human” хэмээх баримт бичиг гаргасны дотор өнөөгийн хүн төрөлхтний баримталж буй үнэт зүйлст шүүмжлэлтэй хандаж, улмаар “... уламжлалт мэргэн ухаан, тэргүүний шинжлэх ухаан, хүмүүнлэгийн туршлагын шинэ синтезийг эрэлхийлж, олон талт ертөнцөд хүсэн хүлээж буй ирээдүйг бий болгох боломжийг олно” хэмээн үзэж байгаагаа илэрхийлжээ. Монголын ард түмний үл хувирах үнэт зүйлс, хойч үеэ сурган хүмүүжүүлж ирсэн шилдэг уламжлал бол чухамхүү энд дурдаж байгаа “уламжлалт мэргэн ухаан” мөн.

Монголчуудын үр хүүхдээ сурган хүмүүжүүлэхдээ баримталж байсан бага наснаас нь сургаж, хүмүүжүүлэх, аливаа зүйлийн учир утгыг тайлбарлахын зэрэгцээ ажил хөдөлмөрөөр сургах, энэ явцдаа зөв зан төлөвтэй болгох, тоглоом зэрэг олон янзын арга хэрэгслийг ашиглах, хүүхдийн хүмүүжилд нийтээрээ анхаарах, гэр бүлийн үүргийг чухалчлах, хэт эрхүүлэхийг цээрлэхийн зэрэгцээ хайрлаж хамгаалах зэрэг зарчмууд нь орчин үеийн боловсролын номлол, олон улсын байгууллагаас гаргаж байгаа зөвлөмжүүдийн үзэл санаатай үндсэндээ тохирч байгаа юм.

## БҮЛЭГ 3

### СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛАМЖЛАЛ

Монголчуудын гэрийн хүмүүжил, боловсрол нь нэгд, ажил хөдөлмөрийн дадалтай болгож, хожим өөрөө амьдралаа авч явах чадвартай болгох, хоёрт, гэр бүл зохиож, үр хүүхдээ эрүүл энх өсгөн бойжуулах, сурган хүмүүжүүлэх чадвартай болгох, гуравд, олны дотор биеэ зөв авч явж, бусадтай харилцах зэргээр нийгмийн харилцаанд оролцох чадвартай болгоход чиглэж байжээ. Ийм гурван чадварыг эзэмшсэн байх нь нийгэмд бие даан амьдарч, амьдрал ахуйгаа үр дүнтэй авч явахад хангалттай байсан байна. Эрдэмтэн Ш.Сүхээ монголчууд “хүмүүжил” хэмээх нь “хүн” хэмээх ойлголтоос үүсвэрлэсэн байдаг тухай өгүүлээд эл хоёр нэр томъёо орос, англи, герман, франц, испани зэрэг бусад хэлээр ямар байдагтай харьцуулан үзэж, зөвхөн гагцхүү монгол хэлэнд л нэг үндэстэй байгаагаас улбаалан монголчууд хүмүүжлийн талаар өвөрмөц ойлголттой байжээ хэмээн дүгнэсэн байна (Ш.Сүхээ, 1988, 7). Монголчууд хүмүүжил гэдэг бол хүүхэд хүн болж төлөвших, хүмүүжүүлэх гэдэг бол хүүхдээр хүн хийх гэсэн үг хэмээн ойлгодог ажээ.

Монголчууд хүүхдийн хүмүүжил төлөвшил бүр бага наснаас нь эхэлдэг гэдгийг мэддэг байсан нь орчин үеийн сурган хүмүүжүүлэх ухааны зарчимтай нийцдэг билээ. Тухайлбал, хүнийг эхийн хэвлий дотор байх үеэс нь хүмүүжүүлэх ёстой гэж үзэж байжээ. Ч.Бат-Очирын бичсэн нь “Анхан эхийн умайд биеийн дүрсийг олсон цагт мэргэн эх нь бие шалтгаантай болоод сац хажуулан амуухгүй, далжийн суухгүй, хэлбийж зогсохгүй, нийлэмжгүй юмыг идэхгүй, ... исэр төвгүй бол суухгүй, нүд муу өнгийг үзэхгүй, чих хурьцангуй дууг сонсохгүй, өглөө үдэш уянгат шүлэглэлийг дуудуулан төв чигч хэргийг хэлүүлэн сонсож явбаас хөвгүүн төрөөд байдал төлөв төв, шударга, эрдэм хүнээс илүү болмуй хэмээжээ. Үүнийг хэвлий дотроос сургамуй хэмээжээ”

(Бат-Очир, 2005, 1) Ийнхүү хөл хүнд эх гэдсэн дэх хүүхдээ өөрийн явдлаар “хүмүүжүүлж” эхэлдэг байна. Төрсний нь дараа “хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” хэмээн үзэж хүүхдэдээ бараг л нялх үеэс нь зан заншлаа зааж, ажил хөдөлмөрт сургаж эхэлнэ. Төрсөн хүүхдийг угаах, даахийг нь авах зэрэг хүүхэд залуучуудын амьдралын онцлог үйл явдалтай холбоотой ёслол болоход тусгайлсан ерөөлийн үг хэлдэг нь хүүхдэд ямар хүн болох ёстойг бага наснаас нь ухамсарлуулж байдаг. Ийм ерөөлийн үгсийн жишээ гэвэл,

- Номонд мэргэн, нойронд сэргэн
- Дайнд баатар, далайд усч
- Үйлэнд уран, үгэнд цэцэн,
- Дээдэст зусаргүй, доодост доромжгүй,
- Ээж аавдаа ачлалтай, элгэн түмэндээ тустай
- Төрдөө түшигтэй, түмэндээ тустай гэх мэт.

Ийм ерөөл, сургаалын үгийг байнга хэлэх нь хүүхдийн ухамсарт түүний эзэмшвэл зохих сайн чанаруудыг суулгаж батжуулж байдаг байжээ.

Юуны өмнө хүүхдийг ажилсаг хөдөлмөрч, хөдөлмөрийн дадал чадвартай болгоход бага наснаас нь эхлэн сургадаг. Монголчуудад “аяга даахаасаа” эхлэн хөдөлмөрлөх гэдэг зарчим байдаг. Хүүхэд аяга даах тэнхээтэй болмогц эх эцэгтээ аяга, шанага бусад жижиг зүйлийг ойртуулах, хураах, угаах ажлыг хийж эхэлнэ. Ингэх нь хүүхдийг хөдөлгөөний эвсэлтэй, зүг чигийн баримжаатай, бусдад туслах эрмэлзэлтэй болгох зэрэг олон янзын чадвар, дадлыг олгоно. Улмаар нас ахих тусам хийх ажлын ачаалал, нарийн төвөгтэй байдал, юмыг өргөх, зөөхөөс гадна ажлыг яаж хийвэл зөв, үр дүнтэй болох талаар бодох сэтгэх чадвартай болгоно. Хүмүүжлийн эдгээр үйл явц нь “эрхийг сурахаар бэрхийг сур” хэмээх зарчмын дагуу явдаг байна. Хүүхдийг эцэг эхдээ эрхэлж зүгээр суух, дандаа тоглож наадаж цагийг дэмий өнгөрөөхийн оронд амар хялбараас эхлэн хүнд хэцүү ажлыг аль болохоор хийж сургахад хөтлөн, эцэг эх, ахмад хүмүүс өөрсдөө үлгэрлэн, үзүүлж зааж сургана. Т.Галсан нас ахих тусам хийж сурдаг ажлыг тоймлон бичсэн нь монголчуудын хүүхэд наснаас дайран өнгөрдөг амьдралын сургууль юм.

- 1-3 насанд ээждээ аргал хомоол, аяга шаазан дөхүүлж өгөх,
- 4-5 насанд хургачин,
- 5-6 насанд тугалчин,
- 6-8 насанд ботгочин,
- 8-16 насанд хоньчин,
- 17-оос дээш насанд адуучин нас залгадаг. (М.Төмөржав, Н.Хүрэлбаатар нараас дам эшлэв. 2017, 74)

Адуучин насанд хүрсэн болон түүнээс дээш насны залуучууд томчуудын адил ямар ч ажлыг хийх ба мал маллах, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, аян жинд явах, ан гөрөө хийх зэрэг бүхий л ажилд оролцож, бие даан хийж чаддаг болсон байжээ. Дээр үед арван долоо, найм хүрсэн эр хүн бол эр бие нь чангарсан, зориг зүрхтэй болсон, нум сум, илд жадаар тулалдах эрдэмтэй дайн тулаанд орох бүрэн бэлтгэлтэй болсон байдаг байжээ. Монголын нууц товчооноос үзвэл Тайчууд Тэмүжинг барихаар ирэхэд Бэлгүдэй мод хугалан шивээ барьж, Хасар тэдэнтэй харвалцаж, энэ хооронд Тэмүжин Бурхан Халдун уул руу зугтан гарсан байдаг. Тэр үед тэд одоогийн ойлголтоор бол бүгдээрээ насанд хүрээгүй хүүхдүүд байжээ. Тэмүжин цэрэг удирдан Мэргидүүдтэй тулалдаж, Бөртэ үжингээ буцаан авах тэр жил 17 той байжээ. Аяга даах наснаас эхлэн ийнхүү ажлын төрөл, ачааллыг нэмж, алгуур ажил хөдөлмөрт сургах нь хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлнэ. Аль ч үндэстэн үр хүүхдээ нялх балчир үед нь хайрлаж, халамжилж өсгөдөг. Монголчууд мөн ялгаагүй. Гэвч нөгөө талаар хойч үеэ хожмын амьдралд нь бэлтгэх ёстой гэдгийг үл мартан сургаж, хүмүүжүүлэхийн зэрэгцээ үр хүүхдэдээ бие даан амьдрах хорвоогийн жамыг ойлгуулан тэр үед хэрхэн яаж аж төрөх нь хүүхэд насандаа ажил хөдөлмөрт хэрхэн суралцахаас хамааралтай гэдгийг ягштал ойлгуулахыг хичээнэ. Тийм учраас “өглөөний нарыг наранд бүү бод, өсөхийн жаргалыг жаргалд бүү бод” хэмээн сургаж, хүмүүжлийн зарчим болгон мөрдөнө. Үүний зэрэгцээ залхуу хойрго, хөдөлмөрч биш байвал амьдралд нь ямар хортой болохыг хэлж, жигшүүлнэ. Үүнд “залхуугийн гэрт түлшгүй, залгидгийн гэрт хоолгүй”, “их залхуугаас бага залхуу” гэх мэтээр ухуулж сургана. Монгол ардын энэ мэт зүйр цэцэн үгс

нь зүгээр нэг цэцэрхсэн хэрэг бус амьдралд дагаж мөрддөг зарчим байдгаараа онцлог юм.

**Гэр бүлийн амьдралд сургах.** Хүүхэд тав орчим настайгаасаа эхлэн дүү нараа харах хамгаалах үүрэг хүлээнэ. Томчууд завгүй ажилтай байх үед дүү нараа харж, дааруулахгүй, халууцуулахгүй, адуу малын хөлд оруулж гэмтээхгүй, өлсгөж, цангуулахгүй байх үүргийг хүлээнэ. Дүү нь ямар нэг шалтгаанаар уйлж эхэлбэл янз бүрийн аргаар түүнийг аргадаж, тайвшруулна. Өдөрт нялх дүүгээ үүрч, шөнөд өвөртөлж унтана. Эрэгтэй нь эцгийгээ дагаж эр хүн гэр бүлийнхээ сайн сайхны төлөө хүлээдэг өрхийн тэргүүлэгчийн, эмэгтэй нь ээжийгээ дагаж гэрийн эзэгтэй хүний үүргийг гүйцэтгэж сурна. Энэ бүхэн хүүхэд залуучуудад хэт нь өөрөө өрх гэрээ үүсгэж, аж амьдралаа авч явах, үр хүүхдээ эрүүл өсгөн бойжуулах, хүмүүжүүлэх сургууль болдог байжээ. Хуучин цагт залуус хорь хүрээгүй шахам насандаа эрт гэр бүл болдог байсан боловч эр нь гэр бүлд эрэгтэй хүний гүйцэтгэх ёстой үүргийг, эм нь эмэгтэй хүний гүйцэтгэх ёстой үүргийг хүлээхэд бэлэн болсон байдаг байжээ. Хүн том хүүгээсээ эхлэн гэрлүүлж, өмч хөрөнгө тасалж өгөөд, аж амьдралаа хэрхэн авч явааг нь дэргэдээс нь харж, шаардлагатай үед туслах, зааж зөвлөх зэргээр амьдралын замд нь оруулж зүгшрүүлнэ. Эцэст нь отгон хүү нь аав ээжийн дэргэд үлдэж, гэрийн сургууль төгсөөд, гал голомтоо залган авдаг байна. Ээж хүн охиноо эрд гарах нас дөхөөд ирэхээр айлын эзэгтэй ямар байх талаар зааж сургана.

**Нийгмийн амьдралд сургах.** Монголчууд хүүхэд залуусаа олны дотор биеэ зөв авч явж, байр суурь эзлэн нийгмийн гишүүн болгохын тулд хэд хэдэн зүйлийг ойлгуулж, зан үйлд нь дадал хэвшил болгосон байдаг. Үүнд:

Нэгд, нийгмийн хэм хэмжээ, ёс заншлыг мэддэг, сахидаг болгох,

Хоёрт, бусадтай эвтэй найрамдалтай байх,

Гуравд, нутаг усныхандаа тустай байх,

Дөрөвд, ахмад хүмүүсийг хүндэлж, үг сургаалыг нь сонсох, тэднийг ачилж халамжлахад сургахыг чухалчилна. Нийгэм, олны дотор биеэ зөв авч явах, нэр төрөө хайрлах, зөв түвшин ярих, зан заншлаа ягштал баримтлан зөв явах, суухыг хүртэл зааж сургана.

Ахмад хүний дээр гарч суух, түрүүлж дуугарах, үг сөрөх, айлын гаднаас мордонгуут мал хар, хүүхэд багачууд дайрчих шахан түргэн давхих, мал сүргийг сандарган үргээх, хөөх туух, танхай балмад, зусарч бялдууч, харамч, аминчхан, ховч зан ааштай байхыг хориглоно. Үнэнч шударга, даруу төлөв, ёсорхог, тусархаг шинж чанарыг эрхэмлэнэ. Ард түмний эрхэмлэдэг нандин зан заншлыг дагаж, цээрлэдэг муу болгоныг жигшин явах нь нийгэмд биеэ зөв авч явах, бусадтай эвтэй найртай байж нэр төрөө цэвэр байлгах үндэс болно. Тийм учраас хүүхэд залуучуудад “нэр хугарахаар яс хугарсан” нь дээр, “хүн нэрээ, тогос өдөө хайрладаг” гэх мэтээр сургадаг байна. Монгол хүн зөвхөн өөрийн төдийгүй эцэг эхийн нэрийг цэвэр байлгахад үлэмжхэн анхаардаг. Эцэг эхийн нэрийг нас барсан хойно нь ч хайрлан хамгаална. Тиймээс ямар нэг хүн муу үйлдэл гаргавал “эцэг эхийнхээ ясыг өндөлзүүллээ” хэмээн ихэд буруушаана.

Бусадтай эвтэй найртай байх, хамтрахын ач тусыг хойч үедээ ойлгуулахад ихэд анхаарч иржээ. “Олны хүч оломгүй далай, цувж явсан барсаас цуглаж суусан шаазгай дээр” гэх мэт цэцэн үг нь ард түмний амьдрал, туршлагаас үүдэлтэй, гүн гүнзгий санаатай зарчмууд юм. Нутаг усныхантайгаа эвтэй, үеийнхэнтэйгээ нөхөрлөж, нөхөр журмын ариун ёсыг сахих нь чухал. Ялангуяа хүнд тустай байж “нөхрийн хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ”, “нөхрийн төлөө боол болох” гэх мэтийн сургаалыг дагаж, ядарсан зүдэрсэн хүмүүст бага боловч тус болохыг хичээх ёстой. Бусдад тус болж чадахгүй, боломжгүй хүн гэж байдаггүй. Ямар ч ядуу зүдүү, эгэл дорой хүнд сэтгэл байвал бусдад тус болох боломж бий. “Тэнхлүүн явахад тэмээн чинээ тус хүргэснээс, тэвдэж явахад тэвнийн чинээ тус хүргэ” гэдэг нь чухам энэ тухай сургаал юм. Тиймээс үеийн хүмүүстэй анд, нөхөр болох, хуурай дүү ах эгч болох гэх мэт заншил эртнээс буй болж, үндсэн агуулга нь одоо хүртэл хэрэглэгдсээр байна.

Монголчууд хүүхэд залуучуудаа нийгэмд биеэ зөв авч явах, байр суурь эзэлж амьдрах тухай асуудалд төр улсдаа тустай байхыг бас багтаадаг онцлогтой юм. Тиймээс гэрлэж өрх гэр үүсгэх, өрх гэрээ өнгөтэй өөдтэй авч явахыг хүн бүрийн төр улсдаа тус хүргэх анхдагч чухал үүрэг гэж үзнэ. Монголчуудад “төрийн төлөө оготно

боож үхэх” гэдэг үг байдаг. Энэ нь хүн өөрийгөө оготно шиг өчүүхэн амьтан гэж үзлээ ч гэсэн төрийнхөө хэрэгт оролцдог байх ёстой гэсэн үг билээ. Монгол хүн бурхан тэнгэр, лам багш, савдаг нявдаг гээд олон зүйлд залбирдгийн дотор төрийнхөө сүлдэнд залбирдаг. Ийнхүү төрөө дээдлэх үзлийг хүүхэд залуучууддаа бага наснаас нь эзэмшүүлдэг нь тэд улмаар “төрийн төлөө боож үхэх” хүртлээ төр улсдаа хүчин зүтгэх хүмүүжилтэй болгодог байжээ. Хүүхэд залуучуудыг нийгэмшүүлэхийн тулд хүнтэй танилцуулах, жин тээхэд оролцуулах, хол газар аялуулах зэрэг арга хэрэглэнэ. Түүний тулд “аавын бийд хүнтэй танилц, агтын бийд газар үз” хэмээн сургана. Монголчууд эртнээс нааш “гэрээс гарахгүй, гэдэс алдахгүй” суугч эр хүнийг муу эрд тооцож шүүмжилдэг байв. Монголын нууц товчоонд Хүчүлүг хан Таян ханыг шүүмжлэн

Хүнд эмийн шээх газар эс гарсан

Хүрдний тугалын бэлчээрт эс хүрсэн” хэмээн хэлсэн тухай дурдсан билээ. Ард түмэн бас “эмээлээсээ өндөр даваа даваагүй, эхнэрээсээ өөр хүнтэй танилцаагүй” хэмээн шоглодог. Хүнтэй харилцах эрдэмд суралцан, хол ойр явж орчлонгийн сайн муутай танилцах нь хүний аж амьдралаа авч явах чадварыг хөгжүүлдэг байна. Хүнтэй танилцаж анд нөхөр бололцон бусдад туслан өөрөө гэднээс тусламж авдаг байх нь хүний боломжийг үлэмж нэмэгдүүлнэ. Тиймээс ард түмэн “танилтай хүн талын чинээ, танилгүй хүн алгын чинээ” хэмээн үзэж, хүнтэй танилцаж, анд нөхөр болохын ач тусыг хүүхдэд ойлгуулдаг байна.

*Байгаль орчинтой зөв харилцаж сурах.* Монголчуудын хүүхэд залууст зааж сургадаг, хэвшүүлдэг зан үйлийн дотор байгаль орчин, мал амьтанд хандах зөв хандлага, тэдгээрийг хайрлах хамгаалах асуудал томоохон байр эзэлнэ. Үүнтэй холбоотой зан заншил, хэм хэмжээ ч баялаг юм. О.Амархүү байгаль орчныг хамгаалах уламжлал гэдэг бол “улс үндэстэн, нутаг усны үндсэн хүн ам, оршин суугч, ард иргэдийн дунд хэвшин тогтсон бөгөөд ёсчлон дагаж биелүүлдэг, өвөрмөц онцлогоороо ялгаран давтагдаж байдаг зан үйлийн нийлбэр, мэдлэг, соёл, ухаан мөн” хэмээн тодорхойлоод монгол байгалиа хамгаалж, дээдлэх зан заншлын уламжлалыг

- Энэрэл хүндэтгэлийн

- Хорио цээрлэлийн
- Сургаал номлолын
- Сүсэг бишрэлийн
- Ажиглалт танин мэдэхүйн хэмээн ангилсан байна (О.Амархүү, 2022, 27)

О.Амархүү байгаль орчныг хамгаалах уламжлалыг “хамгийн товчоор бол байгаль орчин, оюун ухаан хоорондын шүтэлцээт холбоо юм” хэмээсэн нь маш гүнзгий утгыг агуулж байна. Байгаль хамгаалах нь хүн байгалийн хүйн холбоог таслахгүй гэсэн санаа аж. Эл холбоо сулрах, тасрахад хүрвэл байгаль байгаль биш, хүн хүн биш болох нь. Хүүхдийг төрсний дараа хүйг нь ёс төртэйгөөр газарт булдаг учраас монгол хүн эх нутагтайгаа шууд утгаараа хүйн холбоотой байдаг гэж үзэж болно.

**Сурган хүмүүжүүлэх арга барил.** Монголчууд хүүхэд залуучууддаа эзэмшүүлэх зан чанарын талаар мэдлэг хуримтлуулаад зогсохгүй ийнхүү сурган хүмүүжүүлэх арга барилын талаар туршлагажиж амьдрал үйлдэлдээ хэрэглэж ирсэн юм. Тэдгээрийн заримыг нэрлэвэл:

- Хөдөлмөрөөр хүмүүжүүлэх
- Биеэр үлгэрлэж хүмүүжүүлэх
- Үг, сургаалаар хүмүүжүүлэх
- Тоглоом, наадмаар хүмүүжүүлэх
- Хайрыг дотроо хадгалж, халыг гаднаа үзүүлж хүмүүжүүлэх
- Ардын аман зохиол, үлгэр домог түүхээр хүмүүжүүлэх
- Хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэхэд нутаг нугаараа хамтран хүмүүжүүлэх зэргийг дурдаж болно.

Хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэхэд эцэг эх, ахмад хүмүүс биеэр үлгэрлэдэг байжээ. Тийм ч учраас “эх нь хээр алаг бол хүү нь шийр алаг” хэмээн хэлэлцэнэ. Энэ нь адуугаар жишин зүйрлэж хүүхэд бол эцэг эхээ зөвхөн зүс царайгаараа төдийгүй, зан ааш, ажил хөдөлмөрт хандах байдлаараа тэдэнтэйгээ төстэй байдаг хэмээн үзэж байгаа хэрэг юм. Тиймээс хүүхэд нь өсөж том болоод амьдралын ханиа сонгох цаг болоход сонгосон хүнийх нь удам угсааг судлан, зөв сонголт хийх талаар зөвлөж иржээ. Эцэг эх ч алс нь үр хүүхдээ муу хэлүүлэхгүйн тулд тэдний хүмүүжилд онцгой

анхаарна. Хүүхэд залуучуудыг малчин монгол хүн бүрийн хийдэг ажил хөдөлмөрт сургахаас гадна эцэг эх өөрөө дагуулан дархан мужаан, уран үйлч, дууч, туульч зэрэг өөрсдийн онцгой авьяасаа өвлүүлэн үлдээхийг хичээдэг байжээ.

Хайрыг дотроо хадгалж халыг гаднаа үзүүлж хүмүүжүүлэх гэдэг нь маш чухал зарчмын нэг юм. Эцэг эх нь үр хүүхдэдээ ажилч хөдөлмөрч, төлөв даруу гэх мэт сайн чанаруудыг эзэмшүүлэх, бурууг засаж, зөвд чиглүүлэхийн тулд түүнд хатуу хандах боловч хайртай гэдэг нь хүүхдэд үргэлж мэдрэгдэж байх нь эл зарчмын агуулга юм. Хал нь гаднаа гэдэг бол хүүхдийнхээ үйл хөдлөл, ааш зан, алдаа эндэгдэлд шударга хандаж зөвийг ойлгуулах явдал юм. Хүүхэд эцэг эхдээ зэмлүүлж, зарим тохиолдолд “алган боов” амслаа ч гэсэн аав нь, ээж нь түүнд хайртай гэдгийг мэддэг, сэтгэл зүрхээрээ мэдэрдэг учраас гомдохгүй, буруугаа ойлгож, засахыг хичээнэ. “Алган боов” амсуулах гэдэг бол “зодох” гэдгээс өөр ойлголт юм. Монголчууд хүүхдээ гэмтгэл зодох, эмзэг газар руу нь цохих зэргийг цээрлэнэ. “Алган боов” нь зарим тохиолдолд зүгээр л сэтгэл зүйн арга хэмжээ байдаг. Тиймээс “цохихоосоо далайх нь” хэмээх үг гарчээ. Хүмүүжлийн энэ арга бол хүүхдийн болон эцэг эхийн аль алиных нь сэтгэцэд буй ачааллын тайлал болдог. Тэдгээрийн хооронд бий болох магадлалтай хана хэрмийг нурааж байдаг бололтой байдаг. Хүүхэд залуусыг хүмүүжүүлэх нь хайрлах, халамжлах, удам судраа танин мэдэх, хамгаалах гэх мэт хүн хоорондын нандин холбоо, сэтгэл зүйн харилцан үйлчлэл, бүр томоор яривал оршин тогтнох, зохицохуйн хэрэгцээ шаардлагаас үүссэн, хууль дүрмээс өргөн хүрээтэй хэм хэмжээ, арга хэрэгслээр хэрэгждэг нарийн төвөгтэй үйл ажиллагаа юм.

Хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх арга барилын нэг нь урамшуулах, зохих цагт нь магтах явдал юм. Тиймээс “урмыг нь хугалахаар ууцыг нь хугал” гэсэн хэлц үг гарчээ. Ууц хугалах нь хүний амийг егүүтгэх гэсэнтэй бараг л дүйх үг юм. Хүний урмыг хугалах нь ийм хэцүү зүйлтэй зүйрлэхээр хортой байх нь. Хүүхдийг “эртгэч”, “ажилсаг”, “малд нүдтэй” гэх мэтээр магтана. Тэгэх тусам хүүхэд өглөө эрт босохыг чармайж, ажил хөдөлмөрт шамддаг.

Монголчууд хүүхдийг сурган хүмүүжүүлэхдээ тоглоомыг чадамгай ашигладаг байжээ. Маш олон төрлийн тоглоом, наадгай

байсан нь сургалт, хүмүүжлийн их нөлөөтэй байсан байна. Дараах хүснэгтэд зарим жишээг харуулав.

*Монголчуудын тоглоом, түүний нөлөө*

<i>тоглоом</i>	<i>Бие бялдрыг хөгжүүлэх</i>	<i>Сэтгэхүйг хөгжүүлэх</i>	<i>Өвсгөө самбаатай болгох</i>	<i>Өгүүлэх чадварыг хөгжүүлэх</i>	<i>Ёс заншлыг таниулах</i>	<i>Зан аашийг төлөвшүүлэх</i>
Чулуугаар гэр барих					+	+
Шагай шүүрэх	+		+			+
Хар цагаан ялгах	+		+			+
Барилдах, уралдах	+					+
Дайралцаа		+		+	+	+
Дэмбээ	+	+	+	+		+
Үлгэр ярих, цээжлүүлэх		+		+	+	+
Онъсого		+				+
Таавар		+			+	+
12 жил, үүчүүр		+			+	+
Хөлөгт тоглоомууд		+			+	+

Тоглоом бүр өрсөлдөөний шинжтэй байдаг учраас хүүхдийн сэтгэл хөдлөл, зан төлөвийг зөв төлөвшүүлж байдаг. Онъсого гэхэд юмс үзэгдлийн төстэй тал, онцлогийг ажиглах мэдрэх чадварыг дээшлүүлдэг бол таавар нь логик сэтгэлгээг хөгжүүлдэг аж. Хөлөгт тоглоомууд ихэвчлэн төвөгтэй байдалд зөв гаргалгаа хийх чадварт сургаж байдаг байна.

Сурган хүмүүжүүлэх ухааны бичмэл ном зохиолын өв. Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн зарчим, хүн юуг эрхэмлэж, юуг жигшиж явах ёстойг Чингис хааны билэг сургаалууд, Оюун түлхүүр, То вангийн сургаал зэрэг бичмэл ном сударт тодорхойлж, үеэс үед дамжин гарын авлага болсоор иржээ. Тухайлбал, нийгмийн дотор биеэ зөв авч явах, бусадтай эвтэй найртай байх талаар Чингис хааны билиг сургаал, Чингис

хаан зохиосон гэх “Оюун түлхүүр” хэмээх сургаалын номд хэрхэн өгүүлсний заримыг нь үзье.

- Түргэн зуур ханилсан нөхөрт яаран бүү уурла  
 Үргэлж ханилж, тэнсэн мэд  
 Нэгэнтээ ханилсан хойно яаран бүү сал  
 Итгэсэн хойно үгээ бүү нуу  
 Итгэлгүй хүнд зүрхний үгээ бүү хэл
- Хилэн ихтийг аргаар өнгөрүүл  
 Хилэнц ихтийг номоор тэтгэ
- Ханилсан нөхрөө хуурваас  
 Харин биеэ хуурсан адил больюу  
 Үнэхээр барилдсан сайн нөхрийн үгсийг  
 Үхтэл бүү март  
 Хагацашгүй сайн нөхөрт  
 Маргашгүй муу үгийг бүү хэл
- Авсан ам тангаргийг амь мэт сахь  
 Арга заль хоёрыг угаас орхи  
 Аливаа хүмүүн лүгээ нийцэн зохь
- Өөрийн хэргээ орхиж  
 Үнэн санаагаар зүтгэж  
 Ил далд магтах ба  
 Муушаахыг үл бодон  
 Олзонд шуналгүй  
 Нэгэн зоригоо хугалалгүй  
 Ер уйдаа чилэхийг саналгүй  
 Хэв хэзээд цөхрөлгүй  
 Зовох цагт зайлалгүй  
 Жаргах цагт хэтрэлгүй  
 Хайрлах цагт дасалгүй  
 Халдах цагт гуталгүй  
 Насан үргэлжид нэгэн зангаар явбал  
 Улам хойтдоо хөгжих болмуу
- Ер хоёр хүн эвтэй болбоос  
 Төмөр хүрээ мэт бэх  
 Хорин хүн эвгүй болбоос  
 Эвдэрхий хүрээ мэт хэврэг.

- Биеийн бөхөөр ганцыг ядьюу,  
Эеийн бөхөөр олныг яльюу.
- Холын хүнд өршөөл тус хүргэвэл  
Алдар нэр дуурсмуй  
Ойрын хүнд асрал өглөгийг хүртээвээс  
Эв эе бүтээд хүч нэмнэ.  
Харийн газарт арга чадлаа бэхэл  
Халуун зуураа эв эеэ хичээ.

Бусадтай эвтэй найртай байх, өөрөө зөв явдалтай байхын тулд үргэлж сэрэмжилж байх учиртай. Иймээс:

- Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн  
Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун  
Олны дотор үгээ бэхэл  
Ганцаар суухуйд сэтгэлээ шинжил хэмээн сургажээ.

Хүний амьдралд сайн муу олон явдал тохиолдох учраас

- Жаргах цагт сэрэх хэрэгтэй  
Зовох цагт хатуужих хэрэгтэй.

Тавьсан зорилгоосоо ухарч няцалгүй, тууштай хэрэгжүүлдэг байх хэрэгтэйг сурган

- Чанд зорьсон үйлсээ  
Чулуунд цавчсан бичиг мэт болгоюу  
Чин баталж хэлсэн үгээ  
Чухал аминдаа хүртэл үл буцмуй.
- Өндөр уулын хөтөл зорь  
Өргөн далайн олом зорь.  
Хол гэж бүү цөхөр  
Явбаас хүрнэ.  
Хүнд гэж бүү цөхөр  
Өргөвөөс даана.  
Давшгүй даваа гэж сонстох  
Хэр давна бүү сэтгэ  
Даван сэтгэвээс давна.  
Гэтэлшгүй мөрөн хэмээн сонстох  
Гэтлэн сэтгэвээс гэтлэх.

Энд зорилгодоо хүрэхийн тулд тууштай байхаас гадна аливаа үйлийг хийхдээ бэрхшээлгүй, сэтгэлийн тэнхээтэй байхыг сургасан байна. Ер нь монголчууд сэтгэл зүй сайн мэддэг, мэтгэл зүйн хүчин зүйлийг ашиглаж чаддаг байсан. Тиймээс ч “биеийн бөхөөр нэгийг ялна, сэтгэлийн бөхөөр олныг ялна”, “сэтгэлийг нь авбал, бие нь хаа зайлах вэ” гэх мэт олон сургаал бий.

Аливаа юмны тун хэмжээг тааруулж, ухаалаг ханддаг байх хэрэгтэйг сурган:

- Алтан дэлхийг өргөстэй гэж бүтээж үл болох  
Харин өөрийн хоёр хөлийг бэхэлсэн нь дээр.
- Арслангийн омог баатар, арсландаа зохих  
Үнэгний уран арга мөн үнэгэндээ зохих  
Арслангийн баатар омог үнэгэнд тусгүй.  
Үнэгний уран арга арсланд тусгүй.  
Арслан үнэг мэт явбал түргэн гутах  
Үнэг арслан мэт явбал түргэн үхэх

Чингис хааны билиг сургаал нэрийн дор олон хувилбараар хадгалагдаж ирсэн эдгээр зохиол нь олон үе дамжин хадгалагдаж, баяжиж, бас ч тухайн нийгмийнхээ үзэл санааг шингээсэн байдаг учраас дотор нь буй “мөнхийн “ гэж болох үнэнийг шүүн тунгааж, хэрэглэх нь зүйтэй юм. Энэ сургаалд эцэг эх, төрөл төрөгсдөө хайрлах, шударга байх, хүнийг таньж нөхөрлөх, эрдэм номд шамдан суралцах талаар сургасан нь маш гүн гүнзгий агуулгатай юм. Дээр дурдсан болон энд дурдагдаагүй сургаалууд нь Монгол хүн чухамдаа ямар шинж чанартай байх вэ гэдгийг тодорхойлсон зүйлс юм.

Монголчуудад хүүхэд залуустаа амьдралын үнэнийг таниулах, нийгмийн хэм хэмжээг ойлгуулж ухамсарлуулах, зөвийг дадуулж, бурууг жигшүүлэхэд чиглэсэн зүйр цэцэн үгс далай мэт арвин билээ. Түүнчлэн аливаа үлгэр домог сургаалын агуулгатай байдаг. Цэцэн үг, сургамжит үлгэрүүд нь хүүхэд, залууст насны багад эрдэм сурах, бусадтай эвтэй байх, нэр төрөө хайрлах, бусдад тустай байх, тэсвэр тэвчээртэй байх, ажилсаг байх гэх мэт хүний сайн сайхан зан төлөвийг эзэмшүүлэхэд чиглэсэн байдаг. Нас насны онцлогт нийцсэн эдгээр сургаалыг гүнзгий судалж гүн ухааны нь баялгийг ухан гаргавал түнээс бүрэн цэгцтэй боловсролын философи гарах боломжтой юм. Хүнийг бага балчир насанд:

“Өглөөний нарыг наранд бүү бод  
 Өсөхийн жаргалыг жаргалд бүү бод”  
 “Эрхийг сурахаар, бэрхийг сур”  
 “Дуслыг хураавал далай  
 Дуулсныг хураавал эрдэм” гэх юм уу өсөх тусам лавшруулж  
 “Ажил хийвэл дуустал нь  
 Давс хийвэл уустал нь”  
 “Аавын буйд хүнтэй танилц,

Агтын буйд газар үз” гэж сургана. Ер нь монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны онцлог нь одоогийн хэлээр яривал хүүхдийн хөгжлийн үе шатыг сайтар харгалздаг байсан нь юм.

Хожим хүүхэд залуучуудын хүмүүжилд зориулсан олон зохиол гарсны дотор 1735 онд гарсан “То гүнгийн гурван үсэгт ном”, Данзанравжаагийн “Цагийн жамыг тодруулагч цаасан шувууны үлгэр”, “Залуу охид, хөвгүүддээ захисан үгийн товч”, “Сэтгэлийг амраагч хэмээх сургаал”, “Нэгэн үсгийн эрдэм”, “Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг”, “Товагийн гэгээний сургаал буюу тоть шувууны үлгэр”, Ч.Дэмчигдоржийн “Бурханы их хөлгөн номын журмыг батжуулсан ертөнц дахиныг сургах эрдэнэт толь”, Ч.Бат-Очирын “Мандах нарны туяа” гэх мэт хүмүүжлийн сэдэвтэй сургаалын зохиолууд олноор гарч байжээ. Ер нь монгол үлгэр, домог бүхэлдээ хүмүүжлийн холбогдолтой сургаалууд байдаг. Зохиолууд үлгэр, шүлгийн хэлбэртэй, ойлгомжтой байдгаараа онцлог юм.

Монголын бичгийн хүмүүс сурган хүмүүжүүлэх монгол ухаан, дорно дахины бусад ард түмний шилдэг өв, бурхны шашны номлол зэргийг авах гээхийн ухаанаар тунгаан сайн хүний загвар маягтай дүрмийг боловсруулан хэрэглэж байжээ. “Хаан хүний 35 эрдэм”, “түшмэл хүний 9 эрдэм” гэх мэт дээдсийн баримтлах ёс, шинж чанарыг илтгэсэн зохиолоос гадна, эцэг эхийн ачийг хариулах ёс, ахчлах дүүчлэх ёс, сайн эхнэрийн, сайн хүүгийн, сайн бэрийн шинж гэх мэт маш олон загварын шинжтэй сургаалыг боловсруулан залуусыг сургадаг байжээ. Үүний заримаас дурдвал:

*Эх хүний есөн эрдэм:*

1. Өнгөнд цэвэр
2. Үйлэнд уран

3. Үрд энэрэлтэй
4. Үргэлж цэмцгэр
5. Ханьдаа түшигтэй
6. Хадамдаа элэгтэй
7. Найранд дуутай
8. Настанд ерөөлтэй
9. Нартад буянтай

*Эрхэм сайн охины шинж:*

Сайхан гоо зүстэй бөгөөд  
 Санаа сэтгэл номхон дөлгөөн  
 Саруул ухаантай охин сайн  
 Эхийн сургаалаар явагч  
 Эгч дүүтэйгээ эвтэй  
 Эсгэх оёход уран бол  
 Эрхэм сайн охин мөн  
 Алиа наадгайд дургүй  
 Ахуй биеэ хичээн хадгалаад  
 Ахас ихсийг зэргээр хүндлэгч  
 Уур хилэнгүй охин сайн

Монголын бичгийн мэргэдийн зохиолоос хүмүүжлийн агуулгатай заримыг нь дурдвас юуны өмнө Д.Равжаагийн (1803-1856) зохиол бүтээлд сургаалын шинжтэй олон зүйл агуулагдсан байдаг. Түүний “Цаасан шувууны үлгэр”-т шувуу нисгэгч хүн нэгэн хүний асуултад хариулсан нь байдаг. Жишээ нь,

Ямар юм муухай вэ гэхэд  
 Үл мэдэгч муухай гэв.  
 Юу сайхан бэ гэхэд  
 Саруул ухаан сайхан гэв.  
 Юу хортой вэ гэхэд  
 Өст сэтгэл хортой гэв.  
 Юу тустай вэ гэхэд  
 Сайхан сэтгэл тустай (Сүхээгээс дам эшлэв. 38)

Д.Равжаа лам хүний хувьд элдэв нүгэл хийхгүй байх, бурхан шашиндаа сүсэглэхийг сургахын зэрэгцээ онч мэргэн сургаал үгсийг айлдаж, сургамжилсан нь түүний шүлэг зохиолд элбэг байдаг.

“Эх дэлхийг амьтан бүхэн гишгэлэх  
 Бага насыг хүн бүгд дайрах  
 Биеийг дагасан сүүдэр нөхөр үл болох  
 Насыг дагасан омог дайсныг үл дарах” (Энэ хойдыг бодож  
 өгүүлэх нь хэмээх шүлэг) гэсэн нь бага наснаасаа найз нөхөртэй  
 болох, гэнэн залуу насандаа хэт омог бардам байхыг жигших  
 санааг агуулсан байна. Монголчууд хүний амьдралыг жилийн  
 дөрвөн улиралтай жишиж, бага залуу насандаа хэрсүү ухаантай  
 байж, амьдрал ахуйгаа тохинуулахыг сургамжилсан нь элбэг.  
 Равжаа хутагт ч ийм сануулах шүлэг бичсэн байна.

“Эсэргэн хавар цагийн дохио ирэхэд  
 Эгшиглэн донгодогч олон шувуу жиргэлдэн  
 Ээлжлэх цагийн эргэлтийг мартаад  
 Эгүүрд байгаа хэлбэртэй байдаг л  
 Энхрийлэн өсгөсөн аав эжийн хайранд  
 Эрхэлж өссөн жаргалдаа ташуураад  
 Элдэв наадам тохууныг даган явсаар  
 Эргээд ирэх дөрвөн далайн жамыг эс мэдэв л” (*Дөрвөн улирал  
 хэмээх шүлэг, Данзанравжаа, 2011, 184*)

Эрс тэс уур амьсгалтай цаг агаар бүхий монгол орны хүүхдүүдэд  
 ийнхүү дөрвөн цагийн ээлжийг сануулах нь хамгийн ойлгомжтой  
 жишээ болдог байснаас сургаалын энэ аргыг ихэд хэрэглэдэг  
 байжээ.

“Тоть шувууны сургаал”-д сайн эр, эхнэр, хүүгийн талаар  
 шүлэглэн өгүүлсэн байдаг. Уг сургаалыг Ц.Дамдинсүрэн  
 гадны зохиолын орчуулга бус, харин монгол хүн монгол хэлээр  
 зохиосон хэмээн үзсэн байдаг. Тэрбээр уг зохиолыг хэн бичсэн нь  
 тодорхойгүй бөгөөд Товагийн гэгээн гэгч хэн болохыг бас олоогүй  
 аж. Уг зохиолыг лам хүн бичсэн бололтой хэмээн таамаглажээ.  
 Одоо уг зохиолын зарим хэсгийг үзье.

“Эрдэмтэй сайн явдлаар яван, энэ насанд үл эндүүрэн, эцэст  
 сайн алдар дуурсгагч эр хүний сайн явдлыг өгүүлсүгэй.  
 Эгнэгт сүжиглэн буяныг санаж, эд малаа энхрийлж хичээн,  
 эцэг эхийн сургаалыг авсан, энхрий шударга түвшин ард  
 лугаа нэг.  
 Ажил байдлаа алдалгүй арвижуулаад, адгуус малаа үргэлж

өсгөөд, алба татвараа саадгүй төлөөд, ажиггүй сайн суугч ард лугаа хоёр.

Гэргий хөвүүнээ тэтгэн чадагч, гэнэдэж буруу үг үл хэлэгч, хэнд ч ялгалгүй сайхан аашлагч, хэрсүү сайн ард лугаа тав.

Аж төрөхийн явдалд маш мэргэн, ашид хулгай худалд дургүй бөгөөд, уургүй номхон бөгөөд арга сайтай ард лугаа зургаа.

Алс хойтын хэргийг бодогч, архи дарсыг уухуйд дургүй, ач дүү нараа зөв сургагч, ашид хичээнгүйт ард лугаа долоо.

Зорчин явбаас олз ологч, зориглосон хэргээ бүтээгч, зогсож хожимдон үл хоцрогч, зориг сайт ард лугаа найм болмуй.”

Түүнчлэн сайн эхнэр, хүү, охины шинжийг бас дурдан сургасан байдаг. Тухайлбал,

*“Эрхэм сайн хөвүүний ёс нь:*

Эцгийн сургаалаар явагч, эрдэм билэг сурахад дуртай, энхрэх ухаантай хөвүүн лүгээ нэг.

Ах дүү хэнд ч аятай, алинд зарваас ялгуум сайн, ааль зан нь дөлгөөн номхон, уургүй шударга хөвүүн лүгээ хоёр.

Алиа найдангуйгаар үл явагч, арга санаанд цэцэн сайн, аж төрөхөд маш зүтгэлтэй, ашид бүтэмжтэй хөвүүн лүгээ гурав болмуй.”

*“Сайн охины ёс нь:*

Сайн сайхан гоо зүстэй бөгөөд санаа сэтгэл нь номхон дөлгөөн, саруул ухаантай охин лүгээ нэг.

Эхийн сургаалаар явагч, эгч дүү лүгээ эетэй, эсгэх оёхуйд уран, эрхэн сайн охин лугаа хоёр.

Алиа найдангуйд дургүй, аху биеэ хичээн хадгалаад, ах ихсийг зэргээр хүндлэгч, уур хилэнгүй, ааль сайтай охин лугаа гурав болмуй.” (Ц,Дамдинсүрэн, ЭШБЧ Ү, 204-207)

Уг зохиолд ийнхүү хүний сайн шинжийг дурдахын зэрэгцээ жигшвэл зохих муу шинжүүдийг ч бас дурдан сургасан байна.

Нутаг орноо хөгжүүлэх, соёл боловсролыг түгээх, албат ардуудаа ажилсаг хөдөлмөрч болгох талаар их ажил хийсэн хүн бол Монгол улсын түүхнээ Халхын хэцүү То ван хэмээн мөнхрөн алдаршсан Бат-Очирын Тогтохтөр (1797-1868) байжээ. То ван хошуундаа олон төрлийн шинэтгэл хийсний дээр ардуудад

зориулсан сургаал бичиж үлдээсэн хүн юм. Түүний сургаал гар бичмэл байдлаар Монгол Улсын Үндэсний номын санд хэд хэдэн хувилбартайгаар хадгалагдаж байна. Бусад зохиогчдын бичсэн сургаал гол төлөв ёс суртахууны чиглэлтэй байдаг бол То вангийн сургаал нь хүмүүсийг ажилч хөдөлмөрч байж, амьдралаа зохих ёсоор авч явахад зориулсан байдгаараа онцлог юм. То вангийн сургаалыг судалсан Ш.Нацагдорж сургаалын агуулгыг дараах байдлаар товчлон илэрхийлсэн байна. “То вангийн сургаал 11 зүйлээс бүрджээ.

Нэгдүгээр зүйл нь ёс журмыг хүндлэн аж ахуйг хичээх;  
 Хоёрдугаар зүйл нь, биеийн амрыг үл харгалзан аж ахуйд шамдах;  
 Гуравдугаар зүйл нь баян хүний ба тэдний улсын өмнө хүлээсэн албан үүргийн тухай;  
 Дөрөвдүгээр зүйл нь ядуу хүн олзыг хэрхэн олох;  
 Тавдугаар зүйл нь хүн юу чаддагаа залхууралгүй хийх, нэг ажлын далимаар хэд хэдэн ажлыг бүтээх;  
 Зургаадугаар зүйл нь гэр бүл бололцох тухай;  
 Долоодугаар зүйл нь лам нарын тухай;  
 Наймдугаар зүйл нь хулгайн тухай, хэрмэлийн тухай;  
 Есдүгээр зүйл нь аян жинд хэрхэн бэлтгэх;  
 Аравдугаар зүйл мал маллагааны зарим арга барил;  
 Арваннэгдүгээр зүйл нүүдэл, суудлын тухай өгүүлжээ”

(Ш.Нацагдорж, ЭБЭ, 2018, VIII, 147)

То вангийн сургаалд нэгд, тэр үеийн монголчуудын эрхэлдэг ажил төрлийг бараг бүгдийг нь багтаасан, хоёрт, баян ядуу, лам гэх мэтээр нийгмийн бүх давхаргуудад хандсан, гуравд, аж төрөл сайн байхын үндэс нь зөв хүмүүжилтэй ёс заншлаа даган мөрддөг байх явдал хэмээн үзсэн шинжтэй байдаг. Тиймээс сургаалын нэгдүгээр зүйлд хүмүүжил, ёс суртахууны асуудлыг авч үзжээ. Тэрбээр хүн нэгд, ёс журмыг сахиж аж төрөх, хоёрт, бурхан шашныг санаж буян үйлдэх нь мөрдвөл зохих ерөнхий зарчим аж. Түүнээс гадна эцэг эхийг хүндлэн цагаан сараар золгон мөргөж, зохистой идээн ундаа, хөнгөн дулаан хувцас хунараар байнга хангаж, халамжлан байхыг сургажээ. Сургаалд хүүхдийг бага наснаас нь хүмүүжүүлж хүн болгох тухай монголчуудын үзэл илэрхий байдаг. Тэрбээр “өөрийн чадлыг үзэж хүү хүүхнээ

арван найман наснаас нааш хүн хөлөг болговоос аж төрөл олгоход сайн” хэмээн сургажээ. Баячуудад хандаж хөрөнгө малаа нуун дарагдуулж, эсвэл худалдан мөнгө болгох зэргээр төрийн алба татвараас бултахгүй байхыг сануулжээ. Мөн баян хүн зарц ядуусаа дарангуйлах басамжлах, хяхахыг тэвчиж зөв зүйл зааж байх, надад тустай зүйл бүтээдэг хүн хэмээн санаж бай гэжээ. Сургаал нь ухуулан сэнхрүүлсэн шинжтэй. Аливаа юмыг олон талаас нь жишээ татаж тооцоо хийж сургасан байдаг. Жишээ нь, баян хүн гэрт эд мөнгө байвч тэр үржиж арвижихгүй, мөнгөө хүүлсэн ч малтай байхаас илүү орлого оруулахгүй (мөнгийг хүүлбэл нэг лан ихэдвэл нэгэн жилд мөн гурван цэн зургаан фүн хүү өгнө. Таван цэнгийн үнэтэй эм хонь нэгэн жилд мөн таван цэнгийн хурга нэг хоёрыг хургална. Хурга үхэвч арьсыг нь зургаан цэнгээс худалдана. Хурга байтугай арьс нь боловч мөнгөний хүүгээс илүү гарах тул). Үүний зэрэгцээ алба татвараас зугтвал төрийн тэнгэр таалахгүй, элдэв муу ёр болно гэх мэтээр олон янзаар ухуулан сэнхрүүлсэн байдаг. Данзанравжаа, Номтын Ринчин нарын зэрэг олон лам нар монгол, төвд хэлээр сургаалын шүлэг зохиол бичиж байсан нь хүмүүжлийн ихээхэн ач холбогдолтой юм. Түүнээс гадна Ардыг тэжээх рашааны дусал, Эрдэнийн сан Субашид гэх мэтийн сургаалын зохиолыг төвд хэлнээс орчуулсан нь монголчуудын дунд өргөн тархсан байна.

Монгол үндэстний хүүхэд, залуусаа сурган хүмүүжүүлэх арга ухаан, төлөвшүүлэхийг эрмэлздэг байсан шинж чанар нь ерөнхийдөө тухайн үед оршин байгаа нийгмээ хадгалан авч үлдэх зорилготой байснаас бус хөгжүүлэхэд чиглэж байсангүй. Энэ нь олон зууны турш хэвээр хадгалагдан байсан аж төрөх ёсны хэв маягтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, эртнээс уламжлан ирсэн тэр л хэм хэмжээ, ёс заншлыг эзэмшүүлэх, дадал хэвшил болгоход чиглэж байсан хэрэг юм. Тийм учраас орчин үед энэхүү өв уламжлалд авах гээхийн ухаанаар хандаж, боловсролын орчин үеийн философийг буй болгох хэрэгтэй юм. Хүүхдийг бага наснаас нь ажил хөдөлмөрт сургах, хүмүүжил олгох үйл ажиллагаа хоорондоо салшгүй байдлаар нэгэн зэрэг хэрэгждэг. Хүүхдийг ам хэлээр сургахаас гадна ажил хийлгэж сургадаг, ахмад хүмүүс үлгэр, дуурайлаараа сургадаг, тоглоом бусад олон хэрэгслийг ашиглан

хөгжүүлдэг байна. Бусад арга барил нь орчин үед бүтээлчээр авч хэрэглэх боломжтой зарчмууд юм.

Монголын бурхны шашны сургуулиас санаа авч болох зүйл бас бий. Бурхны шашин олон зууны турш хурааж хуримтлуулсан сурган хүмүүжүүлэх арга барилтай болжээ. Монголчууд ч аль тэртээ Хүннүгийн үеэс бурхны шашинтай танилцаж, XVI зууны үеэс түүнийг нийтээрээ шүтэх болсон учир шашны сургалтын баялаг өв уламжлалыг нь авч, өөрсдөө баяжуулан хэрэглэсээр ирсэн юм. Шашны агуулгыг нь орхин сургалтын нь арга барилаас санаа авч болох зарим зүйлийг нь түүвэрлэн өгүүлье.

1. Багш шавийн барилдлага. “Багш шавийн барилдлага бол гэгээрлийн үндэс”. Бодлогын хувьд багшийг юм уу шавийг онцлохгүй, багш шавь хоёрыг сургах, суралцахуй гэсэн хоёр юм шиг атлаа нэг үйлийн үйлдэгч хэмээн үзэх ёстой бол багш шавиа гэсэн, шавь багшаа гэсэн сэтгэлтэй байх.
2. Шавийг сургахын тулд түүнийг суралцахуйд бэлтгэх. Үүний тулд шавийн гурван алдааг цээрлэж засах. Тэрхүү гурван алдаа юу вэ гэвэл нэгд, дээшээ харсан ч бохир, хоёрт, бохирдоогүй ч ёроол нь цоорхой, гуравд, саванд тэнгэрээс хур буувч дотор нь тогтохгүй. Тийм бол нэгд, номыг анхааралтай сонсохгүй, хоёрт, анхааралтай сонссон ч буруу ойлгох, санаа бодол нь ондоо, гуравд, эсвэл дээрх алдааг гаргахгүй ч сонссон үг ба утгыг нь тогтоохгүй мартах зэрэг сул талтай болох ажээ. Энэ нь суралцагчийг юуны өмнө суралцахуйд сургах гэсэн санаа юм.
3. Хүнд ялгавартай хандаж, ном заахдаа оюуны чадвар, онцлогийг нь харгалзан агуулга, арга барилаа сонгох.  
“Оройн дээд номлолоосоо урьтаж  
Оюуны нь савыг шинжээд үзээрэй”

Шавьд ном заахын тулд багш өөрөө өндөр ёс суртахуунтай, багшийн ёс зүйг ёсчлон дагадаг, эрдэм номд нэвтэрсэн байх.

“Номхорсон, амгалан, амарлингуй  
Эрдэм чадлаар үлэмж, хичээнгүй, арвин мэдлэгтэй  
Оршихуйн мөн чанарыг ухаарсан, уран илтгэдэг

Энэрэнгүй, ажилдаа дур сонирхолтой ...” гэсэн үндсэн чанаруудыг эзэмшсэн байх ёстой аж. Оршихуйн мөн чанарыг ухаарсан гэдэг нь хоосон чанарын тухай асуудал учир түүнийг орхивол багшид байх ёстой гэсэн бусад чанарууд ямар ч багшид чухал юм. Жишээ нь, уран өгүүлэх гэдэг нь “номлолын утгыг ямар дарааллаар зааж шавийн ухаанд шингээхээ мэднэ гэсэн үг аж. Харин “Энэрэнгүй” гэдэг нь “номлол зааж буй зорилго нь ариун буюу ямар нэг ашиг хонжоо, нэр хүнд горьдохгүй энэрэл хайранд хөтлөгдөн заах ...” явдал ажээ. “Хичээнгүй гэдэг нь бусдад туслах унтаршгүй эрмэлзэлтэй байхыг хэлнэ”. “Ажилдаа дур сонирхолтой гэдэг бол ахин дахин заасан ч ядардаггүй, зааж сургах бэрхшээлээс халшрахгүй байна гэсэн үг”.

*“Багш шавийн харилцан хүндэтгэх ёс.*

“Шударга, ухаалаг, дур сонирхолтой бол

Гэгээрэл дүүрэх сав болно.

Багш шавь аль нь ч биесүүдээ

Баалах, өөлөх нь ч бас цээртэй”.

Багш, шавийн аль аль нь хүний дутагдалтай талыг нь олж гоочлох бус, сайн талыг нь олж харж, багш нь шавийнхаа сайн талыг хөгжүүлэх замаар сургах, шавь нь багшийнхаа сайн талыг олж харж хүндэтгэх ёстой ажээ. “Чиний дургүй хүн олон сайн чанартай ч зөвхөн алдаа дутагдлыг нь хайх сэтгэл түүний сайн талыг олж харах нүдийг хаадаг. Нөгөө талаар өөрөө олон дутагдалтай ч ганц нэг сайн чанараа дөвийлгөн бодсоор өөрийнхөө алдааг олж хардаггүй”.

Гүн ухааны хувьд монголчууд төвч ёсон, арга билгийн ухаан, авах гээхийн ухааныг аливаад хандах арга зүй болгон ашиглаж иржээ. Аливаад туйлшрахгүй, юм юмны тун хэмжээг тааруулах, орон зайг зөв тохируулах, өөрийн нөхцөл байдалд нийцүүлэн бүтээлчээр өөрчилж хэрэглэх зэрэг арга зүйн хандлагын агуулга юм. Төвч байх гэдэг бол “төвийг сахин” суух гэсэн үг биш гэдгийг өмнө дурдсан. Аливаад зөв шийдлийг олохын тулд юмыг олон талаас нь цэгнэн бодож шийдвэр гаргах арга юм. Тиймээс төв сэтгэл гэдгийг маш чухал хэмээн үзэж байжээ. Чингис хааны билиг сургаалд “түшмэл хүний есөн эрдмийн дотроос төв сэтгэл нэн чухал” гэжээ. Аливаа юм сайн муу хоёр талтай байдаг учраас дан

сайн хэмээн гэж үзэж хэтрүүлэхгүй, дан муу гэж хэтрүүлэхгүйгээр олон талаас нь шинжилж үзнэ. “Энэ орчлонгийн түг түмэн хэрэг үйлсийн сайн муу хэмээгч ертөнцийн арга билгийн хоёр амьсгал мэт толгой сүүл залгалдсан буюу”, “мэргэний дотор мунхаг, мунхгийн дотор мэргэн буй” (В.Инжаннаши, Хөх судар. 2009). Аливаа юм хэр хэмжээнээс хэтэрч, туйлшралд хүрэхгүй байхын баталгаа бол арга билгийн ёсыг баримтлах явдал юм. “Арга билгийг дагаж нам болно, билиг аргыг дагаж хөдлөнги болно” (Ч.Дэмчигдорж). Ч.Дэмчигдоржийн Монголын нийгмийг шинэтгэхтэй холбогдуулан ХХ зууны эхээр бичсэн зүйлс арга билгийн ёс, авах гээхийн ухааныг ойлгоход дөхөм болгох юм. Тэрбээр уламжлалт соёл суртлаа гээхгүй байхын чухлыг онцлон улс төрийг засах ёс гурав бий гээд “нэгэн зүйл нь, сургаал соёл буюу даруй их мөнх хууль мөн болой. Энэ нь түмэн үед хэрхэвч халж үл болох нь болой” гэжээ. Гэвч бас халж сольж байх ёстой зүйл бас бий. Учир нь “аливаа бодис туйлд хүрвээс эрхгүй мохмуй. Мохвоос эрхгүй хувьсмуй. Хувьсваас эрхгүй нэвтэрмүй. Энэ нь даруй цаг улиралд нийцүүлэн хувилж, улирч чадваас даруй тогтнож амьдарваас болой. Үл чадах болбоос даруй мөхөж сөнөхүйд хүрэхийг өгүүлсэн нь буюу”. Тэгэхдээ халах солиход бас учир бий. “Хойч хүн ямагт урьд хүний үйлдсэн журмыг дагаж, хуучныг эвдрүүлэхгүй сэлбэн засваас үүний буян үүсгэн үйлдсэнээс доройгүй болой. Зарим нэгэн нэрд дуртай ард хуучин нь эвдрэхийг үл хайхран өөр онцгой шинийг бүтээж байгуулахыг эрхэлмүй. Энэ хоёрт алины тус үлэмж цөөнийг мэргэчүүд лав дотуураар ухах газар буй за”. Тэгэхээр аливаа юмыг анх үүсгэсэн хүний хийсэн ажил тустай. Түүнийг анх байснаар нь сэргээн засварлавал анх ямар байсан тэр хэмжээгээр л тустай байх болно. Шинэ зүйл бий болохгүй. Харин зарим хүн хуучныг эвдэн цоо шинэ зүйл хийх гэж оролддог. Энэ хоёрын аль алиных нь ашиг тус өчүүхэн ажээ. Энэ бүхэнд монголчуудын төвч үзэл, арга билгийн ёсон, авах гээхийн ухаан илэрч байгаа юм.

Монголчуудын сэтгэлгээний онцлог юу вэ? Энэ асуултад тусгайлсан судалгаагүйгээр хариулахад төвөгтэй. Гэвч ажиглалтын шинжтэй зарим зүйлийг таамаг байдлаар хэлж болох юм.

- Монголчууд юмыг ажиглаж, бясалган бодож, дүгнэлт гаргадаг зуршилтай. Тэгэхдээ ерөнхийгөөс тусгай руу, үндсээс орой руу шилжүүлэн сэтгэдэг шиг байдаг. Өглөө босоод тэнгэр, дараа нь эргэн тойрны байгаль, дараа нь ан амьтан, мал сүргээ ажиглан өдрийн өнгө, сарын шинжийг шинждэг байна. Сэтгэлгээний ийм онцлог нь монгол зурагт илэрхийллээ олсон байдаг. Европ, Хятад, Солонгос, Японы зураачдын зурсан зураг дээр бага хэмжээний орон зайд байгаа юмыг, эсвэл модны мөчир дээр сууж буй шувууг, нэг цэцэгтэй мөчрийг дүрсэлсэн байх нь элбэг. Монголын аж байдлын зураг дээр зуу зуун бээрийн газрыг, заримдаа маш хийсвэрлэсэн байдлаар дүрсэлнэ. Үүний нэг тод жишээг Б.Шаравын “Монголын нэг өдөр” зургаас үзэж болно. Түүгээр ч барахгүй аливаа зүйлийг өндрөөс, тал талаас нь харж байгаа мэт орон зайг хураангуйлах юм уу, цаг хугацааг нэгэн эгшинд хурааж дүрсэлсэн байдаг. “Монголын нэг өдөр” хэмээх зураг дээр тариа тарьж эхэлж байгаа, тариа хурааж байгаа гэх мэтээр жилийн дөрвөн улирлыг дүрсэлсэн байдаг. Энэ бүхэн нь юм бүр хувьсан өөрчлөгдөж байдаг, өөр хоорондоо нягт холбоотой байдгийг ухаарсны үр дүн юм. Монголын нэг өдөр зураг, Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг зэрэг нь хоорондоо маш адилхан, сэтгэлгээний нэг л аргаар бүтээсэн зүйлс юм.
- Монголчуудын сэтгэлгээний хоёр дахь онцлог бол бэлгэдэлт сэтгэлгээ нь юм. Ажил үйлс, хувцас хэрэглэл, орон гэр, тоглоом наадам гэх мэт бүхий л зүйлд нь сайн сайхныг мөрөөдсөн бэлгэдлийн агуулга шингэсэн байдаг. Энэ нь байгалийн хатуу ширүүн нөхцөлд аж төрж, эрин зууныг элээх боломж олгодог байсан байх. Тиймээс ч “хятад хүн бэлээрээ, монгол хүн бэлгээрээ” гэдэг үг гарсан нь тохиолдлын бус юм. Бэлгэдлийн сэтгэлгээ нь монгол хүнд ирээдүйдээ итгэх итгэлийг буй болгож иржээ. Бэлгэдэл нь үгээр, үйлээр, эд зүйлсээр, өнгөөр, тоогоор гэх мэт маш олон аргаар илэрхийлэгдэнэ. Бэлгэдэлт сэтгэлгээ бол монгол үндэстний сэтгэлгээний

ерөнхий төлөв учраас орчин үед их ярих болсон эерэг сэтгэлгээ гэдгээс өөр юм.

- Гурав дахь онцлог бол шог хошин сэтгэлгээ юм. Тийм ч учраас нийгмийн шилжилтийн хүнд үед Монголд хошин урлагийн тоглолтыг олон хүн үздэг, урлагийн энэ төрөл их дэлгэрсэн нь санамсаргүй тохиолдол биш юм. Хамгийн сүүлд ирсэн даагыг өхөөрдөж, “баян ходоод” хэмээн нэрлэж, цоллож, түрүүлсэн морины бай шан өгдөг нь бэлгэдэлт болон шог хошин сэтгэлгээний аль алины нь илрэл юм.
- Монгол хүн аливаа асуудлыг энгийнээр шийдэх эрмэлзэлтэй бөгөөд чадвартай байдаг. Түүхээс жишээ авахад Чингис хааны үед харь орныг эзлээд тэр нутгийн нь хүнээр удирдуулах, өөр өөрийн шашнаа шүтэх эрх олгох, түүнийг нь дэмжих зэрэг арга хэрэглэж байсан нь эзэлсэн газар орныг их хэмжээний дарангуй цэрэг суулгахгүйгээр эсэргүүцэлгүй байлгах хамгийн энгийн арга байсан бололтой. Энгийн арга бодож олохоос гадна энгийнйг төгөлдөрт нь хүртэл сайжруулж чаддаг. Үүний жишээ нь 500 метрт бай онодог зүймэл нум, хоёрхон чавхдастай энгийн болхи юм шиг харагддаг хэр нь гайхамшигтай аялгуу гаргаж чаддаг морин хуур, монгол гэр зэрэг маш олон зүйл бий. Монгол хүн хэрийн хүн бодож олмооргүй санамсаргүй зүйлийг сэтгэж чаддаг. Үүнийг орчин үед хүмүүсийн ярьдаг гадны техникийг “монголчилдог”-оос харж болно. Монголчуудын эдгээр чадварыг орчин үеийн техник, технологийг хөгжүүлэхэд ашиглах боломжтой юм. Зан ааш нь ч энгийн, шулуун. Үүнийг гадны олон хүн тэмдэглэсэн байдаг. Зежи Эварнет Хюк “монголчууд нүүр тулсан хүнтэй энгүүн, чөлөөтэй харьцана. Хятадуудын яршигтай манж зан, хоосон ёсорхог зан аалийн аль алиныг тэднээс олж харахгүй” хэмээжээ.
- Монгол сэтгэлгээний өөр нэг онцлог бол байгаль дэлхийд хандах хандлага нь юм. Байгалийн “дээр” оршиж, түүнийг эзэмдэх гэж оролддоггүй, түүнтэй хамт, түүний дотор оршиж, аж төрдөг.

- Монгол хүн ерөнхийдөө бардам. Дорд үзэх, дээрэнгүй харьцахад дургүй. Гүн Ларсен номдоо өөртэй нь таарсан нэг эмгэний тухай бичсэн байдаг. Тэрбээр араг үүрсэн эмгэнийг харан өрөвдөж зогстол эмгэн:

“Чи гадны хүн байна. Хаанаас ирсэн бэ хүү минь, аян замдаа ядрав уу?” гэж асуугаад хариултыг нь сонссоноо “Монгол хүн болж төрөөгүй нь юутай харамсалтай вэ? Хөөрхий минь. Тэгэхдээ амьд мэнд яваад энэ газар ирсэн нь ашгүй дээ, хүү минь” гэх утгатай зүйл хэлсэн аж. Х.Хаслунд-Христенсен Бээжингийн гудамжаар алхаж яваа монгол хүн ямар их бардам дүр төрхтэй байсан тухай бас дурссан байдаг.

- Монгол нутгаар дайраад өнгөрсөн юм уу богино хугацаагаар байсан гадны хүмүүс бохир заваан, архиддаг зэрэг хамгийн түрүүнд нүдэнд ажиглагддаг муу зүйлийн талаар их бичсэн байдаг бол удаан хугацаагаар амьдарч, монгол хүнтэй танилцаж, хамтран ажиллаж байсан Ларсен, Гелета зэрэг болон бусад олон хүн монголчууд шинэ юмыг түргэн хугацаанд сурдаг, үнэнч, найрсаг, зочломтгой гэдгийг магтан бичсэн байдаг.
- Монгол хүн хорон санаатай биш. В.Инжаннаши “тэргүүлсэн эздэд нь зальхай, их харгисын чанаргүй, доорд ардад нь нууц хор, далд дайсны битүү хохирол үгүй” хэмээн дүгнэжээ.

Монгол хүний эдгээр уугуул зан чанар гадны “соёлт” ертөнцтэй харилцах болсноор нэлээд эвдэрсэн боловч бүр устаж алга болоогүй юм.

Шинжлэх ухаан, технологийн хөгжил өндөр түвшинд хүрч, мэдлэг, сэтгэл хоёр капитал болж хувирсан өнөө үед монгол хүнийг “барууны” хүн болгон хувиргах гэж оролдохын оронд түүний уугуул сайн чанаруудыг хөгжүүлэн орчин үеийн шаардлагад нийцүүлэх нь монголын боловсролын эрхэм зорилго байх ёстой.

## БҮЛЭГ 4

### МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН НОМЛОЛ

Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого нь:

- Улс орны түргэвчилсэн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын чанарыг сайжруулах,
- Үндэсний боловсролын философи/номлолыг буй болгон мөрдөх,
- Монгол хүний төрөлх чадварыг, авьяаслаг хүүхэд, залуучуудыг тасралтгүй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
- Залуу үеийн эх оронч, иргэнлэг байр суурийг бэхжүүлэх,
- Оюун санааны хүрээнд буй болсон хямралт байдлыг гэтлэн давж, ард түмний соёл, ёс суртахууны нэгдмэл байдлыг буй болгох,
- Боловсролын салбарын хоцрогдлыг богино хугацаанд арилгахын тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал мөн.

#### *1. Иргэдийн соёл, үнэлэмжийн нэгдмэл байдлыг бий болгох нь боловсролын эн тэргүүний зорилт мөн.*

Хүний хөгжил гэдэг нь юуны өмнө нийгэм-соёлын талын хөгжил юм. Бусадтай харилцаж, хүндэтгэж, санаа бодлыг нь сонсож, өөрийгөө цэгнэн үнэлэмж буй болгох, өөрийн болон бусдын зан үйлийг үнэлэмжийн шалгуураар үнэлж, сонголт хийж чаддаг байх зэрэг нь чухал юм. Энэ нь бусдын эрхийг хүндэтгэх, өөрөө үүргээ ухамсарлах дадлыг бий болгоно. Энэ үндсэн дээр нийт ард түмний соёл үнэлэмжийн нэгдмэл байдал бий болно. Энэ бол хувь хүний түвшнээс дээш гарсан өндөр түвшин, өргөн хүрээний чанар буй болж байгаа хэрэг мөн. Нарийн мэргэжилтэй, техник, технологийн мэдлэгтэй атлаа нийгэм соёлын чадвар, дадал байхгүй бол түүнийг хөгжсөн хүн гэж үзэх боломжгүй юм.

Нөгөө талаас мэргэжлийн мэдлэг чадвар чухал. Дэлхийн зарим оронд хүнийг иж бүрэн хөгжүүлэх зорилт тавьж байна. Энэ нь социализмын үед их яригддаг байсан бүх талын хөгжилтэй хүн гэдэгтэй ижил сонсогдож байгаа боловч XXI зууны хүний шинж чанар байх ёстой нь зайлшгүй юм.

Гэвч юуны өмнө зөв хүн байх нь чухал юм. Тийм учраас өнөөгийн нөхцөлд Монголын боловсролын гол зорилт бол ард түмний түүхэн туршлагаар бий болсон оюун санааны үнэт зүйлд тулгуурласан соёлын нийгэмшил, залуу үеийг эх орны өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн хэрэгцээ, шинжлэх ухаан, технологийн нөлөөгөөр гарч байгаа хүний оршин байхуйн өөрчлөлтөд нийцүүлэн төлөвшүүлэх явдал юм.

Нийгэм-соёлын хөгжил нь тодорхой сургаал, номлолд суурилна. Монгол улсын иргэний хөгжил, төлөвшил нь үндэсний үзэл, эх оронч сэтгэлгээнд тулгуурлана. Үндэсний үзэл санаа (national idea)-г боловсруулан соёл, боловсролоор дамжуулан хүний амьдралын бүхий л талд шингээх учиртай. Үндэсний үзэл санаа нь нийгмийн гишүүдийг сэдэлжүүлэгч, нягтруулагч хүчин зүйл юм. Монголын нийгэмд сүүлийн гуч орчим жилийн хугацаанд буй болж, улам бүр даамжирч байгаа эсрэгцэл, задралын үйл явц, төвөөс зугтах хүчний эрчимжилтийг харгалзан үзвэл ийм ийнхүү үндэсний үзэл санааг буй болгож, дэлгэрүүлэх шаардлага маш хурц байна. Үндэсний үзэл санаа нь уриа, лоозонгийн хэлбэртэй байх тохиолдол байдаг боловч, өнөөгийн Монгол Улсын хувьд ямар улс, ямар нийгэм байх дүр төрхийн тухай төсөөлөл/мөрөөдөл юм. Монголчууд түүхэндээ ийм төсөөллийг бий болгон, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байсан уламжлал бий. 1914 онд Улсын хурлын газрыг байгуулахыг хүсэж айлтгасныг Богд хаан зөвшөөрөн цохсон бичигт Манж Чин улсаас тулгар салсан Монгол Улсын ирээдүйн төлөвийг тодорхойлж “улсын хүчин бат чийрэг, эдийн засаг элбэг дэлбэг, хүн бүр хүрэлцэж, гэр бүр баян талбиу, дотоод дор ариун тодорхой, гадаад дор найртай түвшин болох” хэмээн бичсэн байна. Социализмын үед “аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон” болох гэх мэт уриатай байсан нь бас л үндэсний үзэл санааны шинжтэй байжээ. Үндэсний үзэл санааг бий болгох улс

төр, эрх зүйн суурь нь Монгол Улсын Үндсэн хуулиар тавигдсан юм. Уг хуулийн оршилд:

Монголын ард түмэн бид

- Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- Төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно хэмээн хуульчилсан юм.

Эдгээр нь монголын ард түмний үнэлэмжийн суурь юм. Энэхүү суурин дээр тулгуурлаж ард түмний соёл, ёс суртахууны нэгдэл бий болно. Үндсэн хуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэгч гол үндсэн субъект нь боловсрол юм. Үндсэн хуульд тодорхойлсон эрхэм зорилгыг агуулгын хувьд нарийвчилбаас энэ нь үндэсний үзэл санаа болно. Улмаар эл эрхэм зорилго боловсролын агуулга, үйл явцад хэрхэн тусгалаа олж буйг нягтлан шинжлэх үндсэн дээр тэдгээрийг шинэтгэх хэрэгтэй болно. Ингэх нь боловсролын тогтолцоонд бүхэлд нь дүн шинжилгээ хийхийг шаардаж байна.

Дээр дурдсан эрхэм зорилго нь соёл, үнэлэмжийн шинжтэй байгаа нь тохиолдлын хэрэг бус юм. Түүнийг хэрэгжүүлж чадвал, иргэн орчин үеийн түвшний мэдлэг, чадвартай болох нөхцөл хангагдана.

## ***2. Боловсролын зорилго***

Боловсролын зорилго бол үйл явцаар бус, бүх нийтэд боловсрол эзэмшүүлэх гэх мэт улс төрийн зорилгоор бус, боловсролтой болсон хүний шинж чанараар, өөрөөр хэлбэл үр дүнгээр илэрхийлэгдэнэ.

## ***3. Хүний хөгжил, нийгмийн хөгжил хоёр өөр түвшний асуудал боловч хоорондоо нягт уялдаатай***

Энэхүү уялдаа нь нэгийг нь нөгөөд нь захируулах гэсэн

үг биш юм. Тиймээс хүний болон нийгмийн хөгжсөн гэж үзэх төлөвийг тодорхойлох хэрэгтэй. Залуу үе бие даасан, сонголт хийх чадвартай байх ёстой гэдэг нь ерөнхий. Юуг хийх, үйлдэхдээ бие даасан байдалтай байх, юуг үндэслэн сонголт хийх вэ гэдэг нь чухал. Бүх нийтээр сургуульд суралцдаг болсон өнөө үед хүнд ийм чадварыг сургууль төлөвшүүлэх ёстой.

#### *4. Хөгжүүлэх боловсрол*

Үндэсний боловсролын философийн үндсэн зарчим нь монгол боловсрол залуу үеийг эх орны хөгжил цэцэглэлтийн тусын тулд хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой. 1974 онд “Ромын клуб”-ээс боловсруулсан “Боловсрол хязгааргүй” хэмээх илтгэлд боловсрол нь “хадгалах” болон “инновац”-ийн гэсэн үндсэн хоёр хэв маягтай байдаг гэсэн ангиллыг санал болгосон билээ. Хадгалах хэв маягийн боловсрол нь түүхийн бүхий л хугацааны дотор буй болсон социаль туршлагыг залуу үед эзэмшүүлснээр тухайн үед оршин байгаа нийгмийг тэр янзаар нь нөхөн “үйлдвэрлэхэд” чиглэдэг бол хөгжүүлэх буюу инновацийн хэв маяг нь хүнийг хөгжүүлэх зорилгыг баримтлан нийгмийг тухайн үеийн нөхцөл байдалд зохицуулан, цаашид оршин тогтнох чадварыг нь улам өсгөн нэмэгдүүлэхэд чиглэдэг. Нэг дэх хэв маяг зонхилж байгаа үед гэр бүл, төр, сүм хийдээс зориуд ялган авсан мэдлэгийг залуу үед дамжуулах зорилгыг агуулж байдаг. Ийм системд сурган хүмүүжүүлэгч гол байрыг эзлэнэ. Харин хөгжүүлэх хэв маягтай боловсрол бол нийгмийн хөгжлийн хэрэгцээ, хүний хөгжлийн үе шат бүрд шаардагдах тэр агуулгыг сонгон эзэмшүүлэх-эзэмшихэд чиглэнэ. Тийм учраас боловсролын агуулга нь сургах, хүмүүжүүлэх үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл, хөгжлийн хүчин зүйл болж байдаг.

#### *5. Мэргэжил*

Монгол хүн бүр орчин үеийн түвшинд нийцэхүйц мэргэжилтэй байх ёстой. Нийгэм-соёлын хөгжлийн зэрэгцээ монгол хүний хөгжлийн нэг чухал тал бол мэргэжил юм. Хүн бүрд заавал мэргэжил эзэмшүүлэх нь боловсролын тогтолцооны гол зорилтын нэг юм. Хүний хөрвөх чадвар өндөр байх нь хүн

амын тооны сөрөг нөлөөллийг арилгах, нөгөө талаар эрчимтэй өөрчлөгдөн буй өнөөгийн нөхцөлд хүний дасан зохицох, аж амьдралаа авч явах боломжийг нэмэгдүүлэх болно. Тийм учраас нарийн мэргэжилтэн бэлтгэхийн зэрэгцээ, хоёр юм уу хэд хэдэн чиглэлийг хосолсон мэргэжилтэн бэлдэх хэрэгтэй юм.

## **6. Боловсролын үр дүн**

Боловсролын үр дүн нь боловсролтой хүний эзэмшсэн байвал зохих цогц чадамжаар тодорхойлогдоно. Боловсролын шалгуур нь тухайн нийгэмд баримталдаг “боловсролтой хүн”-ний хийсвэр дүр зураг юм. Энэхүү дүр зургийг баримтлан боловсролын зорилгыг тодорхойлдог гэсэн үг. Дүр зураг тухайн цаг үеийнхээ онцлогийг тусган өөр өөр болж, хувирч өөрчлөгддөг. Орчин үед боловсролын чанарыг боловсролын тогтолцоо дотроо бус, түүний гаднын үнэлгээгээр хэмжих ёстой гэж үзэх болжээ. Хамгийн ерөнхий хэмжүүр бол макро түвшний улс орны эдийн засгийн чадавх, ард түмний амьдралын чанар, хүрээлэн буй орчны хамгаалалт, технологийн суурь чадавх зэрэг бөгөөд эдгээр нь боловсролын чанар ямар байгааг харуулна. Нэгжийн түвшинд бол боловсролын чанар, үр дүн нь хүний цогц чадамж (competency) хэмээн үзэх болжээ. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан дүр зургийг хүний цогц чадамж тодорхойлдог гэсэн үг юм. Энэхүү цогц чадамж бол мэдлэг, чадвар, дадлаас бүрдэнэ. Тэгэхээр Монгол улсын боловсролын чанарыг (үр дүнг) боловсролтой хэмээн үзэгдэж буй хүний цогц чадамжаар үнэлж дүгнэх болно.

## **7. Багш-шавь**

Багш, шавийн баг холбоо, хамтын хөгжил нь боловсролын тогтолцооны суурь мөн. Боловсролын тогтолцооны систем үүсгэгч нь суралцагч-хүн гэж үздэг. Гэвч боловсрол бол “багш-шавь” гэсэн хоёр хүний үйл ажиллагаа болон тэдний харилцааны үр дүн байдаг. Монголын уламжлалт боловсролд иргэний болон шашны аль алинд нь “багш-шавийн” тогтолцоо зонхилж иржээ. Тийм болохоор монголын боловсролын тогтолцооны систем үүсгэгч нь “шавь-багш” гэсэн хослол байна гэж үзэж байна. Хүнийг хөгжүүлэх гэдгийг шавь, багш хоёрыг зэрэг хөгжүүлэх, багш, шавь

хоёр зэрэг хөгжих гэсэн агуулга болно. Зөвхөн шавийг онцлох нь хувьд зөв биш. Хэрвээ тэгж үзвэл, шавийн хөгжлийн бүх үе шатуудад шаардагдах мэдлэг чадварыг эзэмшсэн багш анхнаасаа байж, шавиа хөтөлнө гэсэн үг болж таарна. Өнөөгийн нөхцөлд ийм боломж байхгүй. Багш шавьтайгаа хамт хөгжиж байж сая үр дүн гарна. Тийм учраас Монголын боловсролын философийн нэг онцлог нь багш, шавь хоёрыг салгахгүйгээр хөгжүүлэх асуудал юм гэж үзэж байна. Шавь төвт сургалтын тухай ярих нь багшийн үүргийг дутуу үнэлэх, хөгжлийг нь орхигдуулахад хүргэж байж болох юм.

Суралцагч суралцах үйлдээ идэвхтэй, хариуцлагатай хандах, бие даасан бүтээлч шинжтэй болж хөгжихөд багш л түүнийг ийм замналаар хөтөлнө. Ийм учраас багш-шавийн харилцааг суралцахуйн “субъект-объектын” бус “субъект-субъектийн” харилцаагаар төсөөлөх, түүнийг амьдралд хэрэгжүүлэх тодорхой арга зам нь юу вэ гэдгийг хэлэлцэх хэрэгтэй байна.

Багш-шавь гэсэн энэхүү явцуу хүрээнээс халих юм бол боловсрол бол боловсорч буй хүний нийгэмтэй харилцах үйл явц юм. Энэхүү харилцаанд гэр бүл, үе тэнгийнхэн, мэдээллийн хэрэгслүүд, соёл, урлагийн ажилтнууд гэх мэт маш олон харилцагч оролцдог. Юуны өмнө “багш-суралцагч-гэр бүл”, “сургууль, суралцагч гэр бүл” гэсэн гурвалжилсан харилцааг суралцагчийн хөгжилд түлхэц өгөхүйцээр эрүүл, үр нөлөөтэй болгох учиртай. Түүнчлэн нийгмийн орчноос хүүхэд залуучуудын хүмүүжилд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөө, мэдлэг, чадвар, дадлаа олоход нь тус дэм үзүүлэх асуудлыг сөхөх, судлах, нийт нийгмийн анхаарлыг хандуулах хэрэгтэй.

### ***8. Сургалт-хүмүүжил нэгдмэл байх***

Боловсрол нь өмнө дурдсанчлан хүний цогц чадамжаар илэрхийлэгдэнэ. Цогц чадамж нь мэдлэг, чадвар, хандлагын төвлөрсөн илэрхийлэл учраас боловсролын мөн чанарыг ингэж тодорхойлох нь цогц чадамжийн тодорхойлолттой дүйж байгаа юм. Суралцахуй хүмүүжихүй хоёрыг ийнхүү нэгэн үйлээр зохион байгуулахад багшийн үүрэг, нөлөө маш их. Энэ асуудал багшийн

цогц чадамж, түүнийг бэлтгэж байгаа сургуулиудын хөтөлбөр, багш мэргэжлийг эзэмшүүлж буй арга барил, багш мэргэжлээр элсэж буй хүүхдүүдийн ёс суртахууны шинж чанар гэх мэт олон зүйлийг хөндөнө.

### **9. Гэр бүл ба боловсрол**

Хүүхдийг хүмүүжүүлэх, сургахад гэр бүлийн гүйцэтгэх үүрэг нэн чухал. Хүүхдийн хүмүүжил бага наснаас эхэлж, зан төлөв нь бүрддэг учраас хүүхдийг хүмүүжүүлэх, сургуульд бэлтгэх нь гэр бүл, эцэг эхийн ариун үүрэг, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг байх ёстой. Боловсролын байгууллагууд залуу эцэг эхчүүдэд, хүүхдээ хүмүүжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг баримталж сургах, сургуульд бэлтгэх, сурах эрмэлзлийг нь өрнүүлэх талаар сургалт явуулах, зөвлөгөө өгөх зэргээр тусалдаг байх хэрэгтэй.

### **10. Боловсролын байгууллага ба хүүхэд хамгаалал**

Боловсролын байгууллага, гэр бүл бол хүүхэд хамгааллын үндсэн субъект мөн. Тэдгээрийг ямар нэг хөндлөнгийн байгууллага орлох нь хүүхдийг гэр бүл, сургууль, багш нарын нь эсрэг болгож, хөндийрүүлэх хандлагатай байна. Хүүхэд, залуу үеийг сургаж хүмүүжүүлэх ажил хаана ч, хэзээ ч гэр бүл, сургуулийн үүрэг байсан. Тэдэнд энэ ажлаа хийх боломжийг нь олгох хэрэгтэй.

### **11. Орчны нөлөө**

Хүүхдийн хүмүүжилд үзүүлдэг орчны сөрөг нөлөөг багасгах. Энд хүүхдэд үзүүлж буй орчны сөрөг нөлөөг багасгахын тулд насанд хүрэгчид, урлаг соёлын зүтгэлтнүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн зүгээс “хүүхдэд үзүүлж буй нөлөө” гэдэг үзүүлэлтийг баримтлан өөртөө “цензур” тогтоох тухай санааг дэвшүүлж байгаа юм. Эл асуудлыг боловсролын тогтолцооны зүгээс нийгэмд хандан бүх нийтийн анхааралд оруулж чадвал улс нийгэмд үзүүлэх ач холбогдол нь их байх болно.

Эх орны ирээдүйг дархлах ёстой залуу үе дээр дурдсан цогц чадамжийг эзэмших нь орлого олох, зугаалж, цэнгэхтэй зүйрлэшгүй өндөр ач холбогдолтой юм. Нэг нутгийнхан хүний өөрийн гэхгүйгээр хүүхдийн хүмүүжилд анхаарч сургаж заадаг

байсан уламжлалыг өнөө үед нийгмийн түвшинд хэрэгжүүлэх арга хэрэгслийг олох нь зүйтэй.

## ***12. Боловсролын үнэлгээг чанаржуулах нь***

Сургууль, багш, суралцагчийн үйл ажиллагааны үр дүн, ахицын үнэлгээ хяналтын нэгдсэн тогтолцоо байх нь чухал юм. Энэхүү тогтолцоо нь боловсролын салбарын дотоод үнэлгээ (явцын болон төгсөлтийн), төрийн үнэлгээ, дээд боловсрол эзэмшсэн мэргэжилтний цогц чадамжийн үнэлгээ, сургуулийн, багшийн үйл ажиллагааны үнэлгээ, орон нутгийн төрийн болон өөрөө удирдах ёсны байгууллын боловсролын бодлого, үр дүнгийн үнэлгээ зэргээс бүрдэнэ. Үнэлгээний шалгуурыг боловсролын үйлчилгээний хэрэглэгчид, мэргэжлийн холбоод зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулж мөрдөх. Боловсрол бол багш сурагч хоёрын хооронд, тэдний харилцаагаар хэрэгждэг үйл явц учраас, ялангуяа багшийн цогц чадамж, цогц чадамжаа хэрхэн хэрэглэж байгааг үнэлэх нь маш чухал. Түүнчлэн олон улсад хэрэглэж буй арга зүйг манай өөрийн хэрэглэж буй аргачлалтай зэрэгцүүлэн судалж сургуулийн, багшийн суралцагчийн, мэргэжилтний үйл ажиллагааны үр дүн, ахиц дэвшил юм уу цогц чадамжийн үнэлгээний тогтолцоо буй болгох нь боловсролын салбарын үйл ажиллагааны чанарыг бүхэлд сайжруулахад түлхэц болно. Үүний дотор багшийн ёс зүйн үнэлгээ, багшийн ёс зүйтэй холбоотой маргааныг шийдвэрлэх асуудал багтана.

## ***13. Монгол уламжлалаас суралцах нь***

Үүнд монголчуудын залуу үеэ төлөвшүүлж ирсэн зарчим, арга барилыг харгалзан үзэх нь үр дүнтэй байж болох юм. Монголчууд олон жилийн туршлага, дорнын ард түмнүүдийн мэдлэг ухааны ололтоос суралцсантайгаа хослуулан ийм зарчмуудыг баримталж ирсэн байна. Үүнээс заримыг нь дурдвал:

- Хүүхэд залуучуудыг багаас нь сургаж, хүмүүжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байжээ. Бүр эхийн хэвлийд байх үеэс анхаардаг байсан нь орчин үеийн боловсролын философийн үзэл санаатай нийцэж байгаа юм. Хүүхдийн ийнхүү нэн багаас нь эхлэн сургаж хүмүүжүүлэх хэрэгтэй

байдаг учраас нялх хүүхдийн боловсролын тухай ярих, энэ талаар эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх, сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарт онцгой анхаарал тавих нь чухал.

- Монголчууд хүүхдийг үйлээр сургадаг байжээ. Эцэг эх, ахмад хүмүүс сургаж, соёхоос гадна нас биед нь тохирсон ажил, хөдөлмөр хийлгэх, хүнтэй харилцах, хүндэтгэх, зөв суухыг хүртэл зааж үйлдүүлж сургадаг байсан юм. “Аяга даах” наснаас эхлэн ажилд сургадаг. 1-3 насанд эцэг эхдээ аяга шаазан, аргал хомоол дөхүүлэх, 4-6 насанд хургачин, тугалчин болох, 6-8 насанд ус авах, түлээ түүх, 8-аас дээш насанд хонь хариулах, 12-13 наснаас эхлэн хөвгүүд нь эмнэг сургах, адуу малд явах, охид нь сааль саах, оёдол хийх гэх мэт ажлыг хийж эхэлдэг. Эдгээр ажлыг хийхийн сацуу мал саах, ноос үс авах, сааль сүү боловсруулах, нүүдэл суудал хийх, хадлан тэжээл бэлтгэх зэрэг олон ажилд зэрэг суралцана.

Энэ бүхэн нь одоогийн нэр томъёогоор яривал хүүхдийн хөгжлийн үе шатыг харгалзан сургаж байсан хэрэг юм. Тэгэхээр монголчуудын энэ уламжлалаас хоёр чухал сургамж гарч байгаа юм. Нэгд, дан ганц үг сургаалаар бус үйлээр, үйл сургаал хоёрыг хослох аргаар хүүхдэд амьдралын боловсрол олгодог, хоёрт, хүүхдийн хөгжлийн үе шатыг харгалзан үйлийн хүнд хөнгөнийг тохируулдаг байжээ. Эдгээрийг боловсролын үйл явцыг зохиомжлох, сургалтын арга барилыг боловсруулахад харгалзаж болно.

- Монголчуудын хүүхдийг ажил хөдөлмөрөөр сургах, ёс суртахууны зөв дадал хэвшилтэй болгох хоёр хоорондоо салшгүй холбоотой нэг үйл болон явдаг байжээ. Мал маллах хөдөлмөрт сургахдаа, мал амьтныг хайрлах, байгаль дэлхий, ус, ургамалтай харьцах зөв дадал олгодог байсан байна. Үүнд эцэг эх, ахмад хүмүүсийн биеэр үлгэрлэх нь чухал нөлөөтэй байжээ. Одоогийн нөхцөлд багшийн ёс суртахуун, багш болон эцэг эх, асран хамгаалагчдын сурган соёх үйлийн агуулга, арга барилын нийцэл маш чухал юм.

- Хүүхдийг хөгжүүлэх маш олон аргыг хослуулан хэрэглэдэг байжээ. Жишээ нь, тоглоом бол зөвхөн зугаа, цэнгэл төдий биш юм. Тоглоом нь олон төрөлтэй бөгөөд зарим нь хүний бие бялдар овсгоо самбааг, зарим нь дүн шинжилгээ хийж, учрыг тайлан ойлгож сурахад, зарим нь үг хэл зүгшрүүлэх, санаагаа уран яруу илэрхийлж сургахад чиглэсэн байдгаараа онцлог юм. Хүүхдийг боловсруулах ийм арга нь үйлээр дамжуулан сургахтай мөн чанарын хувьд ижил боловч, дарамт багатай байдаг учраас илүү үр дүнтэй байж болох юм. Түүнчлэн тоглоом тоглох нь хүүхдийн сэтгэл хөдлөлийн төлөвшилд нөлөөлж, нийгмийн дотор бие авч явах чадварыг төлөвшүүлдэг байна. Ардын тоглоомыг сургалтад ашиглахдаа хөтөлбөр дэх тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх, сурганы болон хүмүүжлийн үр нөлөөг нь үнэлэх зэргээр шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах хэрэгтэй юм. Ялангуяа сургуулийн өмнөх боловсрол, бага сургуулийн хүрээнд тоглоомоор сургах арга зүйг сайтар боловсруулж хэрэглэвэл үр нөлөө сайн байж болно.
- Хүүхэд, залуучуудад ёс суртахууны зөв хэм хэмжээг эзэмшүүлэх, хорвоо ертөнцийн жам ёсыг ойлгуулахад үлгэр домог ярих, тууль хайлах гэх мэт урлаг соёлын шинжтэй аргыг бас өргөн хэрэглэдэг байсан. Өнөөгийн нөхцөлд ялангуяа уран зохиолын хичээл түүнийг орлож болох талтай юм. Уран зохиолтой танилцах нь эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, буруу зөв, сайн муугийн ялгааг ойлгоход маш тустай. Түүнчлэн соёл, урлагтай танилцах аялал гэх мэтийг хичээлийн жилийн бүтцэд оруулан албан ёсоор хэрэгжүүлдэг байх.

Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны эдгээр өв уламжлалыг бүхэл бүтэн тогтолцооны хүрээнд хэрэгжүүлэх арга замыг олох нь чухал бөгөөд боловсролын үр дүнд тус нэмэртэй болох болно.

#### 14. Тогтолцооны өөрчлөлт

Тогтолцооны хувьд анхаарах зарим зүйл байна. Үүнд:

- Орон нутгийн, ялангуяа сумын сургуулийг тухайн орон нутгийн амьдрах ухааны төв болгон хувиргах;
- Сум бүрд бүрэн дунд сургууль байгаагийн эерэг, сөрөг талыг шинжлэн шаардлагатай гэж үзвэл бүрэн дунд сургуулийг бүсчлэн сум дундын сургууль байдлаар зохион байгуулах, бусад сумдад дунд сургууль байх;
- Техникумыг сэргээн байгуулах;
- Хувийн болон орон нутгийн дээд сургуулиудыг салбараар дагнан мэргэшүүлэх, техникум болгох чиглэлээр урамшуулах, дэмжлэг үзүүлэх;
- Эрдэм шинжилгээний ажилтан, их, дээд сургуулийн багш судлаач бэлтгэх зорилгоор математик, байгалийн болон амьдралын ухааны хичээлүүдэд сайн, авьяаслаг хүүхдүүдийг сургах ахисан түвшний ахлах сургуулийг байгуулах;
- Урлаг, спортын ахлах сургуулийг байгуулах;
- Дунд болон ахлах сургуульд сурагчдад хичээл сонгох, эртнээс ирээдүйгээ төлөвлөх боломж бүрдүүлэх зэрэг асуудлыг судалж шийдвэрлэх.

## БҮЛЭГ 5

# ДЭЛХИЙН ЗАРИМ УЛСУУДЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОГ

Дэлхийн улс орон бүр өөр өөрийн онцлогтой боловсролын тогтолцоотой. Тэдгээрийг ерөнхийд нь азийн маягийн, европ-америкийн маягийн хэмээн хоёр ангилж болохоос гадна Болонийн ба Болонийн бус хэв маягийн хэмээн хувааж үзэж болно.

Азийн маягийн боловсролын тогтолцоотой улсуудын тоонд юуны өмнө Хятад, Япон, БНСУ-ыг оруулж болно. Ийм тогтолцооны онцлог нь:

1. Суралцагчдад үндэсний хэл соёлыг эзэмшүүлэхэд онцгойлон анхаардаг,
2. Эх орныхоо төлөө гэсэн сэтгэлгээг төлөвшүүлдэг ба улсын боловсролын бодлого ч эх орны хөгжил цэцэглэлтэд чиглэсэн зорилготой байдаг.
3. Суралцагчдын ачаалал маш их байдаг.
4. Сахилга батад маш анхаарч, сахилгын зөрчил гаргавал хатуу арга хэмжээ авдаг зэрэг юм.

Европ-Америкийн маягийн тогтолцоонд дээр дурдсан зүйлсийн зарим шинж байх боловч, илүү чөлөөтэй байдгаараа онцлог юм.

Дэлхийн улс орнуудын боловсролын тогтолцооноос онцлон дурдмаар зарим зүйл байгааг манай орны боловсролын шинэчлэлд өөриймшүүлэн ашиглаж болох юм. Үүнд:

### *1. Хүмүүжлийн асуудал*

Хүүхдийн хүмүүжилд бүр бага наснаас нь анхаарал тавьж, цэцэрлэгээс эхлэн хүнийг хүндлэх, бусадтай хамтран ажиллах, харилцааны зөв арга барил эзэмшүүлэх, эх оронч сэтгэлтэй болгох ажлыг хийдэг байна. Өмнөд Солонгост цэцэрлэгт хүүхдийг багшаа хүндэтгэх, хичээл зүтгэл гаргаж, хөдөлмөрлөхөд сургаж эхэлдэг байна. Японд бага сургуулийн нийгмийн ухааны хичээлээр ёс зүй, түүх заадаг байна. Шинэ долоо хоногийн даваа гараг бүр

суралцагчид шугам жагсаал хийж сургуулийн захирал 15 минут үг хэлдэг байна. Сургуулиудад “хүчээ дайчлан ажиллах” гэсэн зарим үйлчилдэг байна. Японы сургалтын гол зорилго нь “үйл явдлыг зөвөөр тусган авах, хамтын ажиллагаанд тэмүүлэх, бие даах, үйлдлийнхээ хуулийн үр дагаврыг ойлгодог байх, эх оронч сэтгэлтэй байж, эх орноо, уламжлалаа хүндэтгэх, бусад үндэстэнтэй хамтран ажиллах, өдөр тутмын амьдралдаа хүмүүстэй зөв харилцдаг, зөв хувцасладаг, зөв хооллодог, эх хэлээ зөв, бүрэн дүүрэн хэрэглэдэг, аливаа зүйлд хариуцлагатай ханддаг болгон хүмүүжүүлэхэд оршдог байна. Үндэсний сэтгэлгээ, үзэл санааг хүүхдэд төлөвшүүлэхэд анхаарна. Хүүхдэд мэдлэг олгох, зөв хүмүүжилтэй болгох нь боловсролын зорилгын хувьд эн тэнцүү байдаг ажээ. Жишээ нь, суралцагчдад цагнаас өөр илүү янз бүрийн зүйл зүүхийг хориглодог байна.

Хятад улсад хүүхдэд бага наснаас нь эхлэн шаргуу хөдөлмөрлөх, зорьсондоо заавал хүрэх зэрэг зан чанарыг эзэмшүүлэхэд анхаардаг. Хэзээ ч замын дунд зогсохгүй байх ёстой аж. Тиймээс хятад тамирчин олимпод оролцож байгаа бол заавал алтан медаль авахын төлөө л өрсөлдөх ёстой аж. Сургуулиудад хатуу дүрэм баримтална. Суралцагч хүндэтгэх шалтгаангүйгээр 12 цагийн хичээл тасалах, сургууль дотор архи уусан тохиолдолд сургуулиас шууд хөөгддөг байна. Их сургуулийн оюутан хүндэтгэх шалтгаангүйгээр 3 удаа хичээл тасалбал уг хичээлийг дараа жил нь давтан үздэг байна. Тэр жилдээ хичээлд сууж болох боловч шалгалтад оруулдаггүй аж. Хэрвээ оюутан нэг сургуулиас хасагдвал өөр сургуульд орох эрхгүй болдог байна. Ийм тохиолдолд мэргэжлийн дунд сургуульд орохоос өөр аргагүй болдог аж. Цэцэрлэгт өглөө бүр төрийн далбааг мандуулахаас үйл ажиллагаа нь эхэлдэг байна.

Польш улс хүмүүжлийн асуудлыг боловсролын тухай хуульдаа тусгаж, ялангуяа цэцэрлэг болон бага сургуульд хүүхдийг хүмүүжүүлэхэд анхаардаг байна. Япон, Финлянд улсуудад хүүхдэд цэцэрлэгийн наснаас нь нийгмийн харилцаанд орох, хэлийг хөгжүүлэх, зан аашийг төлөвшүүлэхэд анхаардаг байна. Японд цэцэрлэгт жил бүр хүүхдүүдийг жижиг бүлэг “хан” болгон хувааж

бүлгээр нь үйл ажиллагаанд оролцуулдаг ба бүлгүүдийг жил бүр шинээр зохион байгуулдаг байна. Түүнчлэн бага сургуульд жил бүр өөр багш анги даадаг ажээ. Энэ бүхэн нь хүүхдүүдийг харилцаанд, багаар ажиллахад сургах ач холбогдолтой гэж үздэг байна. Их сургуулийн түвшинд ч уг үүнийг онцгойлон анхаардаг улсууд байна. Жишээ нь, Дани улсын их сургуулиуд суралцагчдадаа эх орон, ажилладаг компани, эзэмшсэн мэргэжилдээ үнэнч байж, тэдгээрийн төлөө зүтгэх итгэл үнэмшлийг олгодог байна. Тиймээс Данийн их сургууль төгссөн дани хүн гадаадад ажиллаж байсан ч эх орноо эн тэргүүнд боддог ажээ.

Хүүхдийн сурлагын амжилт болон хүмүүжилд сургууль-гэр бүлийн холбоо чухал байдгийг олон оронд хүлээн зөвшөөрөх болжээ. Ялангуяа бага ангид сурч буй хүүхдүүд эцэг эхтэйгээ илүү ойр холбоотой байж, асаргаа хамгаалалт шаарддаг, сэтгэл зүйн хувьд ч эцэг эх нь хамгийн нөлөө бүхий хүмүүс байдаг учраас сургууль-гэр бүлийн холбоо хүүхдийн сурлага, хүмүүжилд онцгой нөлөөтэй байдгийг судалгаагаар нотолсон байдаг. Жишээлбэл, Жон Хопкинсийн их сургуулийн профессор Жойс Эпштейн ийм судалгаа хийж, сургууль эцэг эхийн хамтын ажиллагааны дараах үндсэн 6 хэлбэр байна хэмээн ангилсан байна.

- Хүүхдийг хүмүүжүүлэхэд сургуулийн зүгээс гэр бүлд туслах, эцэг эхийн үүргийг хэрхэн гүйцэтгэх, гэртээ хүүхдэд таатай нөхцөлийг хэрхэн бүрдүүлэх, гэр бүлийн соёлын талаар сургалт хийх гэх мэт.
- Нэвтрэлцэхүй (коммуникац). Хүүхдийн сурлага, хүмүүжил, сургалтын хөтөлбөр, сургуулийн үйл ажиллагааны талаар мэдээлэх, хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөлдөх.
- Сайн дурын үйл ажиллагаа. Сургуулийн явуулж буй хөтөлбөр, төсөлд эцэг эхийг сайн дурын үндсэн дээр оролцуулах, эцэг эхийн зүгээс санаачилга гаргах
- Гэртээ хичээлээ давтах. Багш нар гэрийн даалгаврыг хүүхдэд аль болохоор сонирхолтой байх хэлбэрээр боловсруулах, эцэг эх даалгавраа хийхэд нь хүүхдэдээ туслах, сургалтын зорилгыг хүүхдийн онцлогийг

харгалзан хамтран тодорхойлох.

- Сургуулиас гаргаж буй шийдвэрүүдэд эцэг эхийг оролцуулах, шийдвэрийг сурталчлах.
- Нийгмийн бусад бүлгүүдтэй холбоо тогтоох, хамтран ажиллах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зэрэг аж.

Төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс гэр бүл-сургуулийн хамтын ажиллагааны талаар албан ёсны зөвлөмж гаргадаг байна. Жишээлбэл, Австралийн Эцэг эхийн Зөвлөл (АРС), сургуулийн байгууллагуудын төрийн Зөвлөл (АСССО) хамтран гэр бүл- сургуулийн хамтын ажиллагааны талаар дараах зөвлөмж гаргасныг Засгийн газар нь сайшаасан байна.

- Нэвтрэлцэхүй,
- Гэрт болон сургууль дээр сургах
- Өвөрмөц хамт олныг буй болгох,
- Гэр бүлийн үүргийг хүлээн зөвшөөрөх,
- Шийдвэрийг хамтран гаргах,
- Сургуулиас гадуурх ажилд хамтрах,
- Эцэг эхийн оролцоо

Эдгээрийг ажиглахад юуны өмнө сургуулийн зүгээс санаачилга гаргаж, эдгээр чиглэлүүдээр ажил зохиодог байх хэрэгтэй гэсэн санаатай юм. Сургууль-гэр бүлийн холбооны асуудлыг ийнхүү төрийн дээд түвшинд авч үзсэн нь уг асуудал их чухал болохыг харуулж байна. Дэлхийн бусад орнуудад ч төстэй байр суурьтай байгаа юм.

## 2. Хүүхдийг сургуульд бэлтгэх

Энэ асуудлаар гадаадад хийсэн судалгаа хоёр чиглэлтэй. Нэгд, хүүхдийн оюуны хөгжлийг, хоёрт хүүхдийн нийгмийн харилцаа, нийгэмшлийн хөгжлийг анхаарсан. Хүүхэд сургуульд орох үедээ 5-6 мянган үг мэддэг, зөв хэрэглэдэг, орон зай, цаг хугацааны мэдрэмжтэй хөдөлгөөний зөв дадалтай орчноо хараа, сонсголоороо үнэлж чаддаг оюун ухаан, бие бялдар, мэдрэл-сэтгэл зүйн хувьд сургуульд бэлэн байвал сургуульд бэлэн болсон байна гэж үздэг ажээ. Манай улсад ч цэцэрлэгийн ахлах ангид болон сургуульд орох жилийн хавар бэлтгэл ангиар хүүхдийг сургуульд

бэлтгэдэг. Гэвч бусад орнуудад энэ ажилд илүү их анхаардаг бололтой. Франц улсад хүүхэд бүр заавал цэцэрлэгт хамрагдсан байх ёстой. Түүнийг “ээжийн сургууль” (ecole maternelles) хэмээн нэрлэдэг байна. Бага сургуулийн нэгдүгээр анги нь бэлтгэл анги байдаг аж. Японд хүүхдийг цэцэрлэгт байхад нь уншиж, бичиж, зурж, дуулж сургадаг байна. Хятад улсын төрийн өмчийн СӨБ-үүд хүүхдийг сургуульд бэлтгэхэд гол анхаарлаа тавьдаг. Учир нь тус улсад хүүхдүүд боловсролын бүх шатны сургуулиар дамжихдаа маш хатуу шаардлагыг биелүүлж, их хүчин чармайлт гаргах хэрэгтэй болдог байна. Тиймээс тэсвэр тэвчээртэй байж, их ажиллах, шантрахгүй байх зэрэг шинж чанаруудыг бага наснаас нь олгохыг эрмэлздэг байна.

Дэлхийн олон улс оронд сургуульд бэлтгэх ажил цэцэрлэгт юм уу эсвэл бага сургуульд заавал нэг жилийн хугацаагаар хийгддэг байна. Финлянд хүүхдийг заавал нэг жилийн хугацаагаар сургуульд бэлтгэдэг байна. Энэ хугацаанд хичээл байхгүй боловч цагаан толгойг таньдаг болгодог аж. Хятад, Япон зэрэг азийн орнуудад хүүхдийг цэцэрлэгт уншиж, тоо бодож сургадаг байна. Ийм шаардлага нь дүрс үсэгтэй холбоотой байж болох юм.

### **3. Боловсролын шат хоорондын залгамж холбоо**

Залгамж холбоо нь хоёр талын ач холбогдолтой байна. Нэгд, хүүхэд, залуусыг дараагийн шатны сургуульд ороход нь бэлтгэдэг, хоёрт, суралцагчдыг сурлагын амжилт болон бусад шинжээр нь ялган, сурч чадах сургууль руу нь хандуулдаг болон их сургуулиудад зөвхөн сурч чадах хүүхдүүд элсдэг. Ялангуяа академик карьерт зорьж буй хүмүүсийг сонгон авахад их чухал байх шиг байна. Энэ талаар Герман, Франц улсын боловсролын тогтолцоо их онцлогтой юм.

Германы дунд сургууль таван өөр байдаг.

- Гимназ (gymnasium)
- Бодит сургууль (realschule)
- Үндсэн сургууль (Hauptschule)
- Мэргэжлийн сургууль (professionalschule)
- Ерөнхий сургууль (allgemeine Schule)

Гимназ гол төлөв хүмүүнлэгийн агуулгатай сургалттай. Түүний дипломтой хүн элсэлтийн шалгалт өгөхгүйгээр их сургуульд орох эрхтэй байдаг байна.

Бодит сургууль нь худалдаа, үйлчилгээ, төрийн алба хаагчдыг бэлтгэх чиглэлтэй. Өөрөөр хэлбэл хүнтэй ажилладаг мэргэжилтнүүдийг багаас нь бэлтгэж байгаа хэрэг. Түүнийг өндөр оноотой төгссөн хүн гимназын ахлах ангид элсэж, улмаар их сургуульд орох боломжтой байдаг.

Үндсэн сургуульд цаашдаа их сургуульд орох төлөвлөгөөгүй хүмүүст зориулсан сургууль аж.

Мэргэжлийн сургууль нь их сургуульд орох төлөвлөгөөгүй, ямар нэг мэргэжил эзэмших зорилготой хүмүүст зориулсан сургууль юм.

Ерөнхий сургууль нь гимназ болон бодит сургуулийн дундын маягтай бөгөөд хүмүүнлэгийн болон техникийн боловсролыг зэрэг олж авах бололцоо олгодог ажээ. Ерөнхий сургуулийг төгсөгчид гимназын хөтөлбөрөөр шалгалт өгч чадвал их сургуульд элсэх эрхтэй байдаг байна.

Их сургуулийн хөтөлбөр хоёр шаттай. Суурь курс нь 3-4 улирал үргэлжилж, оюутан лицензийн диплом (Vordiplom-урьдчилсан диплом) авдаг бол үндсэн курс нь 4-6 улирал үргэлжилж, түүнийг төгссөн хүнд магистрын диплом (Magister Artium) олгодог байна.

Франц улсад ерөнхий боловсролын сургуулийн анги бүр өөр өөрийн нэртэй байдаг нь түүний зориулалтаас хамааралтай бололтой.

#### *Бага сургууль:*

- 1 дүгээр анги нь “бэлтгэл” анги,
- 2, 3 дугаар анги нь “энгийн” анги
- 4, 5 дугаар анги нь “дунд” анги гэж нэрлэгддэг.

#### *Дунд сургууль буюу коллеж:*

6 дугаар анги нь (ангиуд нь 6-3 хүртэл эсрэг дугаарлагдана) зохицлын гэж нэрлэгдэх бөгөөд сурагчдыг хүндэвтэр хичээлүүдийг үзэхэд дасгах зорилготой бололтой. Тэр ангид математик, франц хэл, түүх болон ерөнхий боловсролын бусад хичээлийг үзнэ.

5, 4 дүгээр ангиуд “үндсэн” анги гэж нэрлэгдэх ба түүнд хими, физик, латин хэл, хоёр дахь гадаад хэл нэмэгдэж ордог байна.

3 дугаар ангийг “чиглүүлэгч” анги гэж нэрлэнэ. Ахлах сургуульд үргэлжлүүлэн үзэх ёстой тусгай хичээлүүдийг гүнзгийрүүлэн судална.

*Ахлах сургууль-лицей:*

Нэг, хоёр, төгсөх гэсэн гурван ангитай. Ахлах сургуулийн сургалт нь төрөлжсөн байдаг.

Мэргэжлийн лицей (lycee professionnel), мастерын туслахуудыг бэлтгэх төвүүд (CFA) байдаг. Түүнээс гадна ерөнхий боловсролын (general), технологийн (technologique) гэсэн хоёр төрлийн лицей байдаг байна. Мэргэжлийн лицей болон мастерын туслахын төвд суралцагчид нь их сургуульд орохгүй. Харин сүүлчийн хоёр лицей нь их сургуулийн бэлтгэл маягтай аж.

Ерөнхий боловсролын лицей нь дотроо нийгэм-эдийн засгийн (BAC-ES), байгалийн ухааны (BAC-S), хэлний (BAC-L) гэж төрөлжинө. Харин технологийн лицей нь эрдэм шинжилгээ-аж үйлдвэрийн (STI), үйлчилгээний (STT), лаборатори-шинжилгээний (STL), эмнэлэг-нийгмийн (SMS) хэмээн хуваагддаг байна.

Ахлах сургууль төгссөн хүмүүст бакалаврын диплом олгодог. Бакалаврын шалгалтад хоёр удаа унавал ахлах сургууль төгссөн гэсэн гэрчилгээ олгодог. Жилд төгсөгчдийн 20 орчим хувь нь ийм гэрчилгээ авдаг байна. Тэд их сургуульд орох эрхгүй байдаг. Бакалаврын зэрэг нь бүрэн бус дээд боловсролтой дүйцдэг учраас ахлах сургууль нь дунд болон дээд боловсролын дунд, тэдгээрийг холбосон маягтай ажээ.

Герман, Францын тогтолцоо нь:

- Хүүхдийг эртнээс мэргэжлийн, ядахдаа салбарын баримжаатай болгож байгаа, энэ нь сайн мэргэжилтэн болох нэг нөхцөл бололтой. Жишээ нь, лицейд гурван жил нийгэм-эдийн засгийн чиглэлээр суралцаад их сургуульд 4-5 жил гүнзгийрүүлэн судалж байгаа тохиолдолд илүү сайн мэргэжилтэн болох нь ойлгомжтой юм.
- Сурлагаар нь “шүүлтүүр” тавьж байгаа, улмаар дээд боловсролын чанарыг баталгаатай болгож байгаа

- Бүх шатны сургуулийн залгам холбоог хангаж байгаагаараа сайн талтай бололтой.

Дэлхийн бусад орнуудад ч ахлах сургуулиас эхлэн салбар, мэргэжлийн чиглэлээр ангиудыг төрөлжүүлдэг. Солонгост шинжлэх ухааны, хэлний, урлагийн гэх мэт ахлах сургуулиуд байдаг. Японд ахлах сургуулийн сурагчид мэргэжил сонгож, түүний нь дагуу үзэх хичээлүүдийг нь тодорхойлдог. Хятадад сурагчид ахлах сургуульд орохдоо “чиглэлийн” шалгалт өгч техник-мэргэжлийн юм уу академик чиглэлээр суралцах уу гэдгийг тодорхойлдог байна. Ахлах сургууль (дээд шат) төлбөртэй байдаг. Ахлах сургуульд орохын тулд шалгалт өгдөг, төлбөртэй байдаг зэрэг нь тухайн хүнд сонголт хийх шаардлагыг буй болгодог байна.

Дэлхийн нэлээд олон улсуудын боловсролын тогтолцоонд техникум юм уу түүнтэй адилтгах сургалтын байгууллага байна. Ийм байгууллагууд нь дээр үеийн нэршлээр яривал мастерын түвшний мэргэжилтнүүдийг бэлтгэдэг, одоо манайд дутаад байгаа мэргэжилтнүүд байх талтай юм.

#### **4. Шалгалт ба дүн**

Дэлхийн улс орнуудад сурагчдад дүн тавьдаг ба дүн тавьдаггүй гэсэн ялгаа байгаа боловч дүн тавьдаг нь дийлэнх байдаг шиг байна. Тэгэхдээ огт дүн тавьдаггүй сургууль гэж ямар ч оронд байхгүй. Дүн тавьдаггүй гэдэг нь бага ангид дүн тавьдаггүй, дүнг тавихдаа мэдлэгээс гадна хичээл зүтгэлийг нь үнэлдэг гэх мэт олон ялгаатай байдгийг хэлж байгаа юм. Финляндад бага ангид огт дүн тавьдаггүй. Дунд ахлах ангид сурагчдын амжилтыг үнэлдэг боловч өдөр бүр биш, томоохон амжилт юм уу хоцрогдолд л дүн тавина. Тэгэхдээ багшийн өрөөнд ганцаарчлан дүгнэдэг байна. Дүгнэдэг арга нь янз бүр байдаг нь ерөнхийгөөс нарийвчилсан байдалтай юм. 1-3 дугаар ангиудад дүн тавихгүй. 3-7 дугаар ангиудад дундаас онц хүртэл үгэн үнэлгээ өгдөг бол 8 дугаар ангиас эхлэн 10 оноогоор дүгнэдэг байна. Францад сурагчдын амжилтыг 20 оноогоор дүгнэдэг байна. Солонгост дүн тавьдаг боловч бага, дунд сургуульд анги дэвшихэд дүн нөлөөлдөггүй, анги дэвших нас нь болсон эсэхийг л харгалздаг аж. Тэгэхдээ дунд сургуулийн төгсөх

ангид сайн дүн авсан байх ёстой аж. Харин ахлах сургуулийн төгсөлтийн шалгалт “сунын” их хатуу байдаг учраас сурагчид суралцах бүхий л хугацаандаа түнд бэлдэж, албан ёсны хичээлээс гадна нэмэлт төлбөртэй сургалтад суудаг ажээ.

Дэлхийн улс орнуудын туршлагаас үзэхэд шалгалтыг аль нэг шатны сургалтыг төгсөх үед гол төлөв авч, ямар хэв маягийн сургуульд үргэлжлүүлэн суралцахыг нь чиглүүлдэг бололтой. Сингапурт бага сургууль төгсөхдөө Primary School Leaving Examination (PSLE) -г өгдөг ба энэ сургалт нь тусгай мэргэшсэн курсүүдээр явагддаг дунд сургуульд чухам алинд нь орохыг шийддэг байна. Дунд сургууль төгсөхдөө GCE ‘O’ Level гэсэн үндсэн гол шалгалтыг, мөн бусад шалгалтыг өгдөг ажээ. Төгсөх шалгалтаас гадна явцын шалгалтыг түүврийн аргаар хийдэг орон нэлээд байна. Чили улсад нэг үе нэг л ангиас тодорхой завсарлагатайгаар (5, 8 дугаар ангид гэх мэт) шалгалт авч сургуулийн ахиц, амжилтыг тодорхойлон сайн сургуулиудад багш нарын нэмэлт цалин болгож цалингийн нэмэлт сан олгодог байжээ.

### **5. Онцлог зарим зүйл**

Дэлхийн улс орнуудад сургалтад, ялангуяа бага ангиудад тоглоом ашиглах нь түгээмэл байна. Түүнчлэн ёс зүй, шашин, харилцаа, гар урлал, гэр аж ахуй зэрэг хичээлүүд байдаг нь сурагчдыг бага наснаас нь амьдралд бэлтгэж байгаа хэрэг юм. Япон, Хятад зэрэг оронд хичээлийн агуулгыг цээжлэхэд их анхаардаг байна. Энэ нь бурхны шашны сургалттай төстэй юм. Эхлээд хүний толгойд мэдээллийг нь хийж өгөөд, дараа нь эргэцүүлэн, дүн шинжилгээ хийж утга агуулгыг нь ойлгодог гэмээр юм уу. Ер нь дэлхийн улс орнуудын боловсролын тогтолцоо өөр өөрийн онцлогтой. Америк гэхэд сурагч хичээлээ сонгодог гэх мэтээр илүү чөлөөтэй байдаг. Турк болон бусад зарим оронд байгалийн ухааны хичээлүүдэд сайн сурагчдыг цуглуулан гүнзгийрүүлсэн сургалт явуулж, ирээдүйн эрдэм шинжилгээний ажилтнууд, их сургуулийн багш нарыг бэлтгэж байна.

Аль ч орны боловсролын тогтолцоо түүхэн нөхцөл байдлаар тодорхойлогдон төлөвшсөн байдаг учраас нэгд, ямар ч гажиггүй

шилдэг тогтолцоо гэж байхгүй, хоёрт, нэг орны боловсролын тогтолцоог нөгөө улсад хуулбарлах нь ихэнхдээ сөрөг үр дагавартай юм. Харин дэлхийн улс орнуудын боловсролын тогтолцооны сайн зүйлсийг өөриймшүүлэн авч өөрийн нөхцөлд нийцсэн өвөрмөц тогтолцоог буй болгох нь чухал юм. Тийм учраас энд бичсэн зүйлс нь хуулбарлах сайн туршлага биш, Монгол боловсролын тогтолцоог боловсронгуй болгохын тулд бодрол бясалгалыг өдөөхөд чиглэсэн болно.

Жич: Энэ материалыг Монгол Улсын боловсролын монгол тогтолцоо ямар байх, боловсролын бодлого ямар байх талаар яриа хэлэлцүүлэг өрнүүлэхийн тулд бэлтгэсэн болно.

## НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

Сүхээ, Ш. (1988). *Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлал, дэвшилийн зарим асуудал*.

Амархүү, О. (2022). *Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Төмөржав, М., & Хүрэлбаатар, Н. (2017). *Монгол малчны эрдэм ухааны дээж оривой*. Улаанбаатар: ТЭПЭ.

Инжаннаши, В. (2009). *Хөх судар*. Улаанбаатар: Мөнхийн үсэг групп.

Нацагдорж, Ш. (2018). *Эрдмийн бүтээлийн эмхэтгэл: Сурвалж судлалын бүтээлүүд VIII боть*. Улаанбаатар: ШУА-ийн Түүх археологийн хүрээлэн.

Гадаад хэлээр:

Петров, Д. (2023). Retrieved from KtoNaNovenkogo.ru: <https://ktonanovenkogo.ru/voprosy-i-otvety/obrazovanie-chto-eh-to-takoe-ego-funkcii-vidyurovni-stupeni.html>

Роджерс, Х. (2015). *Методики оценки качества работы учителей и их навыков*. Retrieved from worldbank: [https://www.worldbank.org/content/dam/Worldbank/Event/ECA/central-asia/1%20Tools%20for%20measuring%20teacher%20performance\\_Halsey%20Rogers\\_Bishkek-RUS.pdf](https://www.worldbank.org/content/dam/Worldbank/Event/ECA/central-asia/1%20Tools%20for%20measuring%20teacher%20performance_Halsey%20Rogers_Bishkek-RUS.pdf)

Гревцева, Г., & Циулина, М. (2014). Retrieved from Краткий словарь-справочникпо гражданско-патриотическому воспитанию Челябинск 2014: <https://dokumen.pub/2014-45-9785912831102.html>

*2022 Framework for Teaching: A Common Vision of Instructional Excellence*. (2022). Retrieved from The Danielson group: <https://danielsongroup.talentlms.com/catalog/info/id:398>

*Australian Professional Standards for Teachers*. (2011). Retrieved from Australian Institute for Teaching and School Leadership (: [https://www.aitsl.edu.au/docs/default-source/national-policy-framework/australian-professional-standards-for-teachers.pdf?sfvrsn=5800f33c\\_90](https://www.aitsl.edu.au/docs/default-source/national-policy-framework/australian-professional-standards-for-teachers.pdf?sfvrsn=5800f33c_90)

Daniel , F., J.R, L., Daniel, M., & Laura, S. (2003). *Evaluating Value-Added Models for Teacher Accountability*. Retrieved from [https://www.rand.org/content/dam/rand/pubs/monographs/2004/RAND\\_MG158.pdf](https://www.rand.org/content/dam/rand/pubs/monographs/2004/RAND_MG158.pdf)

*Encyclopædia Britannica*. (2023). Retrieved from <https://www.britannica.com/topic/education>

*Stanford Encyclopedia of Philosophy*. (2008). Retrieved from Stanford Encyclopedia of Philosophy: <https://plato.stanford.edu/Entries/Education-Philosophy/>

*Teachers' Standards Guidance for school leaders, school staff and governing bodies*. (2011). Retrieved from UK, Department for Education in: [https://assets.publishing.service.gov.uk/media/61b73d6c8fa8f50384489c9a/Teachers\\_Standards\\_Dec\\_2021.pdf](https://assets.publishing.service.gov.uk/media/61b73d6c8fa8f50384489c9a/Teachers_Standards_Dec_2021.pdf)

Timo Gnambs, & Barbara Hanfstingl. (2016). *The Decline of Academic Motivation during Adolescence: An Accelerated Longitudinal Cohort Analysis on the Effect of Psychological Need Satisfaction*. *Educational Psychology* 36(9): 1698-1712.

*Top Hat*. (2023). Retrieved from Glossary: <https://tophat.com/glossary/philosophy-of-education/>



## Аюурзанын ЦАНЖИД

1988 онд Москва хот дахь Нийгмийн Ухааны Академид дэд доктор, 2018 онд ШУА-д “Монголын төрт ёс” сэдвээр Улстөрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн. 1980-аад оны эхэн үеэс их, дээд сургуульд багшилж, эрдэм судлалын ажил эрхэлж ирсэн.

Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын албыг хашиж байсан. Монгол улсад улстөрийн шинжлэх ухааныг анхлан заасан багш, судлаач. Одоо Шинжлэх Ухааны Академийн Нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулган болон Философийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

### *Сүүлийн үеийн бүтээлээс:*

- ✧ Төр барихуй монгол ухаан. УБ., 2011
- ✧ Нууц товчооны нууцыг мөшгөхүй. УБ., 2016
- ✧ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эрх зүйн байдал, төвлөрлийг сааруулах нь. УБ., 2016
- ✧ Монголын төрт ёс. УБ., 2019
- ✧ Хос суртахуунт төр. УБ., 2019
- ✧ Хөдөөгийн хөгжлийн бодлого: онол, загвар, туршлага, сургамж. УБ., 2020
- ✧ Соёл, түүний ирээдүй. УБ., 2020
- ✧ Уугуул монгол соёл. УБ., 2022
- ✧ Бодлого судлал: хөглөн. УБ., 2023
- ✧ Шинэ нөхцөл дэх шинжлэх ухаан, технологи инновацын бодлого. УБ., 2023

